



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2018

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ

Монголбанкны
Ерөнхийлөгч Н.Баяртсайхан



Мэндчилгээ

Төв банкны нээлттэй, ил тод бөгөөд бие даасан, хариуцлагатай зарчмыг хэрэгжүүлэн Монголбанкнаас 2018 онд явуулсан үйл ажиллагаа, мөнгөний бодлого, Монгол Улсын эдийн засагт бий болсон ахиу өөрчлөлтийн тайланг Эрхэм Танд өргөн барьж байна.

2018 он бол эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жил болж өнгөрлөө. Төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадлаа. Мөнгө, зээлийн зохистой өсөлтийг хангаснаар инфляци зорилтот түвшинд буюу 8.1 хувьтай, харин эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 хувьтай гарсан нь сүүлийн 3 жилд өсөлт эрчимжиж, өндөр түвшинд хүрсэн үр дүн болж байна. Эдийн засагт гарсан нааштай, эерэг нөхцөл байдалд тулгуурлан зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2.5 нэгж хувиар буурав. Зээлийн хүүний бууралтын нөлөөгөөр банкуудын бизнесийн зориулалттай, төгрөгөөр олгосон зээл өнгөрсөн онуудтай харьцуулахад өндөр хувиар өслөө. Энэ нь бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байр, үйлдвэрлэл өсөхөд чухал түлхэц болов.

Сүүлийн 3 жилд Монголбанк өргөн хэмжээний шинэчлэл, реформуудыг хэрэгжүүлж, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргээ амжилттай биелүүлж байна. Тухайлбал, банк санхүүгийн системд хууль эрхзүйн шинэчлэлийг амжилттай хийж, Төв банкны хараат бус байдлыг баталгаажууллаа. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль зэрэг хуулийг 2018 онд шинэчлэн батлуулснаар Төв банкны сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь санхүүгийн салбарт тохиосон чухал үйл явдал байлаа. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, банкны салбарыг илүү эрүүл, чийрэг байлгах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монголбанк 2018 оноос нягтлан бодох бүртгэлийн олон улсын IX стандартын дагуу санхүүгийнхээ тайланг гаргаж, Төв банкны тайлагналын найдвартай, хариуцлагатай байдлыг бататгалаа. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн эд зүйлст анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэж, сан хөмрөгөө түүхийн хосгүй үнэт олдворуудаар баяжууллаа. Монголбанкны хуримтлагдсан алдагдал 3 их наяд төгрөгт хүрээд байсныг 1.2 их наяд төгрөгөөр бууруулж чадлаа. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг бүрдүүлж, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дээд хязгаарыг 3 сая төгрөг болгон нэмэгдүүлж, гүйлгээ дамжуулах хурдыг 3 дахин өсгөж, системийн тасралтгүй, найдвартай байдлыг бэхжүүллээ. Үүний зэрэгцээ төгрөгтэй адилтгах бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд анхны тусгай зөвшөөрлийг олгож, Финтекийн цаашдын хөгжлийг дэмжих суурийг тавилаа.

Монголбанк гадаад валютын нөөцийн дотоод гол эх үүсвэр болох үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгө, ханшийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлснээр гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг сүүлийн 2 жилд 3.5 дахин өсгөн 3.6 тэрбум ам.доллар (импортын 8 орчим сарын хэрэгцээг хангах түвшин)-т хүргэн нэмэгдүүллээ. Монголбанкны үнэт металлын худалдан авалт 2018 оны эцэст 22 тоннд буюу түүхэн дээд хэмжээнд хүрч гадаад валютын нөөцийг 740 сая ам.доллараар өсгөв. Энэ нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгт итгэх итгэлийг сэргээх, улсын эрсдэлийг бууруулж, улсын зээлжих зэрэглэл нэмэгдэхэд нөлөөлсөн үндсэн хүчин зүйлсийн нэг байв. Ийнхүү макро эдийн засгийн тогтвортой байдал, сэргэлт хангагдаж, улсын зээлжих зэрэглэл нэмэгдсэн нь Засгийн газар, Хөгжлийн банк, Монголын Ипотекийн Корпораци болон бусад хувийн секторын гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх хүү бага байх, валютын дотогшлох урсгал нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлэв. Монголбанкны бодлого, арга хэмжээ нь эдийн засгийн дархлааг хангах, эмзэг байдлыг бууруулах, нөгөө талдаа ханшийн хэт өндөр хэлбэлзлийг бий болгохгүй байх энэ зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэж байна.

2018 онд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн системийн дархлааг сайжруулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн реформыг үргэлжлүүлэв. Банкны салбарт активын чанарын үнэлгээг хийлгэж, үр дүнг банкуудын тайланд тусгах, чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, банкны салбарын тогтвортой байдлыг хангах буюу дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажлуудад төвлөрч ажиллаа. Эрүүл банкны салбартай байх нь эрүүл санхүүгийн салбар бий болгож, улмаар эдийн засгийн эрүүл суурь бүрдүүлдэг тул Монголбанкнаас 2019 онд банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг олон улсын сайн жишигт нийцүүлэх зорилготой “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанк бүх талаар дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд тохирсон төв банкны дотоод цэвэр активын дээд хязгаар, гадаад цэвэр активын доод хязгаарын тоон зорилтууд болон урьдчилан авах хэмжээнүүдийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн хөтөлбөрийн үнэлгээг амжилттай хийлгэж ирлээ. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь манай эдийн засгийн хэтийн төлөвт стратегийн чухал ач холбогдолтой. Тэр дундаа, Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үргэлжлүүлэн хангахад ОУВС болон бусад доноруудын тусламж дэмжлэг цаашид ч онцгой шаардлагатай юм. Иймд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгахын төлөө Монголбанк үргэлжлүүлэн зүтгэж ажиллах болно.

Монголбанк эдийн засагт үүссэн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тэдгээрийн үндэслэлийг олон нийтэд нээлттэй ил тод зарчмаар тайлбарлаж, тайлагнахад онцгой анхаарал хандуулж байна. 2018 онд “Эдийн засгийн бодлогын чуулган”-ыг санаачлан зохион байгуулж, “Улаанбаатарын зөвшилцөл”, “Зээлийн хүүг бууруулах стратеги”, “Монгол улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд”, “Глобал орчин: Эдийн засгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд” зэрэг хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээг зохион байгууллаа. Олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг боловсролыг дээшлүүлэх, Төв банкны нийгмийн хариуцлагатай байдлын хүрээнд зорилтот бүлгүүдэд чиглэсэн бүсийн зөвлөгөөн, аян, лекц сургалтуудыг нийслэл болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэв. Түүнчлэн, дэлхийн төв банкуудын шилдэг туршлага, жишгийн дагуу Монголбанк нь Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг шинээр үүсгэн байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлээд байна.

Монголбанк санхүү, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдал, ирээдүйн өсөлт хөгжлийн чухал тулгуур болсон реформ, шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэн ажиллах болно.


Сайн, сайхан үйлс дэлгэрэх болтугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ (2018)



ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 9

1.1 Инфляци	9
1.2 Бодит сектор	10
1.3 Гадаад сектор	14
1.4 Мөнгө, санхүүгийн сектор	18
1.5 Монгол Улсын нэгдсэн төсөв	31

2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 33

2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн.....	33
2.2 Банкны салбарын тогтвортой байдлыг хангах бодлогын хэрэгжилт.....	36
2.3 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага.....	37
2.4 Монгол Улсын Үндэсний төлбөрийн систем	38
2.5 Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл	41
2.6 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр	44

3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 51

3.1 Төв банкны үнэт цаас	51
3.2 Төв банкны санхүүжилт	52
3.3 Засгийн газрын үнэт цаас	53
3.4 Гадаад валютын худалдаа.....	54
3.5 Дотоод зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа.....	55

4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН 57

4.1 Монголбанкны бүтэц, шинэчлэлийн үйл ажиллагаа	57
4.2 Гадаад харилцаа	58
4.3 Олон нийттэй харилцах харилцаа	59
4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ.....	60
4.5 Дотоод аудит	63
4.6 Эрсдэлийн удирдлага.....	64
4.7 Бэлэн мөнгөний хангалт	66
4.8 Мэдээллийн технологи	68
4.9 Монгол банкнаас 2018 онд баталсан баримт бичгүүд.....	69

5. АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 73

СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТ (ХУРААНГУЙ) 185

1.1 ИНФЛЯЦИ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг Төв банк 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулах зорилт тусгасан. Инфляци оны туршид 6-7 хувийн орчимд тогтвортой байж, оны эцэст 8.1 хувь байв. Эдийн засгийн сэргэлттэй уялдаад инфляци 2017 оноос алгуур нэмэгдэхийн зэрэгцээ нийлүүлэлтийн шинж чанартай үнийн өсөлт зарим сард инфляци хэлбэлзэхэд ихээхэн нөлөөлөв (Зураг 1).

2017 оны эхний хагаст импортын автомашины татвар нэмэгдсэн, намар нь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж их хэмжээний ургац алдсан зэрэг нь 2018 оны 7 сар хүртэл инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлээ. Түүнчлэн, импортын архи, тамхины онцгой албан татвар¹ нэмэгдсэнээр үнэд үзүүлэх нөлөө хадгалагдаж байна. Харин тайлант оны 2-р хагаст хатуу түлш, мах, шатахуун зэрэг бүтээгдэхүүний үнийн өсөлт жилийн инфляцийн тэн хагасыг бүрдүүлэв. Тухайлбал, Улаанбаатар хотын хувьд тооцсон жилийн инфляцийн 5.4 нэгж хувийг хатуу түлш, мах, шатахуун гэсэн 3 төрлийн барааны үнийн өсөлт бүрдүүлжээ (Хүснэгт 1).

Зураг 1. Улсын сарын болон жилийн инфляци



Хүснэгт 1. Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа


Нэр	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцид эзлэх хувь
Хатуу түлш	0.03	64.6%	2.36%
Мах	0.10	22.5%	1.68%
Шатахуун	0.06	24.8%	1.32%
Бүх төрлийн хувцас	0.09	7.4%	0.63%
Эм тариа	0.03	13.7%	0.52%
Согтууруулах ундаа	0.06	8.4%	0.46%
Нийт	0.37		6.97%

- **Хатуу түлшний үнэ** улирлын шинж чанартайгаар өөрчлөгдөж 8-11 сард өсөөд, 12-р сараас эргэн буурдаг боловч 2018 оны хувьд 1-3, 9-12 сард үнэ өссөнөөр жилийн өсөлт нь 64.6 хувьд хүрч, оны эцэст инфляцийн 2.4 нэгж хувийг бүрдүүлэв.
- **Махны үнэ** 6-р сарын дундаас буурч, 12-р сарын дундаас эргэн өсөх хандлагатай байдаг боловч тайлант жилийн 10-р сараас эхлэн үнэ өссөнөөр жилийн инфляцийн 1.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. 2018 онд дулааны аргаар боловсруулсан махны экспортын хэмжээ өмнөх оноос 8.3 дахин нэмэгдсэн, махны тээврийн зардал өссөн зэргээс дотоодын махны үнэ оны эхнээс 2000 орчим төгрөгөөр нэмэгдсэн нь ийнхүү үнийн өсөлтөд хүчтэй нөлөөллөө.
- **Шатахууны үнэ** дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлтийг дагаад тайлант оны 2-р хагаст өсч, оны эхнээс 400 орчим төгрөгөөр нэмэгдсэнээр инфляцид үзүүлэх нөлөө нь хурдтай нэмэгдэж байв. Харин 12-р сард Аи-92 шатахууны үнэ 100 төгрөгөөр буурснаар дотоодын шатахууны үнэ 2.4 хувиар буурч, инфляцийн 1.3 нэгж хувийг бүрдүүлэв.


¹ 2018 оны 1 дүгээр сараас импортын архи, тамхины онцгой албан татвар 10 хувиар нэмэгдсэн. 2019 онд дахин 5 хувиар нэмэгдэнэ.

- Хүнс, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбарын үйлдвэрлэл 15.7 хувиар тэлж, өсөлтөд 1 нэгж хувийн нэмэлт нөлөө үзүүлжээ.
- Өрхийн хэрэглээ нэмэгдсэн, банк санхүүгийн зээл, хадгаламжийн үйлчилгээ өссөн зэргээс шалтгаалж үйлчилгээний салбарын өсөлт 6.1 хувьд хүрсэн нь эдийн засгийн өсөлтөд эерэг 1.3 нэгж хувийн нөлөө үзүүллээ.
- Хүнсэнд хэрэглэсэн малын тоо өсч, газар тариалангийн салбарын үйлдвэрлэл 2018 онд эрчимжсэнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар 4.5 хувиар өсч, өсөлтийг 0.6 нэгж хувиар тэтгэсэн байна.
- Худалдааны эргэлт нэмэгдсэнээр тээврийн салбарын үйлдвэрлэл 6.7 хувиар өсч, өсөлтөд 0.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв.
- Эдийн засгийн идэвхжилийг дагаад эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 8.2 хувиар өссөн нь өсөлтийг 0.1 нэгж хувиар өсгөв.
- Иргэдийн орлого, хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор мэдээлэл холбооны салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд 0.1 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүллээ.
- Эдийн засгийн идэвхжилийг дагаад хөрөнгө оруулалтын болон хэрэглээний шинжтэй импорт өссөнөөр бүтээгдэхүүний цэвэр татвар 2018 онд 20.1 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд 2 нэгж хувийн хувь нэмэр оруулжээ.
- Орон сууцны эрэлт бага, барилгын их засварын ажил буурсантай холбоотойгоор барилгын салбар 2018 онд 5 хувиар агшиж өсөлтөд -0.2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлээ.

Зураг 5. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт



Зураг 6. Үйлчилгээний салбаруудын өсөлт




Эх сурвалж: YCX

Ажил эрхлэлт


Хөдөлмөрийн насны хүн ам 2018 оны дунджаар өмнөх оноос 0.3 хувиар өсч, 2,227 мянгад хүрлээ. Үүн дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам өмнөх оноос 0.1 хувиар, идэвхгүй хүн ам 0.6 хувиар нэмэгдэн, харгалзан 1,359 мянга болон 868 мянга болсон байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын өсөлт идэвхтэй хүн амын өсөлтөөс давсан тул ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурч 61.0 хувьд хүрэв (Зураг 7).

Эдийн засгийн идэвхтэй хүн ам дотор нийт ажиллагчид 2018 онд өмнөх оноос 1.2 хувиар өсч 1,253 мянгад, нийт ажилгүй иргэд 11.3 хувиар буурч 106 мянгад тус тус хүрчээ. Ажиллагчид бага зэрэг нэмэгдсэнээс гадна ажилгүй иргэд хурдацтай буурсан тул ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 1.0 нэгж хувиар буурч 7.8 хувь болов (Зураг 8).

Зураг 7. Ажиллах хүчний оролцооны түвшин



Зураг 8. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: YCX


Нийт ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны гол салбаруудаар авч үзвэл 2018 онд 450 мянга буюу 35.9 хувь нь үйлчилгээний салбарт, 334 мянга буюу 26.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 258 мянга буюу 20.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 211 мянга буюу 16.9 хувь нь худалдааны салбарт тус тус ангилагдаж байна (Зураг 9). Эдгээрээс хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид өмнөх оноос 6.3 хувиар буурсан бол аж үйлдвэр, худалдаа болон үйлчилгээний салбарт ажиллагчид 8.5 хувь, 3.3 хувь, 2.3 хувиар тус тус нэмэгджээ.

Нийт ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр ангилан авч үзвэл 640 мянга буюу 51.0 хувь нь цалин хөлстэй ажиллагчид, 297 мянга буюу 23.7 хувь нь мал аж ахуй эрхлэгчид, 252 мянга буюу 20.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 45 мянга буюу 3.6 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчид, 18 мянга буюу 1.5 хувь нь ажил олгогчид байв (Зураг 10). Эдгээрээс цалин хөлстэй ажиллагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид өмнөх оноос 3.7 хувь, 1.7 хувиар тус тус нэмэгдсэн бол мал аж ахуй эрхлэгчид 8.1 хувиар цөөрчээ.

Зураг 9. Ажиллагчдын тоо, эдийн засгийн салбараар



Зураг 10. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр




Эх сурвалж: YCX

1.3 ГАДААД СЕКТОР


Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн статистикийн 2018 оны гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 1,814 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,801 сая ам.долларын ашигтай, статистикийн алдаа ба орхигдуулга -127 сая ам.доллар гарснаар нийт тэнцэл 141 сая ам.долларын алдагдалтай гарч, ашгийн хэмжээ 2017 оноос 1,601 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 11. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл




Зураг 12. Урсгал ба Хөрөнгийн дансны тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 2018 онд өмнөх оноос 68 хувиар буюу 737 сая ам.доллараар өссөн бөгөөд үүнд барааны дансны ашиг 54 хувиар буюу 804 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Зураг 13. Санхүүгийн дансны тэнцлийн бүтэц



Зураг 14. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц



* 2016 оны II-р улиралд “Оюу Толгой” ХХК-ийн 4.3 тэрбум ам.долларын арилжааны зээл авч 4.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулагчдын зээлийг төлснийг дээрх зургуудад харуулаагүй болно.

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцлийн ашиг 2018 онд өмнөх оноос 31 хувиар буюу 799 сая ам.доллараар буурч, 1,801 сая ам.долларт хүрсэн бөгөөд төлбөрийн тэнцлийн статистикийг боловсруулах 6-р аргачлалын нэр томьёоллоор Монгол Улс гадаад эх үүсвэрээс цэвэр дүнгээр зээллэгтэй (өр төлбөртэй) гарчээ.

Барааны гадаад худалдаа²

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 2018 онд 1,137 сая ам.долларын ашигтай гарч сүүлийн таван жил дараалан ашигтай гарлаа.

Хүснэгт 2. Барааны гадаад худалдааны гүйцэтгэл (сая ам.доллар)


Төрөл	2016	2017	2018	Өөрчлөлт (18'/17')	
				Мөнгөн дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,351	22%
Экспорт	4,916	6,201	7,012	811	13%
Импорт	3,358	4,335	5,875	1,540	36%
Тэнцэл	1,558	1,865	1,137	-728	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт: 2018 онд экспорт 13 хувиар буюу 811 сая ам.доллараар өссөн нь чулуун нүүрс 530 сая ам.доллараар өссөнөөс голлон шалтгаалжээ. Энэхүү өсөлт нь тус бүтээгдэхүүний экспортын үнэ болон биет хэмжээний өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Алтны үнэ: Алтны үнийн индекс 2018 онд 1 хувиар буурсан нь АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ 12-р сарын хурлаараа дахин нэмэгдүүлж, улмаар ам.долларын ханшийн чангарсан зэрэг нь алтны эрэлтийг сааруулж үнэ буурахад голлон нөлөөлөв.

Зэсийн үнэ: Лондонгийн металлын бирж дэх цэвэршүүлсэн зэсийн үнэ 2018 оны 4 дүгээр улиралд өмнөх оноос 11 хувиар буурчээ. Энэ нь АНУ, БНХАУ-ын худалдааны зөрчилдөөн, Хятадын эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл сүүлийн 28 жилийн хугацаан дахь хамгийн бага буюу 6.6 хувьд хүрсэн, эрчим хүч, барилгын салбарт ашиглагддаг металлын орц буурсан, зэсийн томоохон нийлүүлэгч Чили дэх уурхайн ажилчдын хөдөлмөрийн гэрээ байгуулах хэлэлцээр эцэслэгдсэн болон Перуд 2021 он гэхэд 18 шинэ уурхай үйл ажиллагаа явуулж эхлэх хүлээлтээс шалтгаалж зэсийн нийлүүлэлт өссөнтэй холбоотой юм.

Зураг 15. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2011/1=1.0)

Эх сурвалж: Блумберг

Коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ: БНХАУ нүүрсний дотоодын олборлолтоо бууруулсан, гангийн үйлдвэрлэл нэмэгдсэнээс шалтгаалан Монгол улсаас нийлүүлж буй бүх төрлийн нүүрсний хилийн үнэ, төмрийн хүдрийн үнийн индекс 2018 онд эрчимтэй өсч эхэлсэн. Мөн хөгжиж буй орнуудын өсөлт удааширч байгаагаас шалтгаалан дэлхийн зах зээл дэх нүүрсний үнэ өсч манай улсын нүүрсний үнийн индекс 2018 онд өмнөх оноос 5 хувиар өссөн үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Харин төмрийн хүдрийн үнийн индекс өмнөх оны үзүүлэлтээс 10 хувиар өсчээ.

Түүхий нефтийн үнэ: Боловсруулаагүй нефтийн үнийн индекс 2018 онд 12 хувиар өссөн нь АНУ-ын олборлолт нэмэгдсэн, ОПЕК-ийн гишүүн орнууд зөвшилцөлд хүрсэн хэдий ч АНУ-аас Ираны нефтийн экспортод тавьсан хориг арга хэмжээ тодорхойгүй хэвээр, Венесуэлийн үйлдвэрлэл үргэлжлэн буурах төлөв, ОПЕК-ийн орнуудын нөөцийн түвшин доогуур хэвээр байгаа зэрэг нь зах зээлд нийлүүлэлтийн сөрөг шок үүсч болзошгүй тул үнийн өсөлт хадгалагдсан хэвээр байна.

² ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэсэн тоон мэдээлэл бөгөөд аргачлалын ялгаатай байдлаас шалтгаалан Төлбөрийн тэнцлийн статистикаас ялгаатай болно.

Хүснэгт 3. Экспорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2017			2018			Өөрчлөлт	
	Тоо/ хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт
1. Уул уурхай		5,519	89%		6,200	88%	681	12%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,447	1,613	26%	1,437	2,012	29%	399	25%
1.2. Чулуун нүүрс	32,990	2,256	36%	35,758	2,786	40%	530	23%
1.3. Боловсруулаагүй нефть	7,514	374	6%	6,190	392	6%	18	5%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6,258	310	5%	7,449	342	5%	32	10%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	14,548	595	10%	3,432	144	2%	(451)	-76%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	118	181	3%	124	198	3%	17	9%
1.7. Жонш, лейцит, нефелинт	319	84	1%	555	190	3%	106	126%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	37	1%	6	50	1%	13	34%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	8	0%	1	9	0%	1	9%
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	1	0%	(0)	-24%
1.11. Бусад	440	58	1%	536	75	1%	17	
2. Мал аж, ахуй	363	379	6%	412	477	7%	98	26%
2.1. Амьд мал, малын мах	29	56	1%	41	87	1%	32	57%
2.2. Арьс, шир	306	23	0%	342	17	0%	(6)	-26%
2.3. Малын өлөн гэдэс	0	6	0%	1	9	0%	2	35%
2.4. Ноолуур	8	262	4%	9	333	5%	70	27%
2.5. Ноос, бусад үс, хялгас	19	29	0%	15	28	0%	(1)	-3%
2.6. Бусад	1	2	0%	4	3	0%	1	33%
3. Газар тариалан	153	14	0%	56	15	0%	2	12%
4. Аж үйлдвэрлэл	360	289	5%	234	319	5%	30	10%
4.1. Хүнс	19	77	1%	36	92	1%	14	19%
4.2. Ноолууран эдлэл	1	32	1%	1	35	0%	3	8%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	3	16	0%	4	25	0%	9	x5
4.4. Уул уурхай	35	110	2%	61	107	2%	(2)	-2%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	3	0%	2	212%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	45	1%	3	52	1%	6	14%
4.7. Бусад	300	7	0%	129	5	0%	(2)	-25%
5. Бусад	1	1	0%	1	1	0%	0	3%
Нийт дүн		6,201			7,012		811	13%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт: 2018 оны импорт өнгөрсөн оны үзүүлэлтээс 36 хувиар буюу 1,540 сая ам.доллараар өсөхөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Монгол Улсад орох хөрөнгө оруулалтын өсөлт, компаниудын үйл ажиллагааны сэргэлттэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын шинжтэй бүтээгдэхүүний импорт 41 хувиар буюу 694 сая ам.доллараар, үүнд: машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 40 хувиар, барилгын материалын импорт 47 хувиар өсчээ.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 323 сая ам.доллараар өссөн нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт болон манай улсад орж буй хөрөнгө оруулалтын өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 4. Импорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2017		2018		Өөрчлөлт	
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,285	30%	1,643	28%	358	28%
Түргэн эдэлгээтэй	733	17%	864	15%	131	18%
Хүнс	510	12%	596	10%	86	17%
Эм, тариа	95	2%	119	2%	24	26%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	128	3%	149	3%	21	17%
Удаан эдэлгээтэй	553	13%	779	13%	226	41%
Гутал, хувцас, цунх	64	1%	74	1%	10	16%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	94	2%	120	2%	27	28%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	328	8%	499	9%	171	52%
Бусад удаан эдэлгээтэй бараа	66	2%	85	1%	18	27%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,702	39%	2,396	41%	694	41%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,077	25%	1,512	26%	435	40%
Барилгын материал	441	10%	648	11%	207	47%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	183	4%	236	4%	53	29%
Аж үйлдвэрлэлийн орц	552	13%	717	12%	165	30%
Нефтийн бүтээгдэхүүн	789	18%	1,112	19%	323	41%
Дизель түнш	428	10%	577	10%	149	35%
АИ-92, АИ-95	211	5%	264	4%	53	25%
А-80 болон бусад	150	3%	272	5%	122	81%
Бусад	7	0%	7	0%	(1)	-11%
Нийт дүн	4,335		5,875		1,540	36%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Харин хэрэглээний барааны импортын хувьд өнгөрсөн оны хэмжээнээс 358 сая ам.доллараар өссөн нь хүнсний бүтээгдэхүүний импорт 86 сая ам.доллараар, авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 171 сая ам.доллараар өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2018 онд өмнөх оноос 20 хувиар өсч 1,449 сая ам.долларт хүрсэн.

Үйлчилгээний дансны алдагдал өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал 88 хувиар өсч 258 сая ам.доллар, импортын бүтээгдэхүүний өсөлттэй холбоотойгоор тээврийн үйлчилгээний алдагдал 51 хувиар өсч 428 сая ам.доллар болсонтой холбоотой байна.

Аялал жуулчлалын үйлчилгээний зардлын өсөлтийн хувьд Монголбанк 2018 онд түүвэр судалгааг шинээр хийсэнтэй холбоотойгоор статистикийн хамрах хүрээ нэмэгдсэн нь нөлөөлөв.

Хүснэгт 5. Үйлчилгээний гадаад худалдаа (сая ам.доллар)

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2016	2017	2018	Өөрчлөлт (18/17')	
				Дүн	%
1. Тээвэр	-176	-284	-428	145	51%
2. Аялал жуулчлал	-166	-137	-258	121	88%
3. Барилга, барилгын ажил үйлчилгээ	-137	-218	-147	-72	-33%
4. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-15	-20	-21	0	1%
5. Санхүүгийн үйлчилгээ	-205	-24	-62	38	159%
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	-23	-15	-15	0	0%
7. Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-69	-48	-76	28	58%
8. Бизнесийн бусад үйлчилгээ	-529	-435	-415	-20	-5%
13. Бусад үйлчилгээ	-18	-31	-27	-4	-12%
Нийт үйлчилгээ	-1338	-1212	-1449	236	20%

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 оны эцэст -33,374 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4 хувиар буюу 1,344 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 6,204 сая ам.доллар, үүний 57 хувийг гадаад валютын улсын нөөц, 30 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 5 хувийг багцын хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн буюу пассив 39,578 сая ам.доллар, үүний 50 хувийг шууд хөрөнгө оруулалтын пассив, 37 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12 хувийг багцын хөрөнгө оруулалт бүрдүүлжээ.

Тэгвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын 54 хувь буюу 10,759 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 46 хувь буюу 9,197 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 6. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2018 оны эцэст (сая ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		6,204	Б. ГАДААД ПАССИВ		39,578
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	521		1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	19,956	
2. Багцын хөрөнгө оруулалт	294		2. Багцын хөрөнгө оруулалт	4,884	
3. Санхүүгийн дериватив	0		3. Санхүүгийн дериватив	1	
4. Бусад хөрөнгө оруулалт	1,846		4. Бусад хөрөнгө оруулалт	14,738	
5. Нөөц актив	3,542				
			В. ПОЗИЦИ	-33,374	

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позицийн жилийн өсөлтийг дансны гүйцэтгэл тус бүрээр тайлбарлавал:

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позици 1,909 сая ам.доллараар өсч, багцын хөрөнгө оруулалтын богино позици 78 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслийн богино позици 1 сая ам.доллараар буурав.
- Бусад хөрөнгө оруулалтын богино позици 0.4 хувиар буюу 46 сая ам.доллараар өсөв.
- Гадаад валютын улсын нөөц 18 хувиар буюу 534 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Хүснэгт 7. Гадаад хөрөнгө оруулалтын позицийн өөрчлөлт (сая ам.доллар)

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	Өөрчлөлт (18'/17')	
				Дүн	%
Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позици	-15,822	-17,525	-19,434	1,909	11%
Багцын хөрөнгө оруулалтын позици	-3,351	-4,668	-4,590	-78	-2%
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позици	-15	0	-1	1	-269%
Бусад хөрөнгө оруулалтын позици	-11,458	-12,846	-12,892	46	0%
Гадаад валютын улсын нөөц	1,296	3,008	3,542	-534	18%
Нийт позици	-29,350	-32,031	-33,374	1,344	4%

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 28,743 сая ам.доллар болж, өмнөх оноос 5 хувиар буюу 1,330 сая ам.доллараар өсөв. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын гадаад эх үүсвэрээс авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл ба өрийн бичгийн үлдэгдэл 2 хувиар буюу 130 сая ам.доллараар буурав.
- Төвбанкны гадаад өр харьцангуй тогтвортой буюу харилцах, хадгаламжийн дансны өсөлт болон ОУВС-гийн хөтөлбөрийн зээлийн ашиглалт зэргээс шалтгаалан 5 сая ам.доллараар өсөв.
- Хувийн салбарын гадаад өрийн өсөлтийн хувьд компани хоорондын зээллэг голлон тайлбарлаж байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн толгой компаниасаа авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн онтой харьцуулахад 21 хувиар буюу 1,624 сая ам.доллараар өсөв.

Хүснэгт 8. Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2016	2017	2018	Өөрчлөлт (18/17')	
				Дүн	%
Нийт гадаад өр	24,625	27,413	28,743	1,330	5%
I. Засгийн газар	4,869	7,317	7,183	-135	-2%
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	41%	66%	55%	-10%	-16%
II. Төв банк	1,791	2,025	2,030	5	0%
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,417	2,309	2,220	-89	-4%
Богино хугацаат	469	411	757	346	84%
Урт хугацаат	1,948	1,898	1,463	-435	-23%
IV. Бусад сектор	8,121	8,189	8,114	-76	-1%
Богино хугацаат	394	599	597	-2	0%
Урт хугацаат	7,727	7,591	7,517	-73	-1%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,426	7,572	9,197	1,624	21%

Эх сурвалж: ЗГ-ын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав.

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013-2016 онд 29-41 хувийн хооронд тогтвортой түвшинд байсан бол 2017 онд 66 хувь болж өсөөд байсан ч 2018 оны эцсээр 55 хувь болж буурсан үзүүлэлттэй байна (олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан).


1.4 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох M1 мөнгө болон бусад харилцах хадгаламж 2018 онд нэмэгдсэнээр M2 мөнгө өмнөх жилээс 22.8 хувиар өсч 19.5 их наяд төгрөгт хүрэв. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл 2018 оны эцэст 24.3 хувиар нэмэгдэж (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулснаар) 20.1 их наяд төгрөг болжээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд иргэдийн төгрөгийн хадгаламж 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Мөн байгууллагын төгрөгийн харилцах 0.8 их наяд төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 0.5 их наяд төгрөгөөр, харилцах 0.4 их наяд төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 58.8 тэрбум төгрөгөөр тус тус 2018 онд нэмэгдсэн байна.


Зураг 16. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн: актив, пассив



Эх үүсвэр: Монголбанк

Дотоод цэвэр актив (ДЦА) өмнөх оноос 12.4 хувиар өссөн ба М2 мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь 2018 оны эцсийн байдлаар 98.8 хувь байна. Харин гадаад цэвэр актив (ГЦА) өмнөх оны мөн үеэс 1.2 дахин (118.5 хувиар) буюу 1.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээгээр нэмэгдсэн. Үүнд гадаад албан нөөцийн хэмжээ 17.7 хувиар өсч 3.5 тэрбум долларт хүрсэн нь нөлөөлсөн байна.

Зураг 17. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц: актив, пассив




Эх үүсвэр: Монголбанк

Санхүүгийн байгууллагуудын³ зээлийн үлдэгдэл 2018 оны эцэст 21.9 хувиар өсч 22.6 их наяд төгрөгт хүрэв. Энэхүү өсөлтөд хадгаламжийн байгууллагуудын зээлийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 75.3 хувь нь хадгаламжийн байгууллагаас олгосон зээл, 12.9 хувь нь “МИК ОССК”-ийн эзэмшиж буй зээл, 11.8 хувь нь Хөгжлийн банкнаас олгосон зээл тус тус ногдож байна.


³ Санхүүгийн байгууллагууд нь банк, хадгаламж, зээлийн хоршоо, МИК, Хөгжлийн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас бүрддэг.

Зураг 18. Санхүүгийн байгууллагуудын зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүн



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 19. Банкуудын зээлийн үлдэгдлийн өсөлт, салбараар (улирлаар)



Эх үүсвэр: Монголбанк

Банкуудын зээлийн үлдэгдэл 2018 онд өмнөх оноос 26.5 хувиар өсч 17.1 их наяд төгрөгт хүрэв. Нийт зээлийг эдийн засгийн салбараар нь задлан үзвэл хэрэглээний зээл 53.4 хувиар, худалдааны салбарын зээл 29.3 хувиар, уул уурхайн салбарын зээл 19.7 хувиар, барилгын салбарын зээл 19.5 хувиар тус тус өссөн бол үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл 4.3 хувиар буурчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 84 хувь нь төгрөгийн, 16 хувь нь гадаад валютаар олгогдсон зээл байна. Харин банкуудын 2018 онд шинээр олгосон зээл өмнөх оныхоос 55.8 хувиар өссөн бөгөөд хэрэглээний зээл энэхүү өсөлтийн 20.4 нэгж хувийг, худалдааны салбарт олгосон зээл 14.8 нэгж хувийг эзэлж байна.

Банкуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2018 онд өмнөх жилээс 1.9 нэгж хувиар өсч 10.4 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 1.2 нэгж хувиар буурч 4.9 хувьд хүрлээ.


Банкны салбар

Банкны салбарт тайлант оны эцсийн байдлаар нийт 14 банк, 1,512 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.1 саяд, нийт зээлдэгчдийн тоо 1.2 саяд хүрлээ.

Активын бүтэц, өөрчлөлт

Нийт активыг бүтцээр нь авч үзвэл 48.2 хувь нь зээл, 20.7 хувь нь мөнгөн хөрөнгө, 13.6 хувь нь Төв банкны үнэт цаас, 4.4 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 13.0 хувь нь бусад төрлийн хөрөнгө эзэлж байна. Банкны салбарын нийт актив 2018 оны эцэст 33.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.3 их наяд төгрөгөөр буюу 14.9 хувиар өслөө. Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөг, мөнгөн хөрөнгө нь 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь нийт активын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлсэн байна. Засгийн газрын болон Төв банкны үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт дүнгээрээ төдийлөн өөрчлөгдөөгүй хэдий ч Засгийн газраас хэрэгжүүлж буй өрийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогын нөлөөгөөр Засгийн газрын үнэт цаасны хэмжээ 1.1 их наяд төгрөгөөр буурч, харин Төв банкны үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. (Зураг 20)

Зураг 20. Активын бүтэц, өсөлт



Эх сурвалж: Монголбанк

*-Зээлийн эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн хэмжээ

Зээлийн бүтэц

Банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцсийн байдлаар 17.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.5 хувиар өсчээ. Зээлийн өсөлтийн 17.1 нэгж хувийг иргэдэд олгосон зээл, 8.5 нэгж хувийг хувийн байгууллагад олгосон зээл бүрдүүлж байна. Хэрэглээний зээлийг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн хязгаарласан Монголбанкны шийдвэрийн нөлөөгөөр хэрэглээний зээл олголт 2018 оны дөрөвдүгээр улиралд эрчимжсэн хандлага ажиглагдсан. Иргэдийн хэрэглээний зориулалттай зээл (ипотекийн зээлээс бусад) нь банкуудын нийт зээлийн үлдэгдлийн 32.6 хувийг эзэлж байгаа бөгөөд жилийн өсөлтийн 13.9 нэгж хувийг бүрдүүлж байна. Энэ нь зээлээр санхүүжүүлсэн хэрэглээ, худалдан авалт түгээмэл байгааг харуулж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 84.0 хувийг төгрөгөөр, 16.0 хувийг гадаад валютаар олгосон зээл бүрдүүлж байна.

Зээлийн бүтцийг эдийн засгийн голлох салбараар нь авч үзвэл банкны салбарын нийт зээлийн 14.1 хувийг бөөний болон жижиг худалдааны салбарт, 10.7 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарт, 8.8 хувийг барилгын салбарт, 8.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7.2 хувийг уул уурхайн салбарт олгосон зээл тус тус эзэлж байна.

Зураг 21. Зээлийн бүтэц, эдийн засгийн салбараар (эзлэх хувь, үлдэгдэл)




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн чанар⁴

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын нийт зээлийн 84.7 хувь буюу 14.5 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4.9 хувь буюу 843.4 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 10.4 хувь буюу 1.8 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагджээ. (Зураг 3, 4). Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны эцсээс 54.8 хувиар буюу 629.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, банкны системийн хэмжээнд чанаргүй зээлийн харьцаа 10.4 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, дэлхийн голлох валютуудын ханшийн өөрчлөлтөөр дамжин дотоодийн эдийн засагт цаашлаад бизнесийн орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл гадаад орчноос нөлөөлсөн бол эдийн засгийн голлох салбаруудын мөнгөн урсгал буурсан, төгрөгийн ханшийн сулрал, банкуудын эрсдэлийн удирдлагын сул байдал, зээлийн төвлөрөл зэрэг нь дотоод орчны нөлөөлөл болж байна.

Зураг 22. Зээлийн чанар (үлдэгдтээр, тэрбум ₮)



Зураг 23. Зээлийн чанар (нийт зээлд эзлэх хувь)




Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн бүтцийг задалж үзвэл нийт зээлдэгчдийн 0.7 хувийг бүрдүүлж буй хувийн байгууллага, аж ахуй нэгжид олгосон зээлийн 19.1 хувь нь чанаргүй болж, нийт чанаргүй зээлийн 85.4 хувийг бүрдүүлжээ. Харин иргэдэд олгосон зээлийн чанар харьцангуй сайн буюу чанаргүй зээлийн харьцаа 2.8 хувьтай байна.

Эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай (уг салбарт олгосон зээлийн 38.3% чанаргүй), боловсруулах үйлдвэрлэл (25.3%), барилгын (16.4%) салбарт олгосон зээлийн чанар муудсан нь чанаргүй зээлийн өсөлтийг голлон бүрдүүлжээ. Мөн барилгын салбарт олгосон зээлийн 23.5 хувь нь анхаарал хандуулах ангилалд байгаа нь цаашид уг салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэлтэйг харуулж байна.

Зураг 24. Зээлийн чанар, эдийн засгийн салбараар (%)




Эх сурвалж: Монголбанк

⁴ Монголбанкны "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу зээлийг хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэж ангилдаг. Үүнээс хэвийн бус, эргэлзээтэй, муу ангилалд багтсан зээлүүд нь чанаргүй зээлд хамаардаг.

Банкны салбарын чанаргүй зээлийн бүтцийг эдийн засгийн салбараар нь авч үзвэл тайлант оны эцсийн байдлаар нийт чанаргүй зээлийн 26.5 хувь буюу 471.8 тэрбум төгрөгийн чанаргүй зээл уул уурхайн салбарт, 20.6 хувь буюу 366.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээл боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.9 хувь буюу 247 тэрбум төгрөгийн чанаргүй зээл барилгын салбарт, 8.4 хувь буюу 149.3 тэрбум төгрөгийн чанаргүй зээл үл хөдлөх хөрөнгийн салбарт, 7.6 хувь буюу 135.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээл худалдааны салбарт тус тус олгогдсон байна. Өөрөөр хэлбэл дээрх таван салбарт олгосон чанаргүй зээлийн хэмжээ 1,369.9 тэрбум төгрөгт хүрч, банкны салбарын нийт чанаргүй зээлийн 77.0 хувийг эзэлж байна.


Зураг 25. Чанаргүй зээлийн бүтэц, эдийн засгийн салбараар (нийт чанаргүй зээлд эзлэх хувь, үлдэгдэл)



Ашигт ажиллагаа

Тайлант оны эцэст банкны салбарын нийт алдагдлын хэмжээ 97.7 тэрбум төгрөгт хүрч, ашигт ажиллагааны голлох үзүүлэлтүүд болох ROA (-0.3%), ROE (-3.2%) болж буурлаа. Тайлант оны эхний хагаст банкны салбар ашигтай ажиллаж байсан хэдий ч банкуудад хийгдсэн газар дээрх шалгалтаар банкуудын зээлийн чанарт тохируулга хийж, зээлийн эрсдэлийн сангийн зардал сүүлийн хагаст 430.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь алдагдлын хэмжээ өсөхөд голлон нөлөөлжээ. Банкуудын орлогын тайлангаас харахад алдагдалтай ажилласан банкуудын хувьд хүүгийн зардал хэт өндөр буюу иргэдээс хадгаламж татах зорилгоор банкны системийн дунджаас өндөр хүү санал болгосон нь ашигт ажиллагаанд нь сөргөөр нөлөөлсөн нь нийтлэг харагдаж байна.

Зураг 26. Банкны салбарын цэвэр ашиг (тэрбум ₮) Зураг 27. Активын болон өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт

Банкуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээ 29.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар буюу 4.2 их наяд төгрөгөөр өслөө. Банкууд хадгаламж, харилцахыг 3.6 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн нь эх үүсвэрийн өсөлтийг бүрдүүлжээ. Төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн дундаж хүү харгалзан 1.3 болон 0.5 нэгж хувиар буурсан ч банкуудын татан төвлөрүүлсэн хадгаламж тайлант онд 2.6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хадгаламжийн хэмжээ 13.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт хадгаламжийн үлдэгдлийн 67.4 хувийг 1 жил хүртэлх хугацаатай хадгаламж, харин 32.6 хувийг 1 жилээс дээшхи хугацаатай хадгаламж бүрдүүлж байна. Нийт хадгаламжийн 76.9 хувийг төгрөгийн, 23.1 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна. Төгрөгийн хадгаламж 17.5 хувиар өсч 10.1 их наяд төгрөгт, гадаад валютын хадгаламж 20 хувиар өсч 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна. (Гадаад валютын хадгаламжийн өсөлтийг ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол 17.7 хувь байна.)

Зураг 28. Пассивын бүтэц, өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Бүтцээр нь авч үзвэл банкны салбарын нийт эх үүсвэрийн 67.7 хувийг тогтвортой эх үүсвэр болох иргэд аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татсан харилцах, хадгаламж, 17.7 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 14.6 хувийг банкнаас дотоод, гадаадын зах зээл дээр гаргасан үнэт цаас, төслийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна. Өмнөх онтой харьцуулбал банкны салбарын нийт эх үүсвэрт эзлэх тогтвортой эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн эзлэх хувь 7.1 хувиар сайжирсан байна.


Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүд

Банкны салбарын эрсдэл даах чадварыг тодорхойлдог нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.8 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцаанаас харгалзан 3.8, 4.6 нэгжээр илүү байна (Зураг 29). Мөн банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа Монголбанкнаас тогтоосон доод хязгаарлалтаас 15.9 нэгжээр илүү буюу 40.9 хувь байна (Зураг 30).

Зураг 29. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (%)



Зураг 30. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (%)



Эх сурвалж: Монголбанк


Гадаад валютын ханшийн савлагаанаас үүсч болох алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай нь уялдуулах зорилгоор тэдгээрийн гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцаанд нийт валютын хувьд +/-40 хувиас тус тус хэтрэхгүй байх зохистой харьцааг Монголбанкнаас мөрдүүлдэг бөгөөд тайлант оны эцэст энэ үзүүлэлт нь -5.1 хувь байна.

Санхүүгийн салбар

Санхүүгийн салбар нь санхүүгийн хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс хөрөнгийг татан төвлөрүүлж, үүнийг үр ашигтай хөрөнгө оруулалтад байршуулах, эрсдэлийг тархаах замаар эдийн засгийн өсөлт, хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Гэвч санхүүгийн салбарт гарсан хүндрэлүүд нь эргээд бодит эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх, эдийн засагт учирсан шокийн далайцыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэл дагуулдаг. Үүний нэг тод жишээ нь 2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямрал юм. Уг хямрал нь бодлого боловсруулагч нарт үйлдвэрлэлийн болон үнийн түвшний тогтвортой байдал хангагдах нь макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдах хангалттай нөхцөл болж чадахгүй, нийт санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн тусгайлсан (макро зохистой) бодлого хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг тодорхой харуулсан юм. Улмаар дэлхий нийтээр санхүүгийн тогтвортой байдлыг чухалчлах нь нэмэгдэж, улмаар макро зохистой бодлого хэрэгжүүлэх суурь, боломж бүхий уламжлалт институцийг шинэчлэн зохион байгуулах, шинээр үүсгэн бий болгох, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүрэг (мандат)-ийг хуулинд тодорхой тусгах нь улам бүр олширч байна. Тухайлбал, ОУВС-гаас 2018 онд өөрийн гишүүн орнуудыг хамруулсан макро зохистой бодлогын талаарх асуулга судалгааг зохион байгуулсан бөгөөд уг судалгаанд хамрагдсан орнуудаас 111 нь макро зохистой бодлогын институцийн тогтолцооны талаарх асуултад хариулт өгснөөс 81 (73 хувь) нь макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий байгууллага (байгууллагууд)-тай гэж хариулсан байна⁵ (Зураг 31).

⁵ Судалгаанд хамтрагдсан макро зохистой бодлогын институцийн тогтолцооны талаарх асуултад хариулсан нийт хөгжингүй орнуудын 94.1 хувь, бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын 73.8 хувь нь тус тус макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий байгууллага (байгууллагууд)-тай гэж хариулсан байна.

Зураг 31. Дэлхийн улс орнууд дахь макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд (асуулгад хариулсан орнуудад эзлэх хувиар)



Эх сурвалж: “Annual Macroprudential Policy Survey-Objectives, Design, and Country Responses” IMF (2018).

Дэлхий нийтийн чиг хандлагыг дагаж УИХ-ын 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар батлагдсан Төв банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монголбанкинд макро зохистой бодлого хэрэгжүүлэх мандатыг олгож, хуулинд ил тод байдлаар тусгаад байна. Ингэснээр Монголбанк нь банкуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах уламжлалт үүрэг, функц дээр нэмж банк, санхүүгийн системийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй болсон юм.

Олон улсын туршлагаас харахад улс орнуудын макро зохистой бодлогын институцийн тогтолцоог эрх мэдэл, чиг үүрэг хаана төвлөрснөөс нь хамааруулан дараах ерөнхий гурван тогтолцоонд хувааж үздэг. Үүнд:

- **Тогтолцоо 1:** Нэгдмэл тогтолцоо буюу макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг төв банкинд төвлөрсөн байх бөгөөд төв банкны ерөнхийлөгч эсвэл мөнгөний бодлогын хороо (зөвлөл) нь макро зохистой бодлогын шийдвэрийг гаргах (Жишээ нь: Чех, Ирланд, Шинэ Зеланд, Сингапур, Монгол зэрэг улс). Энэхүү загварт макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх үүрэг нь нэг агент дээр төвлөрсөн байдаг учир хариуцлагын тогтолцоо (accountability) нь тодорхой байх, бодлогуудын (мөнгөний бодлого, макро болон микро зохистой бодлого) харилцан уялдааг хангах боломж олгодгоороо давуу талтай байна.
- **Тогтолцоо 2:** Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг мөнгөний бодлогын хорооноос тусдаа төв банкин дахь тусгайлсан хороо хариуцах (Жишээ нь: Англи, Малайз). Энэхүү загвар нь төв банкны хос мандат буюу мөнгөний бодлого, макро зохистой бодлогын хувьд тус тусдаа зорилттой, шийдвэр гаргалтын тусдаа бүтцийг бий болгосноор төв банкны хос мандатын эрсдэлийг бууруулах боломжтой байдаг.
- **Тогтолцоо 3:** Макро зохистой бодлогын мандат нь төв банкнаас гадуурх хороо, зөвлөлд олгогдсон байх бөгөөд төв банк гишүүнээр нь ажиллана (Жишээ нь: Австрали, Франц, АНУ). Энэхүү загварт Сангийн яамны оролцоо өндөр байх бөгөөд системийн эрсдэлийг удирдахад засгийн газрын оролцоо зайлшгүй шаардлагатай, төсвийн бодлоготой уялдаатай асуудал бий болсон, системийн эрсдэлийг бууруулах зорилгоор шинэ төрлийн макро зохистой бодлогын хэрэгсэл ашиглах, бодлогын хүрээг өргөтгөх зэрэгт хууль эрх зүйн орчинг өөрчлөх шаардлагатай үед энэхүү загвар нь давуу талтай байдаг.

Бүтцийн хувьд авч үзвэл манай улсын нийт санхүүгийн системийн 95 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж, санхүүгийн зах зээл хөгжлийнхөө эхэн үед явж байна. Хэдийгээр 2018 оны 3 дугаар улирлын байдлаар бүртгэлтэй 540 банк бус санхүүгийн байгууллага, 288 хадгаламж зээлийн хоршоо, 18 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил бүр олширч, үйл ажиллагааных нь цар хүрээ өргөжин тэлсээр байгаа боловч, санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувийг эзэлсэн хэвээр байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Санхүүгийн салбарын бүтэц, тэрбум төгрөг

	Актив		Ашиг		Өөрийн хөрөнгө	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
2017						
Банк	28 772	95.2%	249	74.2%	3 150	77.0%
ББСБ	969	3.2%	67	19.9%	758	18.5%
Даатгал	245	0.8%	13.2	3.9%	115	2.8%
ХЗХ	153	0.5%	6	1.6%	15	0.4%
Үнэт цаасны оролцогч	92	0.3%	1	0.3%	52	1.3%
2018Q3						
Банк	31 033	94.5%	42	30.7%	3 098	72.7%
ББСБ	1 202	3.7%	74	53.6%	932	21.9%
Даатгал	328	1.0%	14	10.5%	162	3.8%
ХЗХ	192	0.6%	4	3.0%	15	0.4%
Үнэт цаасны оролцогч*	93	0.3%	3	2.2%	55	1.3%

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо.

Тэмдэглэл: *Үнэт цаасны мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2018 оны 3 дугаар улирлын тоон мэдээлэл гараагүй байсан тул 2 дугаар улирлын тоон мэдээллийг ашиглав.

Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор системийн шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах үндсэн чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь макро эдийн засаг болон санхүүгийн салбарт тулгамдаж буй зарим асуудлыг тухай бүрт нь хурлаараа авч хэлэлцэн зохих шийдвэрийг гарган ажилладаг бөгөөд 2010 оноос хойш нийт 32 удаагийн хуралдаанаар 146 багц асуудлыг авч хэлэлцсэн байна. Тухайлбал, 2018 онд СТБЗ нь “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төлөвлөгөө”, “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”, “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” болон уг стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжил дэвшил, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой стратеги, төлөвлөгөөнүүдийг хамтарсан тушаалаар баталсан бөгөөд холбогдох байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Түүнчлэн олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн салбарын талаарх бодит мэдээллийг олон нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх замаар санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд СТБЗ-өөс 2013 оноос хойш хагас жил тутам “Монгол Улсын санхүүгийн тогтвортой тайлан”-г бэлтгэн гаргаж буй бөгөөд одоогоор эхний 12 дугаарыг бэлтгэн олон нийтийн хүртээл болгоод байна.

Банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт

Тайлант онд банкны салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд Монголбанкнаас банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллалаа.

Банкуудын үйл ажиллагааны хүрээ өргөжихийн хэрээр тэдгээрт тавих хяналт шалгалтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох шаардлага тулгарч байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга хэрэгслийг боловсруулах, банкинд харилцагчдын зүгээс тавих хяналтыг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг ОУВС-гийн техник туслалцаатайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Банкны тухай хууль тогтоомжид заасан шаардлага болон ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн Активын чанарын үнэлгээний үр дүн дээр үндэслэн банкуудад тавьж байгаа шаардлагыг хангуулах, шаардлага хангаагүй банкинд хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч ажиллалаа.

Тайлант онд батлагдсан хуваарийн дагуу банкуудын санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэн, Монголбанкны Хяналт шалгалтын хороогоор хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан болно. Банкны газар дээр нь хийх хяналт шалгалтын хүрээнд банкны санхүү төлбөрийн чадвар, удирдлага зохион байгуулалт, тайлан тэнцлийг шалгаж, шалгалтын акт материал бэлтгэн, төлбөр зөрчил, хууль тогтоомж зөрчсөн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, банкны удирдлагад шалгалтын үр дүнг танилцуулж, нэгдсэн танилцуулгыг Хяналт шалгалтын хорооны гишүүдэд танилцуулан, хурлаар хэлэлцүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, ашигт ажиллагаа, активын чанарын үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, хууль, тогтоомжид тавигдсан шаардлагыг хангаж ажиллаагүй банкуудад хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан болно. Түүнчлэн, банкуудын 2018 оны бизнес төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Хяналт шалгалтын газар нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр ОУВС болон олон улсын бусад байгууллагуудтай хамтран ажилласан болно. Түүнчлэн, төрийн байгууллагуудтай хууль, тогтоомжийн хүрээнд хамтарсан шалгалт хийх, хууль, хяналтын байгууллагаас шалгаж байгаа эрүү, иргэний хэрэгт шинжээчээр ажиллалаа.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (FATF буюу ФАТФ)-аас Техникийн хэрэгжилтийн болон Үр дүнтэй байдлын үнэлгээнд үндэслэн Монгол Улсыг Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн “Эрчимтэй хяналт”-д оруулах шийдвэрийг 2017 оны 7-р сард гаргасан билээ.

Монгол Улсыг Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн “Эрчимтэй хяналт”-д оруулсантай холбогдуулан Монголбанк Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчныг сайжруулах болон ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан, мэдээллийг 2018 оны 7 дугаар сард Балбын Катманду хотод болсон Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн орнуудын бүх гишүүдийн жилийн уулзалт (APG Plenary meeting)-д танилцуулав.

АНДББ (APG буюу Ази, Номхон далайн бүсийн байгууллага)-аас ФАТФ-аас өгсөн зөвлөмжтэй холбоотой 2018 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан гаргаж, Монгол улсыг “Эрчимтэй хяналт”-д хэвээр үлдээн, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааг 1 жилийн хугацаатай тогтоож, үр дүнг дараагийн уулзалтаар дүгнэхээр болсон байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд Монголбанк 2018 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Хууль, журам, эрх зүйн орчны шинэчлэлт

Монголбанкны Хяналт шалгалтын газар ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулж, 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг зарим холбогдох хуулиудад дагаж нэмэлт өөрчлөлт орлоо.

Мөн хуулийн өөрчлөлттэй уялдуулан Монголбанк “Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас газар дээрх хяналт, шалгалт хийх журам”, “Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк зайнаас хяналт тавих журам”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” зэрэг 7 журмыг шинэчлэн баталсан байна.

Хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор дээрх журмуудад “үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэх” зэрэг шинэ ойлголт орсноос гадна харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдийн тодорхойлолт гэх мэт ойлголтуудад өөрчлөлт оруулан илүү оновчтой, олон улсын стандарт шаардлагад нийцтэй болгосон байна.

Мөн хууль болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх зохицуулалт нэмэгдэж, банкууд өөрийн үйл ажиллагааны МУТС, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, бууруулах хэм хэмжээг тогтоох, хэрэгжилтийг нь шалгах, хяналт тавих боломжийг бүрдүүлснээс гадна, Монголбанк банкуудын МУТСТ холбоотой үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, газар дээр нь хяналт шалгалт хийх ажлыг эрсдэлд суурилсан зарчим, аргачлалд үндэслэн хийх хэлбэрт шилжлээ.

Хүснэгт 10. МУТСТ болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль болон холбогдох журмын өөрчлөлт.

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Огноо	Дугаар	Агуулга
1	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	2018.04.26		ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан.
2	МУТСТ үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж	2018.02.06	A-32	БСБ-ууд нь МУ-ийн эдийн засгийн ерөнхий нөхцөл болон МУТС үндэсний эрсдэлийн үнэлгээ, өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан МУ-ийн дотоод болон гадаадын хувь хүн, хуулийн этгээдтэй тогтоох санхүүгийн харилцаанаас үүдэн гарах МУТС эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, мониторинг хийх, хяналт тавих болон эрсдэлийг бууруулах үр дүнтэй тогтолцоотой байх зарчмыг тодорхойлж өгсөн.
3	МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас газар дээрх хяналт шалгалт хийх журам	2018.11.27	A-293	МУТСТ тухай хууль болон түүнтэй холбоотой Засгийн газар, Монголбанкны тогтоол, шийдвэрийг банк үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд Монголбанк МУТСТ болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийн үнэлгээнд суурилан газар дээр нь хяналт, шалгалт хийж үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах харилцааг журамласан.
4	МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк зайнаас хяналт тавих журам	2018.11.27	A-293	МУТСТ тухай хууль болон түүнтэй холбоотой Засгийн газар, Монголбанкны тогтоол, шийдвэрийг банк үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд Монголбанк зайнаас хяналт тавих, МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж, газар дээрх хяналт, шалгалтын чиглэл, хамрах хүрээ, хугацаа, давтамжийг тодорхойлох харилцааг зохицуулсан.
5	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам	2019.01.15	A-18	МУТСТ тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан банкны үйл ажиллагааны нэмэлт тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагад нэмэлт нөхцөл, шаардлага оруулсан.
6	Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам	2019.01.15	A-18	МУТСТ тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагад нэмэлт нөхцөл, шаардлага оруулж өгсөн.
7	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	2019.01.21	A-26	МУТСТ тухай хуульд заасан мэдээлэх үүрэг бүхий этгээдийн МУТСТ үйл ажиллагаа, түүнээс урьдчилан сэргийлэх, илэрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа, үүргийг нарийвчлан тодорхойлсон.

Эх сурвалж: Монголбанкны Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын алба

Түүнчлэн Монголбанкны МУТСТ чиг үүрэг бүхий ажилтнууд, зохих хууль, журмын дагуу ашиглаж болох санхүүгийн байгууллагын төлөөлөгчид, нийтийн албан тушаалтан болон сургагч багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулан, ном болгон гаргав.

Газар дээрх хяналт шалгалт, авсан арга хэмжээ

Монголбанкны хяналт шалгалтын газраас 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 14 банкны үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг газар дээр нь хийв.

Шалгалтаар банкуудын МУТСТ эрсдэлийн үнэлгээний аргачлал, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт, УТНБЭ, түүний холбогдох этгээдийг тодорхойлох байдал болон салбар нэгжүүдэд МУТСТ тухай хууль, журмын хэрэгжилт зэрэг үйл ажиллагааны чиглэл бүрт тодорхой зөрчил дутагдлууд илэрсэн бөгөөд үүнтэй холбогдуулан нийт 7 банкинд Улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэх болон торгуулийн арга хэмжээ авав.

Мөн илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгах, үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэсэн нийт 41 үүрэг даалгаврыг шалгалт хийгдсэн банкуудад өгч хэрэгжилтийн явцыг хянан ажиллаж байна.

Хүснэгт 11. Тусгай хяналтын албаны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн газар дээрх хяналт шалгалт.

Үзүүлэлт	2018 он
Газар дээрх хэсэгчилсэн хяналт, шалгалт	14
Шалгалтаар тогтоосон Улсын байцаагчийн акт, мэдэгдэл	3
Ногдуулсан торгууль, шийтгэлийн тоо	5
Шалгалтаар өгсөн үүрэг даалгавар	41

Эх сурвалж: Монголбанкны Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын алба

Банкуудад газар дээрх хяналт, шалгалт хийх явцад ФАТФ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу дотооддоо мөрдөх МУТСТ холбоотой дүрэм журмуудыг шинэчлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар заавар чиглэл өгсөн. Мөн банкуудын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, журмын хэрэгжилт болон энэ үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх зорилгоор банк бүрээр 7 бүлэг бүхий асуулгыг бөглүүлэн, 6 бүлэг бүхий тоон мэдээлэл гаргуулан авч, эдгээрт үндэслэн тухайн эрсдэлийн үнэлгээг хийлээ.

Түүнчлэн ФАТФ-ийн зөвлөмжид тусгасан хамтарсан хяналт шалгалт хийх тухай зөвлөмжийн дагуу 2019 оны 1 дүгээр сард Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран санхүүгийн нэгдэл бүхий 46 компанид тухайн компаниудын бүтэц, эцсийн өмчлөгчийг тодорхойлох болон тэдгээрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжүүлж буй байдлыг үнэлэх, заавар зөвлөмж өгөх, улмаар гарсан үр дүнтэй уялдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллах зорилгоор газар дээрх хяналт, шалгалтыг хийлээ.

Монголбанкны Хяналт шалгалтын нэгж, Банк санхүүгийн академи болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт МУТСТ тухай сэдвийн хүрээнд 30 орчим цагийн танилцуулга хийсэн байна.

Хүснэгт 12. Тусгай хяналтын албаны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн сургалт, хэлэлцүүлэг.

№	Сургалт хийсэн сэдвийн агуулга	Он, сар	Зохион байгуулагч	Оролцогчдийн тоо
1	МУТСТ чиглэлээр	2018.04	Банк санхүүгийн академи	25
2	МУТСТ заавар, журам боловсруулах	2018.05	Азийн хөгжлийн банк, СЗХ,СМА	90
3	Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн хэлэлцүүлэг	2018.05	УИХ-ын гишүүн Х.Нямбаатар	-
4	МУТСТ чиглэлээр	2018.10	Монголбанк	44
5	Банкны салбарын эрсдэлийн Зөвлөгөөн /De-risking/	2018.10	Монголбанк	75
6	Комплаенсийн форум - 2018	2018.11	Монголбанк, Монголын банкны холбоо, Голомт банк	250

Эх сурвалж: Монголбанкны Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын алба

1.5 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Засгийн газрын санхүү

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9,234.9 тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн дүн 9,222.9 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл ДНБ-ий 0.04 хувьтай тэнцүү буюу 12 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй гарлаа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Өнгөрөгч 2018 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого бүрдүүлэлт 125.5 хувийн гүйцэтгэлтэй байв. Нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.9 хувийг татварын орлого, 11.1 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна. Төсвийн орлого өмнөх оноос 27 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 13. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, бүрэлдэхүүн хэсгээр

тэрбум төгрөг	2017	2018	2018/2017	
	i.	ii.	ii.-i.	ii./i. (%)
Нийт орлого	7922	10063	2140	127%
Ирээдүйн өв сан	358	621	263	174%
Тогтворжуулалтын сан	326	207	-119	64%
Тэнцвэржүүлсэн орлого	7239	9235	1996	128%
Татварын орлого	6303	8207	1904	130%
Импорттой холбоотой татварын орлого	1860	2628	768	141%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1032	1412	380	137%
Гаалийн албан татвар	512	682	170	133%
Онцгой албан татвар	316	534	218	169%
Орлогын албан татвар	1610	2086	477	130%
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1314	1621	307	123%
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	986	1056	71	107%
НӨАТ-н буцаан олголт	-147	-114	33	78%
Бусад татварын орлого	679	929	250	137%
Татварын бус орлого	936	1028	91	110%

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зардал

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зардал, цэвэр зээлийн гүйцэтгэл 91.9 хувьд байв. Үүнд, урсгал зардал 95.6 хувь (342.2 тэрбум төгрөг дутуу), хөрөнгийн зардал 78 хувь (453.4 тэрбум төгрөг дутуу), эргэж төлөгдөх цэвэр зээл 92.5 хувийн (21.5 тэрбум төгрөг дутуу) гүйцэтгэлтэй байлаа. Төсвийн нийт зардал өмнөх оноос 2.7 хувиар (242 тэрбум төгрөг) тэлэхэд татаас, шилжүүлэг 246.7 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардал 204.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн бол зээлийн үйлчилгээний төлбөр 109.1 тэрбум төгрөгөөр, цэвэр зээл 62.3 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 38.2 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт 14. Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээл, төсвийн тэнцэл, бүрэлдэхүүн хэсгээр

тэрбум төгрөг	2017	2018	2018/2017	
	i.	ii.	ii.-i.	ii./i. (%)
Нийт зардал	8981	9223	242	103%
Анхдагч зардал	7825	8176	351	104%
Урсгал зардал /-хүүний зардал/	5850	6301	452	108%
Хөрөнгийн зардал	1646	1608	-38	98%
Цэвэр зээл	329	267	-62	81%
Хүүний зардал	1156	1047	-109	91%
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	-1742	12	1754	
ДНБ-д эзлэх хувь	-6.5%	0.0%		
Анхдагч тэнцэл	-586	1059	1645	
ДНБ-д эзлэх хувь	-2.2%	3.5%		

Эх сурвалж: Сангийн яам

Алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр

Тайлант онд 2'703 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг дотоод (1'768 тэрбум төгрөг), гадаад (Чингис бонд, Дим сам бондын төлбөр 667 тэрбум төгрөг) үнэт цаас болон гадаад төслийн зээл (280 тэрбум төгрөг) эргүүлэн төлөхөд тус тус зарцуулжээ.

Хүснэгт 15. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг	2017	2018	2018/2017
	i.	ii.	ii.-i.
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1742	-12	-1754
Харилцах болон хадгаламжийн данс	-1022	622	1644
ЗГ-ийн бонд	207	-2435	-2641
Шинээр гаргах	6589	0	-6589
Үндсэн төлбөр	-6383	-2435	3948
ЗГ-ийн зээл	1803	1568	-234
Шинээр гаргах	2237	1440	-798
Үндсэн төлбөр	-435	129	563
ИӨС-ийн шилжүүлэг	160	100	-60
ТС-ийн хуримтлагдсан үлдэгдэл	572	123	-449
Өмч хувьчлал	23	9	-13

Эх сурвалж: Сангийн яам

Шаардагдсан 2,703 тэрбум төгрөгийн ихэнх хэсэг буюу 1440 тэрбум төгрөгийг гадаад зээлээр (Үүний 475 тэрбум төгрөг нь хөтөлбөрийн зээл, үлдсэн нь төслийн зориулалттай зээл) санхүүжүүлсэн бол 622 тэрбум төгрөгийг Засгийн газрын Монголбанкн дахь харилцах болон хадгаламжийн данснаас төллөө. Үлдсэн 630 орчим тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сан (ИӨС) –ийн шилжүүлэг, авлага, Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс бүрдүүлээ.


2017 оны эцэст Засгийн газрын дотоод бондын хэмжээ 3,336.4 тэрбум төгрөгтэй тэнцүү байсан бол 2018 онд 1,768 тэрбум төгрөгийн дотоод бондыг эргүүлэн төлснөөр дотоод бондын үлдэгдэл 1,568.4 тэрбум төгрөг болж буурлаа.

2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляци тайлант оны эхний 10 сарын байдлаар зорилтот түвшнээс доогуур түвшинд хэлбэлзэж байсан бол оны эцэст өсч улсын хэмжээнд 8.1 хувь байна. Улаанбаатар хотын хувьд тооцсон жилийн инфляци 9.7 хувьд хүрсэн нь нийлүүлэлтийн хүчин зүйлээс эрс хамаарсан байна. Инфляцийн талаас илүү хувийг мах, шатахуун, хатуу түлшний үнийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 1. ХҮИ-ээр инфляци болон инфляцийн зорилт



Тайлант оны эхний хагаст нэг удаагийн болон нийлүүлэлтийн шалтгаанаар инфляци нэмэгдэж, цаашид эдгээр хүчин зүйлсийн нөлөө саарах, эдийн засгийн идэвхжилийг дагаад эрэлтийн инфляци нэмэгдэх ч дунд хугацааны зорилтот түвшний орчим тогтворжихоор хүлээгдэж байна. Тайлант оны сүүлийн хагаст БНХАУ-д гахайн ханиад өвчин гарч, Монгол Улсаас мах импортолж эхэлсэн нь махны үнийг огцом өсгөж, инфляцийн төсөөлөлд өмнө нь тооцоогүй, шинэ хүчин зүйл боллоо. Үүний зэрэгцээ хатуу түлшний үнэ улирлын чиг хандлагаас давж өсч, шатахууны үнэ хүлээлтээс өссөн нь нийлүүлэлтийн шинжтэй инфляцийн дарамтыг нэмэгдүүлж, улмаар инфляци 11, 12-р сард Улаанбаатар хотын инфляци огцом нэмэгдэх гол шалтгаан боллоо.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2018 оны 1-р улиралд, УИХ-аас томилсон Мөнгөний бодлогын хороо 2-4-р улиралд нийт 5 удаа хуралдаж, мөнгөний бодлогын хүүний болон макро зохистой бодлогын шийдвэрүүдийг гаргалаа. Тухайлбал, 2018 оны 1-р улиралд инфляци дунджаар улсын хэмжээнд 6.8 хувь, Улаанбаатар хотод 7.9 хувь байв. Эдийн засаг идэвхжиж, түүнийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж байсан хэдий ч, нэг удаагийн шинжтэй болон нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө цаашид буурч, жилийн инфляци зорилтот түвшний орчим тогтворжихоор байлаа. Ийм нөхцөлд инфляцийн дарамтыг нэмэгдүүлэхгүйгээр бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор Мөнгөний бодлогын зөвлөл 3-р сарын 26-ны өдөр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргасан юм.

Инфляци 2018 оны 5-р сард улсын хэмжээнд 6.1 хувь, Улаанбаатар хотод 6.6 хувьд хүрсэн бол цаашид алгуур буурч 8-р сард улсын хэмжээнд 6.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.4 хувьтай байсан инфляци улирлын чиг хандлагаа дагаад цаашид нийлүүлэлтийн шинжтэй инфляцийн дарамт буурч, инфляци оны эцэст зорилтот түвшний орчимд тогтвортой хадгалагдахаар байлаа. Нөгөө талаас гадаад

орчны тодорхой бус байдал нэмэгдэж, манай экспортын бүтээгдэхүүний үнэд сөргөөр нөлөөлөх, хөгжиж буй орнуудаас хөрөнгийн урсгал гадагшлах эрсдэлтэй байсан тул УИХ-аас томилогдсон Мөнгөний бодлогын хороо 6 болон 9-р сарын хуралдаанаар бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэв. Хэрэглээний зээлийн өсөлт сүүлийн жилд эрчимжиж, бизнесийн зээл өсөхгүй байгаа нь дотоод эрэлтийг хэрэглээний зээлээр хөөрөгдөж, төлбөрийн тэнцэл, үнэ, банк санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх, иргэдийн өрийн дарамт огцом нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байв. Иймд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг өөрчлөөгүй ч, бизнесийн зээлийг нэмэгдүүлэн эдийн засгийн алгуур сэргэлтийг дэмжих зорилгоор хэрэглээний зээлийн хувьд макро зохистой бодлогын хязгаарлалтуудыг тогтоож 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэлээ.

Оны сүүлийн улиралд хэдийгээр эрэлтийн шинжтэй инфляцийн дарамт харьцангуй алгуур нэмэгдэж байсан боловч мах, хатуу түлш, шатахууны үнийн нөлөөгөөр инфляци нэмэгдэж байлаа. Мөнгөний бодлогын хороо 11 дүгээр сарын 27-ны өдөр ээлжит бус хуралдааныг хийж, инфляци, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, инфляцийн зорилт, 2019 оны батлагдсан улсын төсөв болон гадаад орчны тодорхой бус байдал зэргийг харгалзан үзээд бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөсөн юм. Хэдийгээр нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө цаашид арилахаар хүлээгдэж байсан боловч нэг талаас 2019 онд төсвийн алдагдал нэмэгдэж дотоод эрэлтийг нэмэгдүүлэх, нөгөө талаас гадаад орчны тодорхой бус байдлын нөлөөгөөр гадаад эрэлт саарч, улмаар гадаад, дотоод тэнцвэр алдагдахаас сэргийлэх, макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой өсөлтийг хадгалах зорилгоор энэхүү шийдвэрийг гаргасан юм.

Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн хоёр дахь үеийн нөлөө болон эрэлтийн шалтгаантай инфляци харьцангуй бага байна гэж үзээд Мөнгөний бодлогын хороо 12 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар бодлогын хүүг хэвээр хадгалж, мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэв.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримталж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцон ажиллалаа.

Оны эхний хагаст Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлт сайжирсан, ОУВС-гийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ сайн гарсан, Засгийн газраас 2018 оны 1-р сард төлөгдөх Чингис бондын 500 сая ам.долларын төлбөрийг 800 сая ам.долларын Гэрэгэ бондоор төлсөн, оны эхнээс урьдчилсан байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой гадаад валютын орох урсгал сайжирсан зэргээс шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл тогтворжсон. Харин 2018 оны хоёрдугаар хагасаас эдийн засгийн идэвхжил эрчимжиж буйтай холбоотойгоор гадаад валютын эрэлт нэмэгдэж, 2018 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8.9 хувиар, голлох 22 улсын валютын сагстай харьцах төгрөгийн ханш 2.8 хувиар тус тус сулав. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ийнхүү суларсан нь дор дурдсан гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгааллаа. Үүнд:

1. Холбооны нөөцийн банк 2018 онд бодлогын хүүгээ 4 удаа өсгөж 2.5 хувь буюу Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш хамгийн өндөр хэмжээнд хүргэсэн. Ингэснээр олон улсад ам.долларын өгөөж өсч, хөрөнгийн урсгал хөгжиж буй орнуудаас хөгжингүй орныг чиглэж, улмаар ам.долларын ханш бусад валютын эсрэг чангарав.
2. Монгол Улсын эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор 2018 оны эхний 12 сарын байдлаар зээл олголт өмнөх оны мөн үеэс 24 хувь, импортын хэмжээ 5.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 36 хувиар өссөн нь валютын эрэлтийг нэмэгдүүлэх шалтгаан болов.

3. Дээрх хүчин зүйлстэй зэрэгцэн 11-р сараас эхлэн Монгол Улсын нүүрсний экспортын хагасыг гаргадаг Гашуунсухайт боомтын үйл ажиллагаанд доголдол гарсан, БНХАУ импортлох нүүрсний хэмжээндээ хязгаарлалт тогтоох тухай мэдээлэл гарсан зэргээс шалтгаалан төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах хүлээлт бий болов¹.


Дээр дурдсан шалтгаануудын улмаас Монголбанк 2018 оны 2-р хагаст валютын зах дээр үүссэн ам.долларын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах, валютын захад оролцогчдод тулгарсан нэн шаардлагатай эрэлтийг хангах чиглэлийн дагуу валютын захын оролцоогоо нэмэгдүүллээ. Улмаар Монголбанк 2018 онд зөвхөн 103 удаагийн гадаад валютын дуудлага худалдаагаар цэвэр дүнгээр 1,015.6 сая ам.долларыг, Банк хоорондын валют арилжааны цахим талбараар дамжуулан 211.8 сая ам.долларыг валютын захад нийлүүлэв.

Түүнчлэн, ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй ӨСХ-ийн хүрээнд Монголбанкинд тавьсан тоон шалгуур үзүүлэлтийг ханган ажиллах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” ба “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгасан валютын нөөцийг урт хугацаанд тогтвортой байлгах, шаардлагатай үед гадаад болон дотоод эх үүсвэр татах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилтуудын хүрээнд Сангийн яам болон экспортын томоохон компаниудаас нийт 803.6 сая ам.долларыг худалдан авжээ.


Үүний зэрэгцээ банк болон тэдгээрийн харилцагчдын ханшийн эрсдэлийг бууруулах, гадаад эх үүсвэр татах сонирхлыг урамшуулах, гадаад валютаарх зээлийн өсөлтийг хязгаарлаж, долларжилтыг бууруулах зорилгоор урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулж ажиллалаа. Тухайлбал 2018 онд нийт 608.4 сая ам.долларын урт хугацаат своп хэлцэл, давхардсан тоогоор 8 удаагийн 315.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютын хадгаламжийн гэрээг банкуудтай байгуулжээ.

Оны эцсийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2643.69 төгрөгт хүрч, оны эхнээс 8.92 хувиар суларсан байна. Тайлант хугацаан дахь ханшийн дундаж хэлбэлзэл 0.03 хувь байсан бол нэг өдөрт хамгийн ихдээ 0.21 хувиар буюу 5.05 төгрөгөөр чангарч, 0.61 хувиар буюу 14.69 төгрөгөөр суларсан байна. Мөн тайлант хугацааны 99 хувьд ханш өдөрт ± 0.3 хувьд хэлбэлзсэн бөгөөд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 2017 онтой харьцуулахад 0.04 нэгж хувиар өсч, 2016 онтой харьцуулахад 0.06 нэгж хувиар буурсан үзүүлэлтэй байлаа.

Зураг 2. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны зарласан ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)



Зураг 3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж



Эх сурвалж: Монголбанк

¹ 2018 оны 11, 12 дугаар сард Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд ирүүлсэн банкуудын цэврээр худалдан авах валютын саналын хэмжээ 2018 оны 1-10 сарын дунджаас 3.9 дахин өсч, сард дунджаар 950 сая ам.доллар худалдан авах санал ирүүлж байв.

2.2 БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант жилд Монголбанк банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллалаа. Тодруулбал, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлууллаа. Энэхүү хуулиар эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хөрөнгийг хамгаалах зорилтын хүрээнд төрөөс банкны дахин хөрөнгөжүүлэх харилцааг зохицуулсан бөгөөд дагалдан гарах журам, зааврыг бэлтгэн, батлахаар ажиллаж байна. Банкны дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ банк алдагдлаа хүлээж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх чиглэлд дотоод нөөц бололцоогоо бүрэн ашигласан байх, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах томоохон банк байх, төсвөөс гарах зардлыг хамгийн бага байлгаж, гаргасан хөрөнгийг богино хугацаанд буцаан төвлөрүүлэх зэрэг зарчмыг баримтлах болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталсан Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой банкны тогтворжуулалтын санг бий болгохоор зохицуулсан. Энэ сан нь банкнаас төлсөн хураамжаас бүрдэх бөгөөд татвар төлөгчийн мөнгөөр бус тухайн системээс бүрдүүлсэн хөрөнгөөр хүндрэлд орсон банкинд бүтцийн өөрчлөлт хийх, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг хийнэ. Тус санд хөрөнгө хуримтлуулж эхлэх арга хэмжээг эдийн засаг болон банкны салбарын нөхцөл байдлыг харгалзан хэрэгжүүлэх бөгөөд өнөөдрийн байдлаар үйл ажиллагааны нарийвчлан зохицуулах журмыг боловсруулж байна. Үүнээс гадна эрсдэлд орсон банкны өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож банкны өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах эрх зүйн орчинг бий болголоо.

Албадлагын арга хэмжээ нь Онцгой дэглэм тогтоох, Банкны эрх хүлээн авагч томилох гэсэн хоёр хэлбэртэй байсан бол дээрх нэмэлт, өөрчлөлтөөр банкны тогтворжуулалт, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, банкны нөхцөлт удирдлага, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ, банкны татан буулгах гэсэн дэд хэсэгт хуваагдсан. Эдгээр арга хэмжээг авахад шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор холбогдох журмуудыг Олон Улсын валютын сангийн зөвлөмж, Монголбанкнаас өмнө авсан албадлагын арга хэмжээний туршлага зэргийг үндэслэн боловсруулж тайлант онд “Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам”, “Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх журам”, “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх журам”-ыг баталлаа.

Хадгаламжийн даатгал нь банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн суурь тогтолцооны нэг юм. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар Банкны дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр банкны бүтцийн арга хэмжээний хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацийн оролцоог тодорхой болгож, банкинд санхүүгийн дэмжлэг, нөхөн олговор олгох зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгосон. Мөн Хадгаламжийн даатгалын корпорацийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн салбарт активын удирдлагын тогтолцоо хөгжүүлэх, шаардлагатай эрх зүйн орчин бүрдүүлэхээр 2017 онд Азийн хөгжлийн банктай хамтран ажилласан. Мөн Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөллийг багтаасан өргөтгөсөн ажлын хэсгийг байгуулан хувийн хэвшлийн оролцоо давамгайлсан активын удирдлагын тогтолцоо хөгжүүлэхээр хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн бариулахаар хууль санаачлагчид хүлээлгэн өгч, хамтран ажиллаж байна.

Банкны салбарт хуримтлагдаад буй чанаргүй зээлийг шийдвэрлэх стратегийг 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралд танилцуулж Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар баталсан. Чанаргүй зээл системд хуримтлагдах нь банкны зээл олгох эх үүсвэр, сонирхлыг бууруулж, санхүүгийн зуучлалыг саармагжуулах сөрөг нөлөөтэй тул

стратегийн хүрээнд банкны системийн чанаргүй зээлийн хувийг 2021 онд 4-5 хувь, 2023 онд 2-3 хувьд хүргэж бууруулах зорилт дэвшүүлсэн бөгөөд ирэх 3 жилийн хугацаанд өр төлбөрийг шүүхийн журмаар албадан барагдуулах ажиллагааг сайжруулах, татварын орчинг оновчтой болгох, дампуурлын хууль, тогтоомжийг шинэчлэх зэрэг арга хэмжээг авахаар ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжүүлэх боломж бүрдэж байгаа бөгөөд албадлагын арга хэмжээний үе шат, Монголбанкнаас эрсдэлтэй банкинд авч хэрэгжүүлэх шалгалтын арга хэрэгслийг уян хатан байдлаар тогтоосон. Ялангуяа, Монголбанкнаас эрсдэлтэй гэж дүгнэвэл банкуудад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, учирч болзошгүй алдагдлын хэмжээг бууруулах боломжтой болсон. Түүнчлэн, төлбөрийн чадвар муудсан банкинд авах албадлагын арга хэмжээг санхүүгийн салбарт үүсэх алдагдлыг хамгийн бага түвшинд байлгахуйц байдлаар шийдвэрлэх арга хэрэгслийг ашиглах сонголтыг Монголбанкнаас олгож байгаагаараа онцлог юм. Монголбанкнаас олон улсын сайн туршлага нэвтрүүлэх Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын орчинг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Базелийн стандартын 2 дугаар тулгуур (Pillar II)-ийг нэвтрүүлэх ажлыг тайланд онд эхлүүлээ. Тухайлбал, Монголбанкнаас банкуудад тогтоосон өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод шаардлагаас гадна, уг шаардлагад тусгагдаагүй бусад төрлийн эрсдэлийг үнэлж, удирдах аргачлалыг банкуудын зүгээс бие даан боловсруулах, Монголбанкнаас уг аргачлал нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, бизнес загвар болон эрсдэлийн ерөнхий түвшинтэй зохицсон эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг банк бүрт тусгайлан тогтоож, хангуулах харилцан хамаарал бүхий тогтолцоог нэвтрүүлэх нөхцөл бүрдэх юм.


2.3 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ "Төв банкны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмыг баримталж ажилладаг. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, нөөцийн удирдлагад оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэдэг.

Монголбанк 2018 онд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллалаа. Валютын нөөцийн удирдлагын хүрээнд хийсэн хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэв.

Дэлхийн тэргүүлэгч орнуудын эдийн засгийн өсөлт нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд сайжирснаар тайлант онд АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ 4 удаа нэмэгдүүлсэн бол Английн Төв банк 1 удаа бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн (Зураг 4). Улмаар тус валютын багцуудын хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөж нэмэгдэх нөхцөл бүрдсэн.

Зураг 4. Төв банкны бодлогын хүү (%)



Эхсурвалж: Блүүмберг

Тайлант онд Монголбанкнаас валютын нөөцийг дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи гэх мэт орнуудын төв банк, Засгийн газар, Олон улсын төлбөр тооцооны банк (ОУСБ) зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй улс орон, байгууллагуудад харилцах, хадгаламж, үнэт цаас хэлбэрээр байршуулж удирдлаа. Харин нөөцийн урт хугацаат багцыг АНУ-ын Засгийн газар, олон улсын санхүүгийн корпорацийн 0-3 жилийн хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар удирдав.

Монголбанкны дотоодын зах зээлээс худалдан авсан алтны хэмжээ 22 тн хүрч өмнөх оны үзүүлэлтээс 9.5 хувь илүү байлаа. Улмаар нөөцөд эзлэх мөнгөжсөн алтны багцын хэмжээг ихэсгэж, голч түвшнөөс дээгүүр удирдаж ажилласан.

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3541.6 сая ам.долларт хүрч оны эхнээс 17.7 хувиар буюу 533.5 сая ам.доллараар өссөн. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээг дараах байдлаар хангаж байна (Зураг 5).

- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 5.8 сарын буюу 23.1 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 6.4 сарын буюу 25.5 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд тус тус байв.

Монгол Улсын Их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл (ҮАБЗ)-ийн үзэл баримтлалд заасан “Гадаад валютын улсын нөөц нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшнөөс багагүй байх” тухай шаардлагыг хангахгүй байна.

Зураг 5. Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)



2.4 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн ба тус хуульд нийцүүлэн төлбөрийн системийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг хийх зорилгоор холбогдох журам, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай баримт бичгийг шинээр боловсрууллаа. Тухайлбал, “Цахим мөнгөний журам”, “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”-ыг шинээр батлуулж, “Их дүнтэй төлбөрийн системийн журам”-д нэмэлт өөрчлөлтийг тусгаж, шинэчлэн батлуулаад байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачилгаар 2018 оны 10 дугаар сараас 2 сарын хугацаанд “Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяныг зохион байгуулж, банкууд, Сангийн Яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, АХБ-ны “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн нэгж, Улаанбаатар

TEDx болон финтек байгууллагууд хамтран ажиллалаа. Аяны хүрээнд “Дижитал гарц” өдөрлөг, эссе бичлэгийн уралдаан, нээлттэй сургалт зэрэг арга хэмжээг зохион байгуулсан нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, Монгол Улс дахь төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ирээдүйн хөгжлийн талаар олон нийтэд таниулан сурталчлах, иргэд, хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан арга хэмжээ боллоо.

"Үндэсний төлбөрийн системийн тухай хууль"-д заасны дагуу Монголбанк, санхүүгийн байгууллагыг хянан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, төлбөрийн системийн оролцогчийн төлөөллөөс бүрдсэн, орон тооны бус, хараат бус "Үндэсний төлбөрийн системийн зөвлөл"-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр байгуулж, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зөвлөлийн анхны хурлыг зохион байгуулсан. Зөвлөл нь төлбөрийн системийн оролцогч, хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамгаалах, нэгтгэх, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8.2-д заасны дагуу төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийн зөвшөөрлийг Монголбанк олгодог. Одоогоор Монголбанкны зөвшөөрөлтэй төгрөгийг орлох төлбөрийн хэрэгсэл нь төлбөрийн карт, цахим мөнгө байна. Энэ онд нэмэлт зөвшөөрөл авсан, нэмэлт зөвшөөрөл цуцлагдсан, зөвшөөрөл сунгагдсан банк тус бүр нэг байна. “Цахим мөнгөний журам”-ын дагуу Монголбанк нь цахим мөнгө гаргах үйл ажиллагаа эрхлэх анхны зөвшөөрлийг 2018 оны 9 дүгээр сард Мобифинанс ББСБ-д олгов.

Төлбөрийн системд хяналт тавих үүргийн дагуу бүх банкинд иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн ба шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллаа. Түүнчлэн, Их дүнтэй систем, Төв банкны үнэт цаасны төлбөр тооцооны систем нь Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудыг хэрхэн хангаж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээнээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 12 зарчим бүрэн хэрэгжсэн, 2 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 9 зарчим хамааралгүй байна. Энэхүү үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Цахим орчинд дамжиж буй баримт бичгийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг баталгаажуулдаг, хуулиар баталгаажсан дижитал технологи болох тоон гарын үсгийн системийн (PKI систем) тоног төхөөрөмжийн суурилуулалт, тэдгээрийн програм хангамжийн тохиргоог хийж, Монголбанкны дотоод систем, төлбөр тооцооны бүх систем, зээлийн мэдээллийн сан, Төв банкны үнэт цаас болон валютын арилжааг гүйцэтгэх банк хоорондын цахим арилжааны системд нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлын хүрээнд нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд ПОС төхөөрөмж байршуулах ажлыг Төрийн банктай хамтран амжилттай хэрэгжүүлснээр иргэд аль ч банкны карт ашиглан банкинд очихгүйгээр тухайн үйлчилгээ авч буй цэгтээ төрийн үйлчилгээний төлбөр төлөх боломжтой болсон. Монголбанкны Үндэсний Цахим Гүйлгээний Төвийн системд Төрийн үйлчилгээний Онлайн төлбөр төлөлтийн MPI систем, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд байршуулах ПОС-н гүйлгээг дамжуулах E-Trans системийг нэмэлтээр хөгжүүлсэн нь төрийн үйлчилгээний төлбөр тооцоог Төрийн сангийн дансанд нэг бүрчлэн шууд тусгадаг давуу талтай боллоо.

Тайлант хугацаанд хийгдсэн банк хоорондын гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх оныхтой харьцуулбал гүйлгээний тоо 68.8 хувиар, гүйлгээний дүн 27.3 хувиар өссөн байна. Банк хоорондын 2015-2018 оны байдлаарх их, бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтийг (Хүснэгт 1), өсөлт бууралтыг (Зураг 6)-д үзүүлэв.

Хүснэгт 1. Банк хоорондын 2015-2018 оны гүйлгээний тоо, дүн

(мянган ширхэг, их наяд төгрөг)

	2015		2016		2017		2018	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	5,231.4	12.0	7,323.2	11.3	7,034.1	13.7	9,295.8	20.01
өсөлт (%)	15.9	-9.7	40.0	-5.9	-3.9	20.8	32.2	46.5
II улирал	5,824.7	15.9	11,082.4	17.5	7,533.2	19.8	10,992.30	22.80
өсөлт (%)	14.5	5.8	90.3	10.4	-32.0	13.2	45.9	15.2
III улирал	5,844.0	17.7	5,186.8	15.0	4,999.9	17.3	10,850.60	19.7
өсөлт (%)	22.0	27.5	-11.2	-15.2	-3.6	14.9	117.0	13.6
IV улирал	5,313.9	14.1	8,277.2	13.3	6,514.5	20.0	12,898.7	27.7
өсөлт (%)	-2.8	-38.3	55.8	-5.3	-21.3	50.4	98.0	38.5
Нийт	22,213.9	59.7	31,869.6	57.2	26,081.7	70.8	44,037.4	90.2
өсөлт (%)	11.9	-8.2	43.5	-4.2	-18.2	23.7	68.8	27.3

Эх сурвалж: Монголбанк

Зураг 6. Банк хоорондын 2015-2018 оны гүйлгээний тоо, дүн



Төлбөрийн карт

Төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт жил тутамд өсөж байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах иргэдийн сонирхол өндөр байгааг харуулж байна. Банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жей Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. 2018 оны байдлаар нийт картын 72.9 хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байна.

Хүснэгт 2. Төлбөрийн картын хэрэглээ 2015-2018 онд

Картын хэрэглээний тоо	2015	2016	2017	2018	Өсөлт (%)
Картын тоо /сая ширхэг/	4.1	4.0	3.8	4.3	11.6
Идэвхитэй ашиглагдаж буй картын тоо /сая ширхэг/	2.3	1.5	1.7	1.6	-7.6
Төхөөрөмжийн тоо					
ПОС	14,780	21,325	27,304	42,014	53.9
МПОС	4,381	3,796	3,499	3,784	8.1
ПОБ	1,930	1,872	2,031	2,177	7.2
АТМ	1,545	1,897	2,031	2,358	16.1
Гүйлгээний тоо, дүн					

ПОС	Тоо, сая ширхэг	38,1	65,7	119.2	199.6	67.5
	Дүн, тэрбум төгрөг	1,571.9	1,949.9	3,388.1	5,441.6	60.6
МПОС	Тоо, сая ширхэг	0.2	0.7	0.6	0.8	27.1
	Дүн, тэрбум төгрөг	4.6	8.8	9.5	12.4	31.0
ПОБ	Тоо, сая ширхэг	1.0	0.8	1.2	3.9	228.3
	Дүн, тэрбум төгрөг	191.2	200.6	310.9	477.4	53.5
АТМ	Тоо, сая ширхэг	117.2	83.9	91.5	101.3	10.8
	Дүн, тэрбум төгрөг	6,863.5	10,525.3	18,826.9	24,659.77	31.0
Нийт	Тоо, сая ширхэг	156.6	151.1	212.5	305.6	43.8
	Дүн, тэрбум төгрөг	8,631.1	12,684.6	22,535.4	30,591.09	35.7

Эх сурвалж: Монголбанк

2.5 БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

2018 оны хувьд банк санхүүгийн тогтвортой байдлыг хангах, сайн засаглал, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, зохицуулалт, харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр төв банк, банк, тэдгээрийн эрх зүйн байдлыг тогтоосон гол хуулиудад олон улсын шилдэг туршлага, стандартыг нэвтрүүлж, санхүүгийн систем эрүүлжиж, бэхжих хөрс суурийг бүрдүүлсэн эрх зүйн өөрчлөлт шинэтгэлийн жил боллоо.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”, 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл” болон Монголбанкнаас 2017 оноос санаачлан хэрэгжүүлж байгаа “Банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын Валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хууль эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага, зорилт тусгагдсан билээ.

Энэ хүрээнд Монголбанкны бодлого, удирдлагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, хамтын шийдвэр гаргах зарчмыг нэвтрүүлэх, макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, банкны хяналт шалгалт, зохицуулалтын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хяналт шалгалтад шилжүүлэх, банкний дахин хөрөнгөжүүлэх хэлбэрээр банкны салбарын тогтвортой байдлыг хангах, хадгаламжийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож Хадгаламжийн даатгалын корпорацийн чиг үүрэг, бүрэн эрхийг нэмэгдүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагаас тавьж байгаа зөвлөмж шаардлагыг хангах, санхүүгийн зуучлалыг хөгжүүлж, харилцагчийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах хууль тогтоомжийн төслийг төрийн болон төрийн бус байгууллага, банк, банк бус санхүүгийн байгууллага, олон нийтийн оролцоотой хамтран боловсруулж хууль санаачлагчид уламжлан УИХ-аар батлуулав. Үүнд:

- Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулиуд багтана.

Шинээр батлагдсан хуулиудын үзэл баримтлал, голлох нэмэлт, өөрчлөлтийг тоймлон дурдвал:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, Төв банкны бодлого, үйл ажиллагаа, удирдлага, засаглалын талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдөж тогтсон сайн туршлага, жишгийг нэвтрүүлж, мөнгө, санхүү, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хуулийн үзэл

баримтлал чиглэгдсэн болно. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан уг хуулиар Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын хорооны эрх зүйн байдлыг хуульчилж, Монголбанкнаас макро зохистой бодлого хэрэгжүүлэх, Засгийн газартай харилцах, банкинд зээл олгох, банкны үйл ажиллагаанд хяналт тавих талаарх зохицуулалтыг шинэчлэн тусгаснаас гадна Монголбанкнаас өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж байсан эдийн засгийн тодорхой салбар, тухайлсан этгээдийг дэмжсэн, төсвийн шинжтэй үйл ажиллагааг хориглосон болно.

Уг хуулийг дагалдан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт орсноос гадна Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоол батлагдав.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг банк үүсгэн байгуулагч, удирдлагад тавих шалгуурыг сайжруулах, банкны эрсдэлийг бууруулах, банкинд авах албадлагын арга хэмжээг зөвхөн зөрчил гарсны дараа бус, зөрчил үүсч болзошгүй эрсдэлийн түвшинд хүрсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх байдлаар хэрэгжүүлж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний эрх зүйн үндэслэлийг шинээр тогтоох, албадлагын арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх, албадлагын арга хэмжээг банкны хяналт шалгалтаар тогтоосон дутагдал, эрсдэлийн түвшинд үндэслэдэг байх үзэл баримтлалаар боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлав.

Хуулийн шинэчлэлээр харилцан хамаарал бүхий этгээдийг шинээр тодорхойлж, банкны удирдлагад тавих шаардлагыг нэмэгдүүлж, банкны эрсдэлтэй үйл ажиллагааг хязгаарлан, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлснээс гадна банкны салбарын алдагдал, тогтворгүй байдлын зардлыг төр, татвар төлөгчид бус банк, түүний хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч хариуцдаг байх шинэ арга хэрэгсэл болох “өр төлбөрийг өөрийн хөрөнгөд хөрвүүлэх”, “банкны тогтворжуулалтын сан”-г бүрдүүлэхээр заасан болно. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсан бөгөөд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оров.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

Хадгаламжийн даатгалын тогтолцоог Олон улсын Хадгаламжийн даатгагчдын холбооны “Хадгаламжийн даатгалын үр дүнтэй тогтолцооны үндсэн зарчим”-д тусгагдсан Хадгаламжийн даатгалын корпорацийн засаглал, хамтын ажиллагаа, сангийн эх үүсвэр, зарцуулалт, даатгалын хамрах хүрээ, хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох зарчмуудтай нийцүүлэх үзэл баримтлалын хүрээнд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдөр батлав.

Хуулийн шинэчлэлээр даатгалын тохиолдлыг тооцох, даатгалын хураамж тооцох хэмжээг тодорхой болгох, хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөх хэлбэрийг банкинд данс нээж шилжүүлэх байдлаар өргөжүүлж, нөхөн төлбөр олгож эхлэх хугацааг богиносгох, хадгаламж эзэмшигчид хадгаламжийн шаардах эрхээ хангах боломжит хугацаа олгох, банкинд бүтцийн өөрчлөлт хийх, эрх хүлээн авах үед хадгаламжийн даатгалын корпорацийн оролцоо, эрх үүргийг тодорхой болгох агуулга бүхий өөрчлөлт орсон болно.

Уг хуулийг дагалдан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оров.

Мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (“ФАТФ”)-ын 40 зөвлөмжид нийцүүлэх хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хөгжил, техник технологийн өөрчлөлтөд нийцүүлэн “мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг өргөжүүлэх, уг этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий үзэл баримтлалаар боловсруулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаас 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр батлав.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хөгжил, техник технологийн өөрчлөлтөд нийцүүлэн “мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг өргөжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгах, Засгийн газрын түвшний Үндэсний зөвлөлтэй байх зохицуулалтыг хуульчлав.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдаж, Эрүүгийн хууль, Терроризмтэй тэмцэх тухай, Гаалийн тухай, Шуудангийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Нотариатын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оров.

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль:

Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор банкны салбарт хийгдэж байгаа бүтцийн өөрчлөлтийн бодлогын арга хэмжээ, банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлэх үзэл баримтлал бүхий Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг Улсын Их Хурлаас 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталсан. Тус хуулиар банкинд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах талаар хугацаатай үүрэг өгөх, өөрийн хөрөнгийн шаардлагыг банк, банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, банкны алдагдлыг банкны хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчид хариуцах, шаардлагатай тохиолдолд банкнаас дахин хөрөнгөжүүлэх хүсэлт төрд гаргах, хүсэлтийг шийдвэрлэх, төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх нөхцөл, хэлбэр, үйл ажиллагаа, банкинд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэх, төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкинд хийх хяналт шалгалт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг тодорхойлсон болно. Тус хуулийг дагалдан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон болно.

Дээр дурдсан хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эдгээр хуульд Монголбанкнаас батлахаар заасан мөнгөний бодлого, банкны хяналт шалгалт, төлбөрийн систем, хуульд заасан шаардлага хангасан банкныг төрөөс дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой журам, захиргааны хэм хэмжээний актыг боловсруулан баталж, мөрдүүлэн ажиллаж байна.

Мөн тайлант хугацаанд Валютын нэгдсэн зохицуулалтыг бий болгох, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдал, үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд валютын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, валютын гадаад, дотоод урсгал, гадаад секторын статистик, тоон мэдээллийн чанарыг олон улсын жишигт нийцүүлэх, биржийн болон биржийн бус арилжаа, эдийн засгийн харьяат,

харьяат бусын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн саналыг боловсруулж, хууль санаачлагчид уламжлан, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой Актив удирдлагын тухай хуулийн төслийн саналыг хууль санаачлагчид уламжилсан бол Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох, тус харилцаанд оролцогч этгээдийн эрх зүйн байдлыг сайжруулах, санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулсан болно. Монголбанкнаас Монгол Улсын Эрдэнэсийн сан эрхлэх үйл ажиллагааны хүрээнд Эрдэнэсийн санд байх түүх, соёлын өвд тавигдах шаардлагыг тодорхой болгох, соёлын өвийг хамгаалахтай холбоотой Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанкны үйл ажиллагааг боловсронгуй болгох, Эрдэнэсийн сангийн өмчлөл, эзэмшлийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор үнэт металлын сорьцыг тогтоох эрх бүхий этгээдэд холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав.

Векселийн тухай хуулийн зохицуулах харилцааг олон улсын жишигт нийцүүлэх хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор Векселийн тухайн хуулийг гадаад улс орнуудын векселийн эрх зүйн зохицуулалтыг хөгжлийн төвшин болон бүс нутгаар нь судалж, олон улсын жишигт нийцүүлэх, хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, манай орны эдийн засгийн онцлог, санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин зэргийг харгалзан шинэчиллээ.

Мөн тайлант хугацаанд хэрэглэгч-санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын мэдээллийн болон эрх мэдлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг бууруулж, тэнвэртэй байдлыг хангах, санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, салбарын итгэлцлийг дээшлүүлэх, эрүүл өрсөлдөөнт зах зээлийг бий болгоход хувь нэмэр оруулах зорилгоор Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийн саналыг боловсруулав.

2.6 ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, БСШУЯ (хуучин нэрээр) хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэв.

Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүнгүүд гарна:

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ.
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно.
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна.
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна.
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголт зэрэг сэдэв багтана.

2018 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийв. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийн Зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2018 оны 11-р сарын 15-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 84-р тогтоолын Зорилт 3.2 “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ” хэмээн тусгагдав.

Төв банк (Монголбанкны)-ны тухай хууль

2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулснаар Монголбанкны үйл ажиллагааны чиглэлд “Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” заалт батлагдсан болно.

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”

Зорилт 11. Төрийн болон санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд “Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” ажил хийгдэж байна.

“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”

2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Монголбанкны ерөнхийлөгчийн А/203 тушаалаар батлагдсан тус журмын “Мэдээллийн ил тод байдал”-хэсэгт санхүүгийн харилцагчийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэл багтсан болно.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Банк Санхүүгийн Академийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монголбанк болон Хадгаламжийн Даатгалын Корпорацитай хамтран "Өнөр бүл" хүүхдийн төв болон "Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн төв"-ийн 15-18 насны хүүхдүүдэд 5 сард хувийн санхүүгээ удирдах, санхүүгийн суурь боловсрол олгоход зориулсан хөтөлбөрөөр дэмжин оролцлоо. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлэгт санхүүгийн суурь ойлголтуудыг шат дараатайгаар олгож, бие даан амьдрахад нь зайлшгүй шаардагдах санхүүгийн мэдлэгт суралцуулах замаар ирээдүйгээ өөрсдөө бүтээх чадварт сургах нь энэхүү аяны зорилго юм.

Банкуудын зүгээс дараах 5 сэдвээр мэдлэг мэдээлэл өгч, банкны үйл ажиллагаатай танилцах аяллыг хийхийн зэрэгцээ тухайн сонгосон сэдвээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, ирээдүйн харилцагчдаа бэлтгэхэд хамтран ажиллалаа.

Аяны хүрээнд хийсэн сургалтын сэдвүүд нь:

- Орлого ба зардал /Хас банк/
- Хуримтлал ба хадгаламж /Ариг банк/
- Өр ба зээл, хүүгийн тухай ойлголт /Худалдаа Хөгжлийн Банк/
- Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, тэдгээрийн тухай ойлголт /Хаан банк/
- Эрсдэл ба даатгал /Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк/
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид сонгон судлахаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн А/453 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар батлав.
- 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн ухааны 30 арга зүйч нарт 12 ангид үзэх “Бизнес судлал” хичээлийн талаарх сургалтыг БСПУСЯ-аас зохион байгуулав.
- Ерөнхий боловсролын сургуулийн “Бизнес судлал” сонгон судлах хичээлийн 11,12 дугаар ангийн багшийн ном боловсруулан хэвлэв.
- Хүүхдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох “Анар, Ану 2”-ын 3 төрлийн цуврал комик ном 9000 хувь хэвлэгдэж ерөнхий боловсролын сургууль, орон нутаг болон санхүүгийн боловсрол олгох арга хэмжээнүүдэд түгээн ажиллав.
- Олон улсын Мөнгөний долоо хоног буюу (Global Money week)-тэй холбогдуулан “Дэлхийн мөнгөний долоо хоног-2018”-д хүүхэд залууст мөнгөний талаарх ойлголт, мэдлэгийг өгөх цуврал өдөрлөгүүдийг зохион байгуулж Монголбанк, Монголын Банкны Холбоо, арилжааны банкууд хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 700 сургачдад “Мөнгөний асуудал бол чухал” сэдвээр хичээл орж Төв банкны Эрдэнэсийн сангаар зочлуллаа.
- Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” сан болон арилжааны 10 банк хамтран Дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан “Хуримтлалын аян”-ыг 10 дугаар сарын 22-ноос эхлүүлэн Дэлхийн хуримтлалын өдрийн арга хэмжээг 31-нд Улаанбаатар хотод, 11 дүгээр сарын 2-ний өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд банкууд хүүхэд багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласан юм. Түүнчлэн Монголбанк болон ХБНГУ-ын “Шпаркассе” сангийн зүгээс хуримтлал үүсгэхийн ач тус давуу талыг танилцуулсан гарын авлага, ном товхимлуудаа хүүхэд багачуудад танилцууллаа. Мөн энэ үеэр Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс хүүхэд багачуудын дунд асуулт, хариултын тэмцээн зохион байгуулж, зөв хариулсан хүүхдүүдэд 50 мянган төгрөгийн “Хадгаламжийн сертификат” гардуулж ажилласан. Мөн энэ жилийн “Дэлхийн хуримтлалын өдөр-2018” аянд нийт 10 банк идэвхтэй оролцож, хүүхэд залуусын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, хуримтлалын ач тусыг тайлбарлан таниулахад анхаарч ажилласан. Аянд идэвхтэй оролцсон шилдэг 3 банкаар Тээвэр Хөгжлийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банкны хамт олон шалгарлаа.

Залууст санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” сэдэвт (1 кредит) хичээлийг бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор боловсруулсан бөгөөд хөтөлбөр хэрэгжсэнээс хойш тус хичээлийг 13 их дээд сургууль сургалтын хөтөлбөрт оруулснаас 2018 онд Эдийн засгийн Үндэсний Дээд Сургууль, Хууль сахиулах их сургууль, Дорнод их сургууль сургалтын хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна.
- ХНХЯ-тай хамтран политехник коллеж, мэргэжлийн боловсрол-сургалтын төвийн хөтөлбөрт

“Хувь хүний санхүүгийн мэдлэг”, “Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэлт”, “Эдийн засгийн онол”-ийн хичээлийг заах 21 аймгийн 45, Улаанбаатар хотын 48 мэргэжлийн багш нар “Сургагч багш” бэлтгэх сургалтад хамрагдаж “Гэрчилгээ” гардан авлаа.

- Монголбанк болон Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үндэсний хэмжээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх, жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчдийн бүртгэл, тайлагналын чанарыг сайжруулах, салбарын мэргэжилтний чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамтран оролцох, хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлэх зорилгоор “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгууллаа.

Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох 9 төрлийн гарын авлагыг дараах сэдвүүдээр сажруулалт хийн 19 000 хувийг хэвлүүлэв: Төв банк юу хийдэг вэ? Мөнгөө хэрхэн удирдах вэ? Өрхийн төсөв, хуримтлал ба хадгаламж, зээл, үний түвшин, валютын ханш, таны санхүүгийн мэдлэгт, өрхийн төсвийн дэвтэр зэрэг болно.
- Монголбанкны орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна.
- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран Насан туршийн боловсролын үндэсний төвийн орон нутгийн төвүүдтэй хамтран Говь-Алтай, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Завхан, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Улаанбаатар хотын дүүргийн нийт 265 багшийг “Сургагч Багш”-ийн сургалтад хамруулан иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулан 22,140 иргэнд хүрч ажиллав.

Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiinbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- Иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ удирдах, хяналттай төсөв зохиох, “Төсөвчин” аппликейшн IOS, android үйлдлийн системд нэвтэрч хэрэглэгчдэд түгээн ажиллав.
- “Монголбанкны мэдээлэл” сар бүрийн товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна.
- Санхүүгийн боловсрол олгох 3 төрлийн богино хэмжээний видео боловсруулж олон нийтэд түгээв. Үүнд: валютын ханш, зээлийн мэдээллийн сан, тэтгэврийн зээл.
- “Санхүүгийн боловсрол” фэйсбүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган ажиллалаа.

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяны хүрээнд:

2018 оны 1 дүгээр сарын 02-ноос 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх 5 сарын хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян”-ыг зохион байгууллаа.

Аяны хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын Ипотекийн Корпораци, Монголын банкны холбоо болон арилжааны нийт банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Монголбанкны орон нутагт дахь хэлтэс салбар зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран оролцлоо.

Энэхүү аянаараа бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан авч буй хувь хүн, бичил аж ахуйн нэгж, ирээдүйн санхүүгийн хэрэглэгчид рүү чиглэсэн суурь мэдлэг олгох, эрх үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах, ингэснээр гарч болох санхүүгийн олон талт эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах чадвар суулгахын зэрэгцээ нөгөө талаар, СҮҮ-ийг санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар санхүүгийн хэрэглэгч буюу иргэд-харилцагчдад хүртэж болох

ашиг, үүсэж болох эрсдэл, санхүүгийн бусад нөхцөлийг үнэн зөв, ойлгомжтой тайлбарлах, сонголт хийх боломж олгох зэрэг үйл ажиллагааг хэвшүүлэхийг зорьж ажиллав.

Аяны хүрээнд хийгдэх ажлын 5 сарын дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөг гаргаж, сар тус бүрт хийгдсэн үйл ажиллагааг 5 сэдвийн доор удирдан зохион байгуулж ажиллав. Үүнд:

- СҮҮ-ийн Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл өгөх аргачлал,
- Санхүүгийн хэрэглэгчийн хувийн мэдээлэл, нууцлалын аюулгүй байдал, түүний хамгаалалт;
- Санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх,
- Төлбөрийн карт, түүний зохистой хэрэглээ, аюулгүй байдал,
- Орон сууцны ипотекийн зээл, зээлийн мэдээллийн сан гэсэн 5 ерөнхий сэдвийн хүрээнд танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг нийгмийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж, ТВ, радиогийн ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэгт оролцож, сургалт, уулзалт, өдөрлөг хийх хэлбэрээр аяныг олон нийтэд хүртээмжтэй хүргэхийг зорьсны үр дүнд:
- "Сайн засаглал" сэтгүүлийн нэг улирлын дугаарыг “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцооны өнөөгийн байдал, БСХС–тай хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь ямар ач холбогдолтой вэ?” сэдвийн хүрээнд гаргаж, иргэд, олон нийтэд зориулсан “Санхүүгийн хэрэглэгч танаа” 10,000 ширхэг гарын авлага, 3000 постер, 5000 ширхэг нугалбар болон бусад холбогдох хэвлэмэл материалуудыг давхардсан тоогоор 18000 хэвлүүлж, Улаанбаатар хотын 14 банкны төв аппарат, Орон нутагт дахь төр захиргааны байгууллагууд болон Монгол Улсын 21 аймаг дахь банкны 119 салбар, сумын төв, алслагдсан сууринд байрлах 852 тооцооны төвөөр дамжуулан нийт 17000 иргэд, аж ахуйн нэгжид хүргэж ажилласан байна.
- БСХС, МИК болон Банкуудтай хамтран аяны хүрээнд зохион байгуулсан нийт 115 сургалт, семинар, уулзалтыг их, дээд сургуулийн оюутнууд, сургагч багш нар, сэтгүүлчид, төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгчид гэсэн тус тусын ЗОРИЛТОТ бүлэг рүү чиглүүлж ажилласны үр дүнд уг үйл ажиллагаанд давхардсан тоогоор Улаанбаатар хотын хэмжээнд нийт 45000 иргэн, аж ахуйн нэгж, аймгийн төвийн болон сумдын хэмжээнд нийт давхардсан тоогоор 59600 иргэд хамрагдсан байна.
- Аяны хүрээнд мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг нийгмийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж ажиллалаа. Цахим, сошиал орчин болоод нийт 121 удаагийн ТВ, радиогийн ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэгт оролцож ажилласан байна. Банкууд өөр, өөрсдийн цахим хуудаснаа Мэдээлэл, Аюулгүй байдлын зөвлөмж цэсийг шинээр байршуулж, мэдээ мэдээлэл, танилцуулга видео шторк, зөвлөмжүүдийг тогтмол байршуулж, тэдгээрийг өөрсдийн харилцагчдад хүргэсэн үзүүлэлтийг харуулбал 1,500,000 хүрсэн байна.
- Аяны хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нийт 650,000 харилцагчийн гомдол, санал, хүсэлтэд зөвлөгөө өгч шийдвэрлэж ажиллалаа. Аяны хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэг удаагийн чанаргүй зээлийн түүхтэй 41000 гаруй иргэний зээлийн мэдээллийг лавлагаанд тусгахгүй байхаар шийдвэрлэсэн.
- Аян хэрэгжүүлсэн нийт 5 сарын хугацаанд “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” хуулийн төслийн тандан судалгааг орон нутаг даяар давхар гүйцэтгэж, нийт 4000 иргэнийг судалгаанд хамруулсан.
- 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр буюу "Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр"-ийг ШӨХТГ, СЗХ, ХДК –тай хамтран “Цахим орчин дахь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” сэдвийн доор нээлттэй хаалганы өдөрлөгийг ОРОН ДАЯАР зохион байгуулж өнгөрүүлснээрээ онцлог болж чадсан.
- Аяны хүрээнд банкууд өөрсдийн нэгдсэн санаачилгаар “Банкны салбарт хэрэглэгчийг хамгаалах нэгдсэн стандарт”-ыг боловсруулж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр боллоо.

Харилцагч байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал:*Дэлхийн банк*

Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн эхний шатны мониторинг хийх зөвлөмжийг олон улсын экспертүүдийн баг ажиллан Монголбанкинд хүлээлгэн өгөв.

Германы Хадгаламжийн банкны ОУ-ын хамтын ажиллагааны сан

Монголбанк, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын сан, Монголын банкны холбоотой хамтран “Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийн эхний шат дуусан Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” банкны сан, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассэ” банк хооронд “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 3 жилийн хугацаатай байгууллаа.

Тус санамж бичигт оролцогч талууд хамтран:

- Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжлийг банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалт, хүүхэд залуусын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрөөр дамжуулан эрчимжүүлэх,
- Банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалтын чанарыг тогтвортой байлгах;
- Төсөлд идэвхтэй оролцож буй банкуудын мэргэжилтнүүд болон удирдах албан тушаалтнуудад зориулан хэрэгцээт сэдвийн дагуу тусгайлсан семинарыг зохион байгуулах,
- “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийн аяныг үргэлжлүүлж, Монголбанк болон арилжааны банкуудтай хамтран жил бүр хамрах хүрээг тэлэх;
- “Шпаркассэ” банкны сан нь өөрсдийн санхүүгийн нэгдлийн туршлагаас хуваалцах, эдгээр үндсэн 5 чиглэлийн ажлыг хэрэгжүүлнэ.

Төслийн хүрээнд 2018 онд хийсэн ажил:

- Төслийн хүрээнд нийт 26 мастер сургагч багш анхан болон ахисан шатны сургалтууд зохион байгууллаа.
- Онол, практик хослуулсан сургалтыг 12 арилжааны банкнаас бүрдсэн нийт 41 оролцогчийг 7 модуль хичээлээр амжилттай бэлтгэв.
- Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” сан болон арилжааны 10 банк хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2018” аяныг 10 дугаар сард хүүхэд залуусын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, хуримтлалын ач тусыг тайлбарлан таниулахад анхаарч амжилттай зохион байгуулав.

“Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалт”

Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалт нь жил бүр зохион байгуулагддаг чухал арга хэмжээ бөгөөд Aflatoun international олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Ази тивийн улс орнуудын санхүү, нийгмийн боловсролыг дэмжих үйл ажиллагаа болон шинээр нэвтэрч буй туршлагын талаар хэлэлцэж, хуваалцдаг уулзалт болон хэвшжээ.

Энэ удаагийн чуулга уулзалтыг БНХАУ-ын “Be Better” олон улсын байгууллагаас зохион байгуулсан ба 2018 оны 11-р сарын 11-нээс 16-ны өдрийг сонгосон нь 4 дэх удаагаа болж байгаа БНХАУ-ын Боловсролын Инновацийн Экспотой давхцуулж, түүний хүрээнд хийх зорилготой байсан аж. Өөрөөр хэлбэл энэхүү чуулга уулзалт нь илүү том арга хэмжээний нэг хэсэг болсноороо онцлог юм. БНХАУ-ын Боловсролын Инновацийн Экспод 187 боловсролын их сургууль, коллеж болон нийт 50,000 орчим зочин оролцсон байна.

Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалтад Энэтхэг, Бангладеш, Филиппин, Шри Ланк, Пакистан, Индонез, Малайз, БНХАУ зэрэг Азийн 15 орноос санхүүгийн боловсролын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Боловсролын яамд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон болно.

Монголбанкны хувьд Үндэсний хөтөлбөрийг тэргүүлэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд тус арга хэмжээнд оролцох нь зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд олон улсын хэмжээнд хөтөлбөрийн чиглэл, үйл ажиллагааг амжилттай танилцуулав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ

Монголбанк нь ЭЗХАХБ/СБОУС-ний бүрэн эрхт гишүүн бөгөөд 2018 оны 10 дугаар сард ОХУ-ын Москва хотно зохион байгуулагдсан техникийн хорооны 10-р хурал, ЭЗХАХБ-ОХУ-ын Симпозиум: "Дэлхий дахины санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх: хэрэгжилт, шинэчлэл"- д тус тус оролцов. Техникийн зөвлөлийн хурал болон Симпозиум нь санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд дэлхий нийтийн дэвшилтийг бий болгохын тулд хэрэгжүүлэх шинэлэг арга барилд анхаарлаа төвлөрүүлэх чиглэлээр зохион байгуулав. Энэ нь санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн боловсрол олгох, залуучууд, шилжин суурьшигчид гэх мэт эмзэг бүлгийнхэнд санхүүгийн боловсрол олгож, санхүүгийн шийдвэр гаргах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга замыг тодорхойлох, зээлийн шийдвэр, үр дүнг сайжруулахад чиглэсэн чиг хандлагыг хэлэлцэв. 50 гаруй орны 200 гаруй мэргэжилтэн оролцсон бөгөөд засгийн газар, төв банк, санхүүгийн институт, ашгийн бус байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, хувийн болон иргэний салбарын төлөөлөгчид оролцсон болно.

3.1 ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болдог.

Монголбанк 2018 онд хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр харилцан адилгүй дараах төрлийн ТБҮЦ-ны арилжааг зохион байгуулсан байна. Үүнд:


2018 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хүүний дээд хязгаартай, хэмжээг хязгаарлаагүй хэлбэрээр 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг Даваа, Лхагва, Баасан гарагт арилжааллаа. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү байх бөгөөд банк хоорондын зах дээр хөтөч хүүний үүргийг гүйцэтгэж, банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэгтэй байдаг.

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн урт хугацаат санхүүгийн хэрэгслийг мөнгөний зах дээр бий болгож, банк хоорондын захад зохистой өгөөжийн муруйг бий болгох зорилгоор 28 хоногтой Төв банкны үнэт цаасыг хүүний дээд хязгаартай, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр 7 хоногт 1 удаа буюу Даваа гараг бүр зохион байгуулав.

Түүнчлэн 28 хоногтой ТБҮЦ-ыг арилжаалахын хамт 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс банк хоорондын захын байнгын шинжтэй, бүтцийн илүүдэл нөөцийг шингээх, харьцангуй урт хугацаат ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, мөн хүүний өгөөжийн муруйн эхлэлийг бий болгох үүднээс 196 хоногтой ТБҮЦ-ны арилжааг 2 долоо хоногт нэг удаа, Лхагва гарагт арилжаалж байна.

ТБҮЦ-ны үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэрлэсэн дүнгээр 5,063.5 тэрбум төгрөг болж, оны эхнээс 1,615.7 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт үнэт цаасны 86.2 хувийг 28 хоногийн хугацаатай, 13.8 хувийг 196 хоногийн хугацаатай үнэт цаас тус тус эзэлж байсан. ТБҮЦ-ны өсөлт нь Гадаад цэвэр активын өөрчлөлт (Цэвэр дүнгээр 388.3 тэрбум төгрөг нийлүүлсэн) болон Засгийн газрын цэвэр зээл (Засгийн газрын үнэт цаасны 1,746.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт)-ийн өөрчлөлтөөс голлон шалтгаалав.

Зураг 1. ТБҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг, хугацаагаар)



Эх сурвалж: Монголбанк

3.2 ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зохистой түвшинд удирдах зорилгоор банкны системд мөнгөн хөрөнгө нийлүүлэхдээ өдрийн зээл, репо санхүүжилт, репо арилжаа зэрэг хэрэгслийг ашиглаж байна. Эдгээр нь хугацаа, хэлбэр, хүү, зориулалтаараа ялгаатай юм. Монголбанкны санхүүжилтийн хэрэгслүүд бүгд барьцаа хөрөнгө шаарддаг бөгөөд барьцааны төрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-262 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Тайлант онд Монголбанк мөнгөний бодлогын хэрэгслүүдээр дамжуулан банкуудад давтагдсан тоогоор нийт 1,142.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

Өдрийн зээл

Өдрийн зээл нь банкны төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учирсан нөхцөлд Монголбанкнаас банкинд олгож буй санхүүжилтийн хэрэгсэл юм. Өдрийн зээл нь тухайн өдөрт багтан эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй репо хэлцэл юм. Тайлант онд өдрийн зээл олгогдоогүй байна.

Репо санхүүжилт

Монголбанкнаас олгох репо санхүүжилт нь мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх, банкуудад заавал байлгах нөөцийн шаардлага хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой санхүүжилтийн байнгын хэрэгсэл юм. Төв банкны репо санхүүжилтийн журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-192 дугаар тушаалаар шинэчлэн баталж, тус журмаар репо санхүүжилтийг 90 хүртэл хоногийн хугацаатай болгосон. Ингэснээр бодлогын хүүтэй уялдсан харьцангуй урт хугацаатай байнгын санхүүжилтийн хэрэгсэлтэй болсноор мөнгөний бодлогын хүүний банкуудын хадгаламжийн хүүнд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, банк хоорондын захад өгөөжийн муруйны эхлэлийн хэсэг дэх бодлогын хүүний нөлөө сайжрах зэрэг давуу талтай болно.

Репо санхүүжилтийн хүү нь Төв банкны хүүгийн коридорын дээд хязгаар буюу бодлогын хүүн дээр 2 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Тайлант онд 34 удаагийн хэлцлээр нийт 1,142.7 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг Монголбанкнаас банкуудад олгосон бөгөөд оны эцсийн байдлаар 254.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Овернайт хадгаламж

Төв банкны овернайт хадгаламж нь банк хоорондын илүүдэл нөөцийг татан төвлөрүүлэх хэрэгсэл юм. Тус хэлцлийг банкны хүсэлтээр, тухайн ажлын өдрийн хамгийн сүүлийн, дараагийн ажлын өдрийн хамгийн эхний гүйлгээ байхаар тогтоосон байдаг. Овернайт хадгаламжийн хүү нь Төв банкны хүүний коридорын доод хязгаар буюу бодлогын хүүнээс 2 хувийг хассантай тэнцүү байна. Тайлант онд Монголбанк давхардсан тоогоор 410 удаагийн 17,119.6 тэрбум төгрөгийн овернайт хадгаламжийн хэлцлийг банкуудтай байгуулсан. Оны эцсийн байдлаар 274.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа нь банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцэл юм. Банкны системд хөрөнгийн дутагдал бий болсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан тохиолдолд төв банк 7 хүртэл хоногийн хугацаатай санхүүжилтийг банкуудад репо арилжаагаар олгодог. Тайлант онд репо арилжаа хийгээгүй байна.

Барьцаат зээл

“Монголбанк” банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд банкинд барьцаат зээл олгодог.

Шинэчлэн найруулсан Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон олон улсын жишигт нийцүүлэн “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-174 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Тайлант онд Монголбанк банкинд барьцаат зээл олгоогүй бөгөөд нэг банкны 14.4 тэрбум төгрөгийн зээл төлөгдөж, 2018 оны эцсийн байдлаар барьцаат зээлийн үлдэгдэлгүй болов.


3.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ЗГҮЦ)

ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогдож, хүүгийн орлого нь татвараас чөлөөлөгддөг давуу талтай.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд арилжааны банк харилцагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон тул Монголбанкаар дамжин арилжаалагдах ЗГҮЦ-ны арилжаанд зөвхөн банкууд оролцох боломжтой байна. Гэхдээ иргэд, ААНБ-ууд өөрсдийн харилцагч брокер, дилерийн компаниар дамжуулан Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ээр дамжин арилжаалж байгаа ЗГҮЦ-ны арилжаанд оролцох боломжтой.

Сангийн яамны шийдвэрийн дагуу 2018 онд ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаа зарлагдаагүй бөгөөд Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл 1,449.7 тэрбум төгрөгөөр буурч, оны эцэст 128.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. ЗГҮЦ-ыг хуваарийн дагуу тогтмол арилжаалах нь зах зээлд эрсдэлгүй үнэт цаасны өгөөжийн муруйг бий болгох, банкны систем дэх илүүдэл нөөцийг урт хугацаанд шингээх замаар мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах ач холбогдолтой.

Зураг 2. Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл (тэрбум ₮)



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1. ЗГҮЦ-ны хоёрдогч захын үйл ажиллагаа

ЗГҮЦ-ын хоёрдогч захад хийгдсэн арилжааны дүн /багцын тоогоор/			
/Огноо	i/ Богино хугацаат	ii/ Урт хугацаат	/i+ii/ Нийт
2018 оны 1 сар	220.00	-	220.00
2018 оны 2 сар	900.00	-	900.00
2018 оны 3 сар	-	-	-
2018 оны 4 сар	-	-	-
2018 оны 5 сар	-	-	-
2018 оны 6 сар	-	300.00	300.00
2018 оны 7 сар	84,500.00	30,704.00	115,204.00
2018 оны 8 сар	-	-	-
2018 оны 9 сар	-	-	-
2018 оны 10 сар	-	704.00	704.00
2018 оны 11 сар	-	-	-
2018 оны 12 сар	-	-	-
НИЙТ	85,620.00	31,708.00	117,328.00

Эх сурвалж: Монголбанк

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд ЗГҮЦ-ыг мөнгөний бодлогын хэрэгсэлд ашиглахад үүсч буй хүндрэлийг арилгах, банк хоорондын арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор ЗГҮЦ-ны арилжааны програмд хоёрдогч захын арилжаатай холбоотой өөрчлөлт оруулах, сайжруулах чиглэлээр Сангийн яам болон ҮЦГХТ ХХК-д хамтран ажиллах саналыг

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар 2013 онд батлагдсан “ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ын дагуу 2018 онд нийт 117.3 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ хоёрдогч зах дээр арилжаалагдсан байна. Үүнээс 85.6 тэрбум төгрөг нь Засгийн газрын богино хугацаат, 31.7 тэрбум төгрөг нь Засгийн газрын урт хугацаат үнэт цаас байв.

хүргүүлж, програм сайжруулалтын асуудлыг шийдвэрлэх хүртэл эзэмшигчийн мэдээллийг сар бүрийн эцэст ҮЦТХТ-ээс ирүүлж байхаар шийдвэрлэв.

Мөн ТБҮЦ болон ЗГҮЦ-ны хоёрдогч захыг хөгжүүлэх, банк хоорондын арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, оролцогчдын тоог өсгөх чиглэлээр Цахим арилжааны ерөнхий гэрээ, Үнэт цаас худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээнүүдэд холбогдох өөрчлөлтийг оруулан, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци зэрэг оролцогчдын тоог нэмэгдүүлэв.

3.4 ГАДААД ВАЛЮТЫН ХУДАЛДАА

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож ирлээ. Улмаар 2018 оны 2 дугаар хагаст валютын зах дээр эдийн засгийн идэвхжил болон гадаад хүчин зүйлсийн нөлөөнөөс шалтгаалан үүссэн валютын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагын дагуу Монголбанкны валютын захад хийсэн оролцооны хэмжээ өмнөх онтой харьцуулахад нэмэгджээ.

Монголбанкнаас 2018 онд 103 удаагийн гадаад валютын дуудлага худалдаагаар цэвэр дүнгээр 1,015.6 сая ам.долларыг валютын захад нийлүүлсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад ам.долларын арилжаа 13 дахин буюу 937.3 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Зураг 3. Ам.доллар, юанийн дуудлага худалдаа /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос байгуулж эхэлсэн. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, банкуудын гадаад эх үүсвэрийн өртөг нэмэгдэж байгаа зэргийг харгалзаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А-69 дугаар тушаалаар урт хугацаат своп хэлцлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, урт хугацаат своп хэлцлийн өртгийг бууруулсан. Ингэснээр банкуудын хувьд гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг төгрөгт хөрвүүлэх зардал буурсан нь зах зээл дэх хүүний түвшин буурахад нөлөөлөх нэг үзүүлэлт болов.

Монголбанкнаас тайлант онд богино хугацаат своп хэлцэл байгуулаагүй байна. Харин урт хугацаат своп хэлцлийн хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан нэг жилээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрээр ам.долларын урт хугацаат своп хэлцэл байгуулж байгаа бөгөөд 2018 онд нийт 608.4 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулснаас 551.9 сая ам.доллар нь бодит бус хэлцлийн төрөлд хамаарч байна. Нийт байгуулсан хэлцлийн дүнг 2017 онтой харьцуулбал 2.5 дахин

буюу 362.9 сая ам.доллараар өссөн байв. Харин тайлант онд нийт 296.2 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусч төлбөр тооцоог гүйцэтгэсэн бөгөөд урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 312.2 сая ам.доллараар өсч 1580.2 сая ам.долларт хүрэв.

3.5 ДОТООД ЗАХ ЗЭЭЛЭЭС АЛТ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Ашигт малтмалын тухай хууль”-д 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү болгосноор, Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2014 оноос тогтмол нэмэгдэв.

Монголбанкны алт худалдан авалтын хэмжээ 2014 онд 13 тонн, 2015 онд 15 тонн, 2016 онд 18 тонн, 2017 онд 20 тонн байсан бол 2018 онд 22 тонн хүрч өмнөх оноос 9.3 хувиар өссөн үзүүлэлттэй байлаа. Монголбанкны 1990-2018 онд худалдан авсан алтны хэмжээг (зураг 4)-т дүрслэн үзүүлээ.

Ийнхүү алт худалдан авалтын хэмжээ өмнөх онуудаас давж биелэхэд 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд Монголбанкнаас “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг улс орон даяар амжилттай хэрэгжүүлсэн нь эергээр нөлөөллөө. Мөн “Алт 2” үндэсний хөтөлбөр, “Лаборатори байгуулах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 275 дугаар тогтоол, “Орон нутагт алт худалдан авах үйл ажиллагааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А-108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Дархан-Уул аймагт 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Баянхонгор аймагт 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн төвийг нээн, алт худалдан авалтыг орон нутагт эхлүүлсэн нь үр дүнгээ өгсөн.

Монголбанк орон нутагт алт худалдан авалтыг эхлүүлснээр 2018 онд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 142 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 80 кг алтыг худалдаж авсан байна.

Зураг 4. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (жилээр)



4.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанк нь 11 газар, 1 төв, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 1 төлөөлөгчийн газартайгаар үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монголбанк 2018 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэд технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Бусад төв банкуудын шилдэг туршлага, жишгийн дагуу Монголбанк Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн (ЭЗССХ)-г шинээр үүсгэн байгуулав. ЭЗССХ нь төв банкны үндсэн чиг үүргээс бусад (жишээ нь, төсвийн бодлого, санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, улс орны эдийн засгийн түүх, хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээл, аж үйлдвэрлэл, хууль ба эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, баялаг, бүс нутгийн эдийн засаг, ХАА, байгалийн баялаг) чиглэлийн бодлогын судалгааны ажил, стратегийн баримт бичиг, тодорхой асуудлаар зөвлөмж гаргах, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн мэргэжлийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэх, хурал зохион байгуулах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. ЭЗССХ-ийн ажиллах хэлбэр, дунд хугацаанд гүйцэтгэх бодлогын судалгааны ажлын төлөвлөгөөг олон улсын туршлагад тулгуурлан боловсруулж, үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлээд байна. Ингэснээр макро эдийн засгийн өргөн хүрээний асуудлуудыг хамарсан, судалгаанд суурилсан бодлогын зөвлөмжүүдийг гарган УИХ, Засгийн газар болон төрийн бусад байгууллагуудад хүргүүлэх, төрийн албан хаагчид болон санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан дунд болон ахисан түвшний сургалт явуулж боломж, чадавхи бүрдэв.

Хүний нөөцийн чадавхыг сайжруулах, удирдлагыг боловсронгуй болгож, өндөр мэдлэг чадвартай боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, ажилтнуудаа тасралтгүй сурган хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Гадаад, дотоод албан томилолт, сургалтад нийт 170 гаруй ажилтан хамрагдсанаас гадна нийт ажилтандаа зориулсан сургалтыг 7 хоног бүр тогтмол зохион байгуулж хэвшээд байна.

Банк санхүүгийн салбарын бүсийн ажилтны зөвлөгөөнийг 2017 онд санаачлан зохион байгуулж, орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсийн удирдлагууд болон мэргэжилтнүүдийн дотоод үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хэлэлцүүлэг уулзалт, сургалтыг зохион байгуулж байв. Харин 2018 оноос хамрах хүрээг өргөжүүлж, орон нутгийн засаг захиргаа, арилжааны банкны удирдлагууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг хийдэг боллоо. Энэ удаа мөнгөний бодлогын шийдвэрийн хэрэгжилт, банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулга хийж, "Банкны эрх зүйн шинэчлэл, хяналт шалгалтын чиг хандлага, цаашдын хамтын ажиллагаа" сэдвээр хэлэлцүүлэг хийлээ.

Сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх замаар Монголбанкны ажилтнуудыг цахим орчинд үр ашигтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хэрэгцээнд цуглуулсан бүх төрлийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, түгээх, ашиглах, түүнд үндэслэн шинжилгээ хийхэд чиглэсэн Мэдээллийн технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийж байна. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд ERP систем нэвтрүүлэх төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, шийдвэр гаргах хэлбэр, үйл явцыг ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

4.2 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанкны гадаад харилцаа, хамтын ажиллагаанд гарсан онцлох үйл явдлууд:

Олон улсын валютын сан/ Дэлхийн банк

- 2018 оны 4 дүгээр сард Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн жилийн ээлжит хуралдаанд оролцож ОУВС-ийн тэргүүн Кристин Лагард, Дэлхийн банкны дэд Ерөнхийлөгч Виктория Кваква болон албаны бусад хүмүүстэй уулзалт хийж Монголд хэрэгжиж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг цаашид тууштай хэрэгжүүлэх талаар санал солилцов.

Олон улсын төлбөр тооцооны банк /BIS/

- 2018 оны 6 дугаар сард Швейцарь улсын Базель хотноо болсон Олон улсын төлбөр тооцооны банкны 88 дахь удаагийн ээлжит хуралд Монголбанкны Ерөнхийлөгч урилгаар оролцсон бөгөөд Олон улсын төлбөр тооцооны банкны гүйцэтгэх захирал Андрей Карстенстэй уулзалт хийн Монгол улс тус банкинд гишүүнээр элсэх тухай хүсэлтээ албан ёсоор гардуулав. Энэ нь Монголбанк Олон улсын төлбөр тооцооны банктай холбоо тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх нэгэн том алхам болов.

Европ

- 2018 оны 9 дүгээр сард ОХУ-ын Сочи хотноо болсон Санхүүгийн хүртээмжийн холбооны олон улсын 10 дугаар форумд оролцож удирдлагуудтай уулзалт хийн Монголбанкны тус холбоон дахь Монголбанкны гишүүнчлэлийг сэргээж, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх санал тавьсан.
- ОХУ-ын Төв банкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчтэй уулзалт зохион байгуулж санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, автоматжуулах болон бусад ажлын хүрээнд хамтран ажиллах санамж бичиг байгуулж 2 орны Төв банкны хамтын ажиллагааг улам өргөжүүлэх талаар санал солилцов.
- Туркийн Төв банктай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийг сэргээж Монголбанкны ажилтнууд тус улсын Төв банкны дэргэдэх сургалтын төвийн хөтөлбөрт өргөнөөр хамрагдах болов.

Ази

- 2018 оны 10 дугаар сард Монголбанкны Ерөнхийлөгч Хятадын Ардын банкны Ерөнхийлөгч И Гантай дээд хэмжээний уулзалт хийж 2 орны Төв банк хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг дахин сунгах, 2019 онд тохиох Монгол улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан 2 орны банк хоорондын дугуй ширээний уулзалтыг 2019 онд өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулах болон бусад ажил хэрэгч, үр дүнтэй арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулах санал тавьсныг Хятадын тал нааштайгаар хүлээн авсан. Энэхүү нь хоёр орны Төв банкны гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжин, дэвшихийн илрэл юм.
- 2018 оны 11 дугаар сард Монголбанкны Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Казахстан улсад албан ёсны айлчлал хийж Евроазийн бүс нутгийн банкир болон санхүүгийн шинжээчдийн туршлага солилцох олон улсын томоохон арга хэмжээ болох “Санхүүжүүлэгчдийн чуулга уулзалт”-д оролцож илтгэл тавьсан бөгөөд Казахстаны тал цаашид банк, санхүүгийн салбарт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.
- Монголбанк, Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын Холбооны Судалгаа, Сургалтын Төвтэй (The SEACEN Centre) хамтран банкны хянан шалгагч нарын ахисан түвшний сургалтыг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 20-ны өдөөр Улаанбаатар хотноо зохион байгуулав. Сургалтыг Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын Холбооны Судалгаа, Сургалтын Төв, Хонг Конг дахь Эрнст энд Янг компаний болон Малайзийн Төв банкны удирдах албан тушаалтнууд илтгэгчээр оролцсон. Азийн 8 орны Төв банкны ахлах хянан шалгагчид шалгалтын үед тулгардаг арилжааны банкны

соёл, ёс зүйн эрсдэлийг үнэлэх онол болон практик хичээл, бусад Төв банкуудын туршлагаас судлан сургалтад хамрагдсан.

- Монголбанк БНСУ-ын Төв банк хооронд 2011 оны 08 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу тус банкнаас хэрэгжүүлдэг “Мэдлэг солилцох хөтөлбөр”-т Монголбанк хоёр дахь жилдээ оролцож байна. Энэ хүрээнд 2017 онд тус банкны санхүүжилтээр хоёр улсын мэргэжилтнүүд “Хямралыг удирдах системийг Монгол Улсад хөгжүүлэх” сэдвээр хамтарсан судалгаа хийсэн бол 2018 онд “Санхүүгийн тогтвортой байдал: Байгууллагын шинж чанар ба Макро зохистой бодлогын хэрэгжилт” сэдвээр судалгааны үр дүнг тайлагнан товхимол хэвлүүлэв.

4.3 ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Монголбанк бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулж, Төв банкны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангах зарчмын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Инфляцийн тайлангийн хүртээмжийг сайжруулах

Төв банкны олон нийттэй харилцах гол арга хэрэгслүүдийн нэг болсон инфляцийн тайланд багтсан дүрслэл, графикуудыг MsExcel форматаар вебсайтад байршуулснаар эдийн засагчид, судлаач нарт тус тайланг ашиглахад дөхөм болсон сайн туршлага боллоо. Түүнчлэн, 2018 оны 2-р улирлаас эхлэн Инфляцийн тайлангийн “Хураангуй” хувилбарыг боловсруулж, олон нийтэд хялбарчилсан байдлаар хүргэдэг болов. Тайланг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан тогтмол түгээж байгаа ба нэгдсэн танилцуулгыг банк, санхүүгийн салбарын мэргэжилтнүүд болон судлаачид, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагч нарт тайлбарлан хүргэдэг болов.

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг тайлбарлан түгээх

Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 03, 06, 09, 11, 12 сарын шийдвэрүүдийг Хэвлэлийн бага хурлаар дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд тухай бүрт хүргэв. Мөн Мөнгөний бодлогын хорооноос гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг эдийн засагт оролцогч талууд буюу судлаач, шинжээчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд тайлбарлахын тулд Монголбанкны албан ёсны веб хуудас, олон нийтийн цахим сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан тогтмол мэдээлэл түгээж байна. Тэдгээрээс дурдвал, Bloomberg, Eagle телевизүүдээр тусгай нэвтрүүлэг бэлтгэн түгээж байгаагаас гадна МБГ-ын удирдлагууд, Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүд сонин, сайт, телевизүүдэд тухай бүр тайлбар ярилцлага өгөв.

Хэвлэлийн бага хурал

Монголбанкны цаг үеийн асуудал, санхүү, банкны салбарын статистик үзүүлэлтийг мэдээлэх, тайлбарлах зорилгоор Хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байна. Ингэхдээ, мөнгөний бодлогын хорооны мэдэгдэл, Монголбанкны хэвлэлийн бага хурал болон цаг үеийн шуурхай хурлын үеэр Фейсбүүк орчинд шууд дамжуулалт хийж хэвшээд байна. Тайланг хугацаанд нийт 17 удаа хэвлэлийн бага хурлыг зохион байгуулснаас Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хурлыг 4 удаа зарлан хуралдуулав. Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь иргэдийн Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, улмаар зах зээл дээрх хүлээлтийг үр дүнтэй удирдахад эерэг нөлөө үзүүлэхийг зорьдог.

Эрдэм шинжилгээний бага хурал, сэтгүүлчдийн нийтлэлийн уралдаан

Эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг хөхиүлэн дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, олон нийтийн эдийн засгийн талаарх ойлголтыг дээшлүүлэх зорилгоор жил бүр болдог Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлыг 5-р сард оюутан болон судлаач гэсэн 2 ангилалд амжилттай зохион байгуулав.

Монголбанк сэтгүүлчдийн эдийн засгийн чиглэлээр дүн шинжилгээ хийх, нийтлэл бичих чадварыг хөхиүлэн дэмжих зорилгоор сэтгүүлчдийн сургалт, нийтлэл бичлэгийн уралдааныг зохион байгуулж ирсэн билээ. Энэ ажлын хүрээнд сар бүр сэтгүүлчдийн сургалтыг хийж, шилдэг эдийн засгийн нийтлэлийн уралдааныг “Төв банкны олон нийттэй харилцах харилцаа” сэдвээр зохион байгуулж, ирсэн бүтээлүүдийг сонгон шалгарууллаа.

Монголбанкны мэдээлэл

“Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 12 дугаар эрхлэн гаргаж, 6000 хувийг хэвлүүлэн дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа. Түүнчлэн, сард хоёр удаагийн давтамжтайгаар Bloomberg ТВ-д “Төв банк ба төгрөг”, Eagle ТВ-д “Монголбанкны мэдээлэл” нэртэйгээр тус бүр 15 минутын нэвтрүүлгийг тусгайлан бэлтгэн гаргав.

Монголбанкны бодлого, шийдвэр, 2017, 2018 онд хэрэгжүүлсэн аяны хэрэгжилт хөдөө, орон нутагт хэрхэн хангагдаж байгааг тандан судлах, Монголбанкны талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, мэдээлэл ямар түвшинд байгааг сурвалжлахаар тусгай нэвтрүүлэг бэлтгэж эхлэв. Эдгээр нэвтрүүлэг нь цуврал болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан бөгөөд 2018 онд Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймгийг хамруулан “Төв банкны бодлого Төвийн бүсийн аймгуудад”, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийг хамруулан “Санхүүгийн боловсрол говь нутгийн иргэдэд”, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Архангай аймгийг хамруулан “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн санд” нэртэйгээр тус бүр 20 минутын нэвтрүүлэг бэлтгэж, олны хүртээл болгоод байна.

Монголбанкны сургагч оюутан-багш

Оюутнуудад Монголбанкны бодлого, үйл ажиллагааг таниулж, санхүү, эдийн засгийн мэдлэг олгох ажлын хүрээнд “Сургагч оюутан багш”-ын сургалтыг 12 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 2000 орчим оюутныг хамруулсан бол “Монголбанкны цаг” арга хэмжээг мөн 15 их, дээд сургуулийн 1700 орчим оюутны оролцоог ханган зохион байгуулав. Тухайлбал, “Монголбанкны цаг” арга хэмжээнд Монголбанкны Ерөнхийлөгч нар, газрын захирлуудыг урьж оролцуулснаар оюутнуудад Монголбанкны удирдлагуудын ажил, мэргэжлийн замнал болон Төв банкны бодлого шийдвэрийн талаарх сонирхолтой лекцүүдийг сонсох боломжийг олгосон ач холбогдолтой арга хэмжээ болов.

4.4 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас 2017 оны 7 дугаар сард Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцооны 2 дахь удаагийн Харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж, улмаар Монгол Улс Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын эрчимтэй хяналтад багтах шалгуур хангасныг зарласан. Монгол Улс нэн түрүүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчноо өөрчлөх, улмаар Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан техникийн болон шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг хангаж ажиллах хугацаат үүрэг даалгавар авсан билээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл болон Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ) хамтран “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г боловсруулж, Монгол Улсын Засгийн газраар 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдөр батлуулав.

Энэ ажлын төлөвлөгөөний хүрээнд Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) болон СМА-ны зүгээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдах Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Терроризмтэй тэмцэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслүүдтэй хамт Олон улсын валютын

сан (ОУВС)-гийн зөвлөхүүдийн саналыг тусгаж боловсруулан, холбогдох байгууллагуудаас санал авч, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, СМА-ны дэргэдэх ХАЗ-өөр хэлэлцүүлэн Засгийн газарт өргөн барьсан бөгөөд Монгол Улсын Их хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон дээр дурдсан дагалдах хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг батлав.

Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг мөн эрсдэлд суурилсан үндсэн дээр хийх, хуулийн нэр томъёоны тодорхойлолтуудыг олон улсын стандартад нийцүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгах зэрэг хуулийн шинэчилсэн найруулгын хэмжээний томоохон өөрчлөлт болов.

Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагааг нэгэн адил хамруулсан. Түүнчлэн үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийн тодорхойлолт болон энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ, бусад холбогдох зохицуулалтыг Эрүүгийн тухай хууль, Терроризмтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулав.

Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Аюулгүйн Зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх үүргийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд тусгав.

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ)-дэд хуульч, нягтлан бодогч болон үнэт металл, үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарыг хамруулж, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хуульд заасан гүйлгээний мэдээллийг тайлагнаж байх үүргийг тодорхой болгов.

2018 оны 10 дугаар сар хүртэл хэрэгжсэн “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан 42 төрлийн арга хэмжээг 22 яам, агентлагийн зүгээс хэрэгжүүлсэн бөгөөд 30 арга хэмжээний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй, 10 нь 80-90 хувийн гүйцэтгэлтэй, 2 нь 80 хувь хүрэхгүй гүйцэтгэлтэй байв.

2018 оны 7 дугаар сард ФАТФ-аас Монгол Улсын эрчимтэй хяналтад байх хугацааг 2019 оны 10 дугаар сар хүртэл дахин 18 сараар сунгаж явцын тайланг 2019 оны 1 дүгээр сард тайлагнахыг үүрэг болгосон билээ. Үүний хүрээнд Монгол Улс техникийн хэрэгжилтийн хангалтгүй үнэлгээ авсан 20 үзүүлэлтийг ахиулах хүсэлтийг АНДББ-д гаргаж, 2019 оны 1 дүгээр сарын 31-нд шууд хэрэгжилт болон техникийн үзүүлэлтийн биелэлтийн тайланг дагалдах мэдээ материалын хамт хүргүүлэхээр бэлтгэж байна.

Эрчимтэй хяналт 2019 оны 10 дугаар сард дууссанаар ФАТФ-аас юуны түрүүнд Монгол Улс Харилцан үнэлгээний тайландаа хангалтгүй үнэлгээ авсан шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүд болон Терроризмын санхүүжилттэй тэмцэх зорилтот санхүүгийн хориг арга хэмжээтэй холбоотой ФАТФ-ын 6 дугаар зөвлөмжийн биелэлт, түүнчлэн Монгол Улсын явцын тайланг магадлаж шалгах мэдэгдээд байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтын ажил 2018 онд үргэлжлэн хийгдэв (Хүснэгт 1). Монголбанкнаас харьцангуй өндөр эрсдэлтэй 5 банкинд төлөвлөгөөний дагуу газар дээрх шалгалт хийж, үлдсэн 9 банкны харилцагчийн эцсийн өмчлөгчийг тогтоох үйл ажиллагаа болон зорилтот санхүүгийн хоригийн хэрэгжилтийг шалгав. Нийт 41 үүрэг даалгавар, үүний дотор 12 хугацаат үүрэг даалгавар өгч улсын байцаагчийн 3 мэдэгдэл өгч ажиллав.

Хүснэгт 1. МУТСТ чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Банкинд хийсэн хяналт шалгалт	12	13	2	14
Банкнаас бусад МҮЭ-эд хийсэн хяналт шалгалт	116	419	139	1025
Банк болон банкнаас бусад МҮЭ-эд тавигдсан акт	12	14	29	4
Банк болон банкнаас бусад МҮЭ-эд өгсөн хугацаат үүрэг даалгавар	213	393	367	272

Эх сурвалж: Монголбанк, СМА.

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос Улаанбаатар хот болон орон нутагт банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, үнэт цаасны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг хяналт шалгалтад хамруулсны сацуу Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран улс хоорондын шуудан, каргоны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад мөн шалгалт хийв.

Монголбанкнаас банкуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор дараах томоохон ажлыг хийж гүйцэтгэв:

- “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам” болон “Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг боловсруулж батлуулав.
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагад зориулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлагыг боловсруулж зохицуулалттай этгээдүүдэд хүргүүлэв.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулан 500 хувь хэвлүүлэн Монголбанкны орон нутаг дах салбар, арилжааны банкууд, их дээд сургуулиудад тараав.
- “Эрсдэлд суурилсан зарчмыг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг батлуулав.

МУТСТ хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор СМА-наас хийж гүйцэтгэсэн зарим томоохон ажлыг дурдвал:

- Засгийн газраас баталсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор ХАЗ-ийг 2018 онд нийт 8 удаа хуралдуулав. Мөн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гишүүн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор ХАЗ-ийн бүрэлдэхүүнд Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл болон Улсын бүртгэлийн ерөнхий газраас гишүүн нэмж оруулав.
- СМА-ны үйл ажиллагаанд ашигладаг програм хангамжийг шинэчлэх ажлын хүрээнд НҮБ-ын Хар тамхитай тэмцэх байгууллагын GoAML програм хангамжийг авах бэлтгэл ажлыг эхлүүлэв.
- Эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх байдлаар хамтран ажиллав. СМА нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн дагуу МҮЭ-ээс холбогдох тайланг хүлээн авч ажиллав (Хүснэгт 2).

Хүснэгт 2. СМА-нд МҮЭ-ээс ирүүлсэн тайлангийн тоо

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Сэжигтэй гүйлгээний тайлан	113	282	203	1,596
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан	1,223,984	838,110	572,181	669,910
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан	86,329	90,560	98,549	126,944
Гаалийн мэдүүлгийн тайлан	1,917	1,488	1,533	1,413

Эх сурвалж: СМА.

2018 онд 1596 сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) хүлээн авсан нь 2017 оныхтой харьцуулахад 7.9 дахин өссөн байна. Мөн хугацаанд гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо 28.8 хувиар, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан 17 хувиар өссөн байна. СМА нь МҮЭ-ээс ирүүлсэн СГТ-д дүн шинжилгээ хийх, мөнгө угаах буюу терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй байх тохиолдолд хууль сахиулах байгууллага (ХСБ)-д шилжүүлж шалгуулах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд дотоодын хууль сахиулах байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. СМА-ны мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй СГТ	209	245	35	151
СМА-наас дотоодын ХСБ-уудад шалгуулахаар шилжүүлсэн мэдээлэл	27	166	15	181
Мэдээлэл авах зорилгоор дотоодын ХСБ-уудаас СМА-нд ирүүлсэн хүсэлт	1,248	1,200	1,945	2,510
ХСБ-уудаас СМА-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу	1,241	1,238	1,834	2,300

Эх сурвалж: СМА.

СМА-наас 2018 онд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэх чиглэлд ажиллав:

- Олон улсын санхүүгийн мэдээллийн албадын нэгдсэн байгууллага (Egmont group буюу Эгмонт бүлэг)-ын гишүүний хувьд СМА нь бусад орны ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагатай мэдээлэл солилцох, Монгол Улсаас гадагшилсан буюу Монгол Улсад орж ирсэн хууль бус мөнгөний урсгал, гэмт хэргээс олсон орлогыг олж илрүүлэх тал дээр хамтран ажиллав.
- АНУ, Австрали, Япон, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс (ИБУИНВУ)-ын элчин сайдын яамд болон Европын холбоо, Азийн хөгжлийн банк (АХБ), Дэлхийн банк (ДБ)-тай хамтран олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэх асуудлаар тогтмол уулзалт хийх зохицуулах бүлэг байгуулан ажиллаж байна.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгох, МҮЭ-үүдэд зориулсан харилцагчийг таньж мэдэх журам, олон улсад мөрдөж буй стандарт, хэрэгжүүлж буй арга хэмжээ, СЗХ-ны хяналт шалгалттай холбоотой заавар, зөвлөмж, эрсдэл үнэлэх хэрэгслийг боловсронгуй болгох чиглэлээр АХБ-тай хамтран ажиллав.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах тухай эрх зүйн зохицуулалт бий болгох хүрээнд бодлогын болон хууль тогтоомжийн чиглэлээр дэмжлэг авах шугамаар СМА, ТТАЗЗ, ХЗДХЯ нь Австрали Улсын Дотоод хэргийн яамтай 2018 оны 3 дугаар сараас эхлэн хамтран ажиллаж байна.
- СМА-ны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулан 500 хувь хэвлүүлэн Монголбанкны орон нутаг дахь салбар, арилжааны банкууд, их дээд сургуулиудад тараав.
- СМА-ны чадавхыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр АНУ-ын Сангийн яам болон ОУВС-ийн техник туслалцааны багтай хамтран ажиллаж байна.

4.5 ДОТООД АУДИТ

Дотоод аудитын газар нь Монголбанкны бүтцийн нэгжүүдэд газар дээрх аудит, шалгалт хийх, тэдгээрийн үйл ажиллагаанд зайны болон дараалсан хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах, аудит, хяналт шалгалтын үр дүнгээр шийдвэр гаргуулж, биелэлтийг хангаж ажиллах замаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан аудитын төлөвлөгөө, удирдамжийн дагуу бүтцийн 26 нэгжийн үйл ажиллагаанд иж бүрэн, 2 нэгжийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн аудит хийж үр дүнг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Төлөвлөгөөт шалгалтуудаас гадна удирдлагаас өгсөн үүргийн дагуу 21 удаа тодорхой үйл ажиллагааны чиглэлээр хэсэгчилсэн шалгалт хийж гүйцэтгэсэн байна. “Үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах 3 шатны зарчим”-д тулгуурлан аудитын төлөвлөгөө, удирдамж, аудит хийх хугацаа, давтамжийг тогтоож ажиллаж байна.

Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хяналтын зөвлөлийн тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Монголбанкны удирдлагад танилцуулан биелэлтийг хяналтын зөвлөлд танилцуулан ажиллаж байна. Мөн Монголбанкны санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулж, СТОУС-9 стандартыг Монголбанкны санхүүгийн тайлан бүртгэлд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулахад оролцон ажилласан болно.

“Монголбанкны дотоод аудитын дүрэм”-ийг Дотоод аудитын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна.

4.6 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба нь тайлант хугацаанд гадаад валютын улсын нөөцийн удирдлагын эрсдэлийн удирдлага, мөнгөний захын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг тус тус хэрэгжүүлэн үүсэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад удирдан ажиллалаа. Түүнчлэн геополитикийн эрсдэлийн шинжилгээг сар тутам хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав.

Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл /credit risk/

Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Гадаад валютын албан нөөцийн удирдлагын журам”-ын дагуу нөөцийг хөрөнгө оруулалтын төрлөөр, харилцагч банк, санхүүгийн байгууллагаар, зээлжих зэрэглэлээр тус тус лимит тогтоон гадаадын төв банк, олон улсын байгууллага, өндөр зэрэглэлтэй банк, санхүүгийн байгууллагуудад тархаан байршууллаа. Мөн нөөцийн удирдлагын хүрээнд зөвхөн Төв банк, олон улсын байгууллага, гадаад орны “А” болон түүнээс дээш зэрэглэлтэй банк, санхүүгийн байгууллага, тэдгээрийн салбар, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэдэг байгууллагыг Монголбанкны харилцагч байгууллагаар сонгон ажиллав. Түүнчлэн гадаадын харилцагч банк, санхүүгийн байгууллагуудын зээлжих зэрэглэлээс гадна Базел III-ийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг харгалзан үзэв.

Мөнгөний зах зээлийн үйл ажиллагаа

Монголбанк банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангах зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн хувьд банкинд зээл олгодог. Тайлант онд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний зах дахь мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор банкинд олгох зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн үнэ цэнийг тооцох ерөнхий аргачлалыг боловсруулж, “Монголбанкнаас банкинд олгох зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгө, үнэт цаасны үнэ цэнийг тооцох заавар”-ыг шинээр батлан гаргалаа. Ингэснээр барьцаа хөрөнгийн үнэ цэнийг зохих аргачлалын дагуу тооцож, барьцаа хөрөнгийн үнэлгээг зохистой түвшинд хадгалах, улмаар зээлийн эрсдэлийн удирдлагыг илүү үр ашигтай болгосон. Түүнчлэн Монголбанкнаас банкинд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг тухайн барьцаа хөрөнгийн төрөл болон хэлбэрээс хамааруулан ангилж,

харгалзах эрсдэлийн хямдруулалтыг шинэчлэн тогтоосон нь зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээ боллоо.

Монголбанкны тайлан тэнцэлд учирч болзошгүй эрсдэлийн хүрээ

Тайлант онд Монголбанк Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартын дагуу санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг урьдчилан тооцоолох аргачлалыг шинээр боловсруулж, “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ыг батлав. Энэхүү аргачлалыг Монголбанк үйл ажиллагаандаа мөрдсөнөөр тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг урьдчилан харж тооцоолон, түүнд тохирсон эрсдэлийн нөөц санг байгуулж, бодит эрсдэл учирсан тохиолдолд эрсдэлийг зохистой удирдах боломжийг бий болгох чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн 2018 оноос дэлхий даяар хүчин төгөлдөр мөрдөж эхэлж буй олон улсын нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартын дагуу санхүүгийн тайлангаа гаргаж, хөндлөнгийн аудитын байгууллагаас “Unqualified” буюу “Хязгаарлалтгүй” дүгнэлт авснаар олон нийтэд санхүүгийн үзүүлэлтүүдээ үнэн бодитоор тайлагнах нөхцөл бүрдэж, төв банкны бодлогын найдвартай, хариуцлагатай байдлыг бататгахад чухал хувь нэмэр оруулах онцлог ажил боллоо.

Зах зээлийн эрсдэл /market risk/

Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн зах зээлийн үнэлгээ, эрсдэл болон үр өгөөжийн тооцооллыг өдөр бүр хийж, тогтоосон лимитийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа.

Ханшийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын гадаад зээлийн төлбөр, импортын бүтэц, банкуудын гадаад гүйлгээний гадагшлах урсгал болон дотоодын валютын захын бүтцэд үндэслэн ханшийн эрсдэлийг хамгийн бага байлгахад шаардлагатай валютуудаар багцыг бүрдүүлсэн. Үүний зэрэгцээ хүүний өөрчлөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурах эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс үргэлжлэх хугацаа болон түүний хазайлтыг оновчтой тодорхойлох замаар хүүний хэлбэлзлээс үүсэх эрсдэлийг удирдан ажиллав.

Мөнгөний зах зээлийн үйл ажиллагаа

Банк хоорондын валютын арилжааны системд оролцогчдын арилжааны өдрийн лимитийг тухай бүр тооцож тогтоох, валютын арилжааны системийн үндсэн дилерийг улирал тутам сонгох, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг гүйцэтгэлээ. Үүний зэрэгцээ гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах үүднээс банкуудтай байгуулж буй урт хугацаат своп хэлцлийг долоо хоног тутам дахин үнэлж холбогдох тооцооллыг хийж гүйцэтгэв.

Хөрвөх чадварын эрсдэл /liquidity risk/

Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Гадаад валютын улсын нөөцийг чөлөөтэй хөрвөдөг гадаад валютуудаар илэрхийлэгдсэн зах зээлд хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, удирдаж буй багцын үргэлжлэх хугацааг сар бүр бенчмарк индексийн үргэлжлэх хугацаатай дахин тэнцвэржүүлж / rebalancing/ байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

ЭУА нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор олон улсын төв банкуудын тэргүүн туршлага, жишгийн дагуу эрсдэлийг үнэлж, тодорхойлох арга хэрэгслүүдийг амжилттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж, эрсдэлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад хамгийн түгээмэл ашиглагддаг үнэлгээний хэрэгсэл болох “өөрийн үнэлгээ” (Risk Control and Self-Assessment)-г хоёр дахь жилдээ цахим хэлбэрээр бүх

ажиллагсдаар хийлгэж, үр дүнг нэгтгэн, эрсдэлийн үнэлгээ хийв. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтүүд (KRI)-ийн гүйцэтгэлийг газар нэгжүүдээс нэгтгэн авч, тухай бүр хяналт тавин, удирдлагад танилцуулж, холбогдох газруудад зөвлөмж өгч ажиллалаа. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бодит хэмжүүрээр хэмжиж, эрсдэл үүсгэж буй хүчин зүйлийн гол шалтгааныг олж тодорхойлон тохирсон арга хэмжээ авахад чухал хувь нэмэр оруулж байна.

Тайлант хугацаанд шинээр хийсэн гол ажлуудын нэг нь Монголбанкны орон нутагт зузаатгал хүргүүлэх үйл ажиллагаанд үйл явцын бодит практикт үндэслэн зураглал хийж (business process mapping), үе шат бүрт эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлгээ хийсэн.

Бүх нэгжид үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтанг томилуулан, тусгай сургалтад хамруулж, хурал уулзалтыг тогтмол зохион байгуулж эхэллээ. Энэ нь нэг талаар нийт байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг түгээж, нөгөө талаар нэгж тус бүртэй нягт уялдаа, холбоотой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

Геополитикийн эрсдэл

Дэлхийн том гүрнүүдийн бодлого, улс орнуудын харилцан хамаарал болон Төв банкуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг нь олон улсын санхүүгийн зах зээл, гол түүхий эдийн үнэ, хөрөнгийн урсгал, үнэт металлын үнээр дамжин манай улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх, үүнээс шалтгаалан үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан харах, удирдах зорилгоор Монголбанк тайлант онд геополитикийн асуудал хариуцсан шинжээчийн ажлын байрыг шинээр бий болголоо. Үүний хүрээнд дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл, том улс орны макро бодлогын өөрчлөлтийг агуулсан цаг үеийн мэдээ, мэдээллийг сар тутам боловсруулж, улмаар Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх үр нөлөөг судлан ажиллалаа.

Цаашид олон улсад өрнөж буй үйл явдлууд Монгол Улсын эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж болох сувгуудыг судалж илрүүлэх, тодорхойлох, гадаад хүчин зүйлийн эрсдэлийн ерөнхий загварыг боловсруулах зэргээр гадаад эрсдэлийг удирдахыг зорин ажиллаж байна.

4.7 БЭЛЭН МӨНГӨНИЙ ХАНГАЛТ

Монголбанкны үндсэн үүргийн нэг болох үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах үйл ажиллагааны хүрээнд 2018 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 453.02 сая ширхэг, 968.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний энэхүү хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэлтэй харьцуулбал тоо ширхгийн хувьд 37.85 сая ширхэг буюу 9.1 хувиар, мөнгөн дүнгээр 62.2 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар өссөн байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд буюу 2012-2018 оны өөрчлөлтийг нь харвал мөнгөн дүнгээр дунджаар 3.1 хувь, тоо ширхгээр 7.6 хувиар өсч иржээ.


Хүснэгт 4. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өөрчлөлт, мөнгөн дүнгээр

№	Мөнгөн тэмдэгт	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө оны эцсийн байдлаар (сая төгрөг)						
		2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	1	26	29	30	30	31	32	32
2	5	12	131	133	136	140	143	146
3	10	527	571	623	680	744	830	900
4	20	736	880	966	1,010	1,086	1,343	1,488
5	50	1,676	1,843	2,016	1,982	2,242	2,725	3,134
6	100	3,375	3,745	3,963	4,039	4,526	5,480	6,138
7	200	68	34	34	35	36	36	36
8	500	5,200	5,661	5,978	5,702	6,390	7,057	7,772
9	1000	13,727	14,263	14,756	16,278	17,962	18,570	19,724
10	5000	64,394	53,975	50,003	43,420	54,091	62,875	68,902
11	10000	234,702	207,230	187,416	148,941	165,678	189,379	213,472
12	20000	501,525	553,908	544,274	484,264	570,665	617,887	646,835
Нийт		825,969	842,269	810,192	706,517	823,591	906,358	968,580

Хүснэгт 5. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өөрчлөлт, тоо ширхгээр

№	Мөнгөн тэмдэгт	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө оны эцсийн байдлаар (сая ширхэг)						
		2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	1	26.4	29.26	29.72	30.30	31.01	31.71	32.32
2	5	23.5	26.24	26.70	27.24	27.97	28.68	29.29
3	10	52.7	57.06	62.31	67.96	74.43	83.05	90.04
4	20	36.8	44.00	48.28	50.50	54.28	67.17	74.40
5	50	33.5	36.86	40.32	39.64	44.85	54.49	62.68
6	100	33.8	37.45	39.64	40.39	45.27	54.80	61.38
	200	0.3	0.17	0.17	0.18	0.18	0.18	0.18
7	500	10.4	11.32	11.96	11.40	12.78	14.11	15.54
8	1000	13.7	14.26	14.76	16.28	17.96	18.57	19.72
9	5000	12.9	10.79	10.00	8.68	10.82	12.58	13.78
10	10000	23.5	20.72	18.74	14.89	16.57	18.94	21.35
11	20000	25.1	27.70	27.21	24.21	28.53	30.89	32.34
Нийт		292.6	315.8	329.8	331.7	364.7	415.2	453.02

Зураг 1. Мөнгөн дэвсгэртүүдийн бүтцийн тоо ширхэг, мөнгөн дүнгийн өөрчлөлт:



Гүйлгээнд эргэлдэж байгаа бэлэн мөнгөний сүүлийн 6 жилийн ерөнхий хандлагаас харахад тоо ширхгийн хувьд тогтмол өсөлттэй явж ирсэн бол мөнгөн дүнгийн хэмжээгээрээ 2014-2015 онд буурч, 2016 оноос эхлэн эргээд өсч байгаа нь эдийн засгийн мөчлөгийг дагаж буй хэрэг юм. Харин нийт мөнгөний нийлүүлэлтэд болон ДНБ-д харьцуулсан хэмжээгээрээ жил ирэх тутам аажмаар буурсаар байна.

Монголбанк тайлант онд мөнгөн тэмдэгийг хуурамчаас үйлдэхээс сэргийлсэн хамгаалалтын элементийг сайжруулахад онцгой анхааран ажиллаж нөөцийг нь шинээр бүрдүүлэх шаардлагатай болсон 5000 төгрөгийн дэвсгэртийн хамгаалалтын таних тэмдгийг шинэ дэвшилтэд технологиор сайжруулан үйлдвэрлэж гүйлгээнд гаргалаа.

Монгол улсын 21 аймаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын шаардлагатай бэлэн мөнгөний нөөцийг бүрдүүлэхэд зориулан давхардсан тоогоор 15 аймагт 204.9 тэрбум төгрөгийн бэлэн мөнгөний зузаатгал хийсэн байна.

4.8 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Монголбанк нь тайлант онд банк хоорондын төлбөр тооцооны систем, банк хоорондын цахим арилжааны систем болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй цахим мэдээллийн системүүдийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь банк хоорондын болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим мэдээллийн системүүдийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ эдгээр системийг сайжруулах, боловсронгуй болгох, шинэ техник, технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг ажил хийлээ. Тухайлбал, Банк хоорондын валютын арилжааг идэвхжүүлэх, боловсронгуй болгох, валютын арилжааны бодит ханшийг тогтоох, валютын арилжаанд оролцох үйл ажиллагааны зардлыг бууруулах, банк хоорондын захын валютын арилжааг хянах, удирдах зэрэг үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд “Банк хоорондын валют арилжааны цахим талбар” системийг 2018 онд шинээр хөгжүүлж, ашиглалтад оруулаад байна.

Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай байдлыг дээшлүүлэх зорилтын хүрээнд банк хоорондын их дүнтэй гүйлгээний системийн шинэ хувилбарыг амжилттай суурилуулж, ашиглалтад орууллаа. Мөн олон улсын төлбөр тооцооны Свифт системийг шинэ хувилбарт шилжүүлэх ажлыг өөрсдийн хүчээр цаг хугацаанд нь амжилттай ашиглалтад орууллаа.

Үүнээс гадна Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхэд зориулсан вэб, зоосыг олон нийтэд танилцуулах вэб болон Монголбанкны дотоод үйл ажиллагаанд зориулж, үндсэн хөрөнгийн бүртгэлд баркод нэвтрүүлэхэд шаардлагатай програм, мөнгөн тэмдэгийн бүртгэлийн үйл ажиллагаанд зориулсан програм шинээр хөгжүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мөн мэдээллийн технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, вирусын болон аливаа төлөвлөгөөт халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу арга хэмжээ авахад чиглэсэн үйл ажиллагааг улам сайжруулах зорилгоор “Мэдээллийн аюулгүй байдлын алба”-ыг шинээр байгуулаад байна.

4.9 МОНГОЛ БАНКНААС 2018 ОНД БАТАЛСАН БАРИМТ БИЧГҮҮД

Монголбанкнаас 2018 онд гаргасан эрх зүйн акт, шийдвэрийн хураангуй

Д/д	Эрх зүйн акт, шийдвэр	Огноо	Дугаар	Агуулга
Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр				
	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоох тухай	2018.03.23	A-73	Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5, Валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12.0 хувиар тус тус тогтоов.
	Заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай	2018.03.29	A-80	Банкны заавал байлгах нөөцийг тогтоон, тооцох журмыг батлав.
	Заавал байлгах нөөцийн урамшууллын хүү тогтоох тухай.	2018.03.29	A-81	Заавал байлгах нөөцийн тогтоосон хэмжээнд олгох урамшууллын хүүг Төв банкны овернайт хадгаламжийн хүүгийн 50 хувьтай тэнцүү хэмжээгээр тогтоов.
	Заавал байлгах нөөцийн шаардлагаас хасч тооцох эх үүсвэрийн тухай	2018.03.29	A-83—A-86	Мөнгөний бодлогын зорилтыг хангах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд банкнаас олгосон хөнгөлөлттэй зээлийн дүнтэй тэнцэхүйц хэмжээний харгалзах валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасч тооцохоор болов.
	Мөнгөний бодлогын хорооны ажиллах журам	2018.05.17	A-143	Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагаа, зарчим, хуралдааны дэг, шийдвэрийг нийтэд мэдээлэх харилцааг зохицуулна.
	Төв банкны репо санхүүжилтийн журам	2018.07.09	A-192	Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдалыг зохицуулах, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэхэд дэмжлэг болно гэж үзэв.
	Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам	2018.07.23	A-203	Банкны хүү бодоход баримтлах зарчмыг тодорхойлох, хүү шимтгэл, хураамжийн мэдээллийг ил тод байлгах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд өөрчлөлт оров
	Өр орлогын харьцааг тооцох аргачлал батлах тухай	2018.06.20	A-176	Банкнаас иргэдэд олгох хэрэглээний зээлийн үйл ажиллагаанд өр, орлогын харьцааг тооцоход энэхүү аргачлалыг мөрдөнө.
	Бодлогын хүүг тогтоох тухай, өр орлогын харьцааны дээд хязгаар тогтоох тухай	2018.01- 2018.05	Мөнгөний бодлогын хорооны тогтоол	2018.01-Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болгох; 2018.02- Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах, иргэдийн хэрэглээний зээлийн Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувь тогтоох; 2018.03- Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах; 2018.04- Бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөн 11 хувьд хүргэх; 2018.05- Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах;
	Төв банкны үнэт цаасны арилжааны журам нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2018/03/29	A-79	
	Урт хугацаат своп хэлцлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2018/03/09	A-69	

Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зээл олгох чиглэлээр				
	Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам.	2018.06.15	A-174	Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, барьцаат зээл олгох харилцааг зохицуулах
Банкны үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр				
	Эрсдэлээс хамгаалах сан байгуулах хувь тогтоох тухай тушаал	2018.02.09	A-39	Кастадионы үйл ажиллагаанаас санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах
	Банкны хяналт шалгалтын хорооны ажиллах журам	2018.03.26	A-75	Хуульд заасны дагуу Банкны Банкны хяналт шалгалтын хорооны үйл ажиллагааг зохицуулах
	Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкийг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах журам	2018.10.17	A-258	
	Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журам	2018.11.30	A-302	Банкийг албадан татан буулгах шийдвэр гаргах болон банкны эрх хүлээн авагч томилох, түүний бүрэн эрх хэрэгжих нөхцөл, татан буулгах арга хэмжээ хэрэгжих нөхцөл, өр төлбөрийг барагдуулах, банкны эрх хүлээн авах арга хэмжээ дуусгавар болгох арга хэмжээг зохицуулна.
	Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам	2018.12.06	A-308	Банкны тогтолцооны тогтвортой байдлыг зорилгоор банкны тухай хуульд заасан Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахаар шийдвэрлэх, хэрэгжүүлэх, дуусгавар болгох, бусад эрх бүхий байгууллагатай харилцах асуудлыг зохицуулна.
	Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам	2018.12.07	A-312	Монголбанкнаас банкинд нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгч томилох, банкны хэвийн ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг сайжруулахтай холбоотой бүрэн эрхт төлөөлөгчөөс авах арга хэмжээ түүнийг дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулсан.
	Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам	2017.06.29	A-152	Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг зохицуулна.
	Мөнгө угаах терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк зайнаас хяналт тавих журам.	2018.11.27	A-293	Монголбанкнаас баталсан дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих харилцааг зохицуулна.
	Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай.	2018.02.06	A-32	Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хэлбэрийг нэвтрүүлэх зорилгоор Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.
	Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2018.08.03	A-215	Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих

Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам	2018.08.02	A-211	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх
Цахим мөнгөний журам	2018.02.13	A-45	Цахим мөнгө гаргах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны журмыг тогтооно.
Их дүнтэй төлбөрийн системийн журам	2018.03.30	A-88	Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог үнэн зөв, тасралтгүй найдвартай гүйцэтгэх үйл ажиллагааг зохиуулах.
Үндэсний цахим гүйлгээний төвийн төлбөрийн картын сүлжээний дүрэм шинэчлэн батлах тухай	2018.05.10	A-133	Картын төлбөрийн системийн үйл ажиллагааг зохион байгуулах, нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангахад чиглэсэн.
Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх зээл олгох чиглэлээр			
Засгийн газарт зээллэг олгох журам	2018.06.07	A-161	Монголбанкаас Засгийн газарт зээллэг олгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулна.
Бусад			
Монголбанкны Захирлуудын зөвлөлийн ажиллах журам	2018.04.10		Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороо болон тусгайлан байгуулсан бусад зөвлөлийн хэлэлцэхээс бусад асуудлаар, Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад зөвлөх чиг үүрэгтэй
Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах тухай	2018.05.17	A-144	Монголбанкны ажилтнууд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ тогтоосон.
Монголбанкны худалдан авах алт цагаан мөнгөний үнийг тодорхойлох журам	2018.05.10	A-138	Монголбанкны худалдан авах алт, цагаан мөнгөний үнийг тогтоох, тооцоолох, худалдан авах, эзэмших, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохицуулна.

МОНГОЛБАНК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН
ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ БЭЛТГЭГДСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ
БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

АГУУЛГА

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанк (цаашид “Банк”)-ны санхүүгийн тайлангууд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг эдгээр санхүүгийн тайлангуудад үнэн зөв бодитой илэрхийлэгдсэнийг Захирлуудын зөвлөл баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Захирлуудын зөвлөл нь нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв, зохистой хөтөлж явуулахыг хариуцах ба энэ нь Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв тайлагнах үүргийг биелүүлэх боломжийг олгодог.

Үүнээс гадна, Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авч хэрэгжүүлэх нь Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь (1-ээс 92 дугаар хуудсанд тодруулсан) санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:





Хараат бус аудиторын тайлан

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хараат бус аудиторын тайлангийн Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл хэсэгт дурьдагдсан эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлж болзошгүй байдлыг эс тооцвол, Монголбанк ("Банк" гэх)-ны санхүүгийн тайлангууд нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл

2018 онд Банк нь Эрдэнэсийн Сангийн хөрөнгүүдэд дахин үнэлгээг хийсэн. Үүний үр дүнд Эрдэнэсийн Сангийн хөрөнгийг 924,729 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба үүнтэй холбоотойгоор Өөрийн хөрөнгийн хэсэг дэх Эрдэнэсийн Сангийн дахин үнэлгээний нөөц санг ижил дүнгээр харгалзуулан нэмэгдүүлсэн. Эрдэнэсийн санд түүх соёлын болоод өв уламжлалын хосгүй үнэт зүйлс, Монгол зооснууд хадгалагддаг. Хамгийн их нөлөө бүхий 20 гаруй төрлийн түүхэн үнэт зүйлс, 1925 онд гүйлгээнд гаргасан таван өөр нэрлэсэн үнэ бүхий нийт 2,054 мянган ширхэг мөнгөн зоос ("Зоос")-нд дахин үнэлгээг хийсэн ба эдгээр зоосыг банкны эрх залгамжлагч Монголбанк нь анх гүйлгээнд нийлүүлсэн. Эдгээр зоосыг дахин үнэлэх болсон үндсэн зорилго нь түүхэн цуглуулгын үнэ цэнийг тусгах явдал байсан бөгөөд мөнгөн үнэт металлын орцын үнэ цэнээс илт давуу байна гэж үзсэн.

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу банкууд болон хэрэглэгчдэд зориулан зоос болон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах үед нэрлэсэн үнэ бүхий өр төлбөрөөр бүртгэнэ гэж заасан. Банк нь гүйлгээнд гаргаагүй хэвлэсэн үндэсний мөнгөн тэмдэгт, зоос мөн гүйлгээнээс татсан мөнгөн тэмдэгт, зоосыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөггүй. Санхүүгийн тайлангийн тодруулга 4 болон 15-д тодруулсны дагуу Монголбанкны хууль ёсны эрхийг залгамжлагч банк нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох зоосыг үйлдвэрлэж гүйлгээнд гаргасан хэдий ч Банкны удирдлага нь эдгээр Зоосыг Засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж үзэж хөрөнгөөр хүлээн зөвшөөрч болно гэж дүгнэсэн. Банкны Удирдлага нь 1938 оноос хойш эдгээр зоосыг гүйлгээнээс татахад гуравдагч талын эзэмшилд байсан болон Монголбанк эсвэл түүний хууль ёсны эрхийг залгамжлагч болох банкны зүгээс биш, харин Гуравдагч талын зүгээс зоосыг Эрдэнэсийн Санд шилжүүлсэн. Улмаар СТОУС-д шилжих явцад Банкны Санхүүгийн байдлын

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот
Д.Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо,
Улаанбаатар хот 14200, Монгол Улс
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068, www.pwc.com/mn

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31



тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн гэх итгэл үнэмшлийг төрүүлэхүйц холбогдох тайлбар, тодруулгыг бид Банкны удирдлагын зүгээс авч чадаагүй. Иймд Зоос нь СТОУС-ын дагуу Санхүүгийн байдлын тайланд үнэн зөв хүлээн зөвшөөрөгдсөн эсэхэд холбогдох итгэл үнэмшлийг олж авч чадаагүйгээс шалтгаалан Зоосны бодит үнэ цэнийн дахин үнэлгээний дүн болох 826,198 сая төгрөгний дахин үнэлгээний нэмэгдлийг Банкны Өөрийн хөрөнгөнд дахин үнэлгээний нөөц сан байдлаар хүлээн зөвшөөрөх үед хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бид олж авч чадаагүй болно. Дахин үнэлгээний дараах Зоосны нийт үнэ нь 827,886 сая төгрөг.

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хүрээнд Банкны удирдлагууд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Банкны 2018 оны Жилийн тайлангаас бүрдэнэ (бидний аудитын тайлан болон санхүүгийн тайлангуудыг агуулаагүй байдаг).

Бидний санхүүгийн тайлангуудад өгөх дүгнэлт нь бусад мэдээллүүдэд хамаарахгүй тул бид бусад мэдээллүүдэд аливаа төрлийн баталгаа болон дүгнэлт өгдөггүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой үүрэг хариуцлагынхаа хүрээнд бид, дээр дурдсан бусад мэдээллийг уншиж уг мэдээллүүд нь санхүүгийн тайлангуудтай болон бидний аудитын явцад олж авсан мэдэгдэхүүнтэй материаллаг байдлын түвшинд авцалдаагүй, илэрхий буруу илэрхийлэл агуулж буй эсэхийг хардаг.

Хэрэв бусад мэдээлэлд бидний зүгээс хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд материаллаг хэмжээний алдаа байна гэж дүгнэвэл бид үүнийг мэдэгдэх үүрэгтэй. Дээрх *Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэлд* тайлбарласны дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Зоосны дахин үнэлгээ болон түүний хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор хангалттай бөгөөд зохистой нотолгоог бид олж авч чадаагүй. Тиймээс, энэ асуудлын хувьд бусад мэдээлэл нь материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн эсэхийг бид дүгнэн хэлэх боломжгүй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.



Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31



Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Гарын үсэг зурсан:

Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапия
Захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Улаанбаатар, Монгол Улс
2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	Тодруулга	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө	7	72,027	76,895
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	8	2,868,239	3,136,251
Дотоодын банкуудад олгосон зээл	9	442,293	860,358
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	10	4,677,189	-
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	11	11,734	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	12	-	2,966,262
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	13	2,463,612	3,083,987
Алт ба үнэт метал	14	2,185,657	538,948
Эрдэнэсийн сан	15	931,241	5,259
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	199,657	55,732
Засгийн газрын үнэт цаас	17	64,331	163,027
Бусад хөрөнгө	18	840,790	694,903
Үндсэн ба биет бус хөрөнгө	19	74,451	34,635
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		4,144	4,778
НИЙТ ХӨРӨНГӨ		14,835,365	11,621,035
ӨР ТӨЛБӨР			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	20	968,618	906,396
Төв банкны үнэт цаас	21	5,005,515	3,444,401
Засгийн газрын хөрөнгө	22	1,130,107	1,880,664
Дотоод банкуудын хөрөнгө	23	4,215,585	3,116,298
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	368,710	311,472
Гадаад өр төлбөр	24	4,906,130	4,737,952
Бусад өр төлбөр	25	116,695	45,132
НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,711,360	14,442,315
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	26	60,000	5,000
Хуримтлагдсан алдагдал	26	(3,071,835)	(2,844,603)
Бусад нөөц	26	1,135,840	18,323
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		(1,875,995)	(2,821,280)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		14,835,365	11,621,035



Ц.Гарьд
Тайлан бүртгэлийн газрын захирал

Хуудас 8-аас 92-д тусгасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	Тодруулга	2018	2017
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	27	275,154	302,156
Хүүгийн зардал	27	(823,530)	(523,235)
Хүүгийн цэвэр зардал		(548,376)	(221,079)
Алт, үнэт металын арилжааны ашиг	28	18,707	23,270
Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн ашиг	29	164,176	3,957
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний ашиг	30	125,556	673,299
Гадаад валютын арилжааны алдагдал	31	(116,162)	(148,703)
Гадаад валютын хөрвүүлгийн ашиг/(алдагдал)	32	134,175	(175,795)
Хорогдуулсан өртгөөр хэмжих дотоодын банкуудад олгосон зээлийн болзошгүй алдагдлын буцаалт/(болзошгүй алдагдлын нөөц сан)		4,054	(820)
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн үнэ цэнийн бууралт		(120)	-
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын буцаалт		77,932	-
Болзошгүй алдагдлын нөөцийн сангийн буцаалт		-	61,249
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт борлуулсны алдагдал	33	(9,641)	(690)
Засгийн газрын үнэт цаас борлуулсны ашиг		-	2,754
Орлого зарлага нь бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн ашиг	34	176,997	-
Өмчийн үнэт цаасны санхүүгийн хөрөнгө оруулалт арилжаалсны орлого		6,831	-
Үйл ажиллагааны бусад орлого	35	16,003	12,762
Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	36	(41,725)	(51,527)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ		8,407	178,677
Бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Орлого зарлагад дахин ангилагдаж болзошгүй зүйлс:</i>			
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт:			
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз		(6,587)	(2,726)
- Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн олз		9,641	690
<i>Орлого зарлагад дахин ангилагдахгүй зүйлс:</i>			
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	26	18,436	-
- Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдэл	26	924,729	-
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		946,219	(2,036)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		954,626	176,641

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	Тодруулга	Дүрмийн сан	Бусад нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт өөрийн хөрөнгө
2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	26	5,000	16,402	(3,019,323)	(2,997,921)
Тайлант жилийн ашиг		-	-	178,677	178,677
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	(2,036)	-	(2,036)
2017 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	(2,036)	178,677	176,641
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн	26	-	3,957	(3,957)	-
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		5,000	18,323	(2,844,603)	(2,821,280)
СТОУС 9-ийн нөлөө:					
– хүлээгдэж буй зээлийн алдагдлын дахин хэмжилт		-	-	(8,130)	(8,130)
– бусад нөлөө		-	52	(1,263)	(1,211)
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл		5,000	18,375	(2,853,996)	(2,830,621)
Тайлант жилийн ашиг		-	-	8,407	8,407
Бусад дэлгэрэнгүй орлого	26	-	946,219	-	946,219
2018 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	946,219	8,407	954,626
Хуримтлагдсан алдагдлаас дүрмийн санд хуваарилсан	4, 26	55,000	-	(55,000)	-
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн	26	-	171,246	(171,246)	-
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		60,000	1,135,840	(3,071,835)	(1,875,995)

Хуримтлагдсан алдагдлаас дүрмийн санд хуваарилсан дүн нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 10 дугаар тушаалын дагуу болзошгүй алдагдлын нөөц сангийн буцаалтыг хуримтлагдсан алдагдлаас тусгаарлан дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой болно. Банкны 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн саналыг үндэслэн гаргасан УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 70 дугаар тогтоолоор Банкны дүрмийн сангийн нэмэгдүүлэлтийг зөвшөөрсөн гэж удирдлага үзэж байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 4 болон 26-аас харна уу.

Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний өөрчлөлтийг Тодруулга 4 болон 15-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2017 болон 2018 онд хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц санд шилжүүлсэн дүн нь алт, үнэт метал болон гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлын зөрүү зөрүүг шилжүүлсэнтэй холбоотой болно. (Тодруулга 26).

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант жилийн ашиг:	8,407	178,677
<i>Тохируулгууд:</i>		
Алт ба үнэт металын ханшийн тэгшитгэлийн (ашиг)	(164,176)	(3,957)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний (ашиг)	(86,687)	(673,299)
Гадаад валютын хөрвүүлгийн бодит бус (ашиг)/алдагдал	(7,070)	180,897
Орлого зарлага нь бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн (ашиг)	(176,997)	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бодит алдагдал	411	-
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл	3,077	2,624
Данснаас хассан үндсэн хөрөнгө	4	16
Өрийн үнэт цаасны санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны алдагдал	9,641	-
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны алдагдал	-	690
Засгийн газрын үнэт цаас борлуулсны (олз)	-	(2,754)
Хорогдуулсан өртгөөр хэмжих дотоодын банкуудад олгосон зээлийн (болзошгүй алдагдлын нөөц сангийн буцаалт)/болзошгүй алдагдлын нөөц сан	(4,054)	820
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн үнэ цэнийн бууралт	120	-
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын (буцаалт)	(77,932)	-
Болзошгүй алдагдлын нөөц сангийн (буцаалт)	-	(61,249)
Хүүгийн орлого	(275,154)	(302,156)
Хүүгийн зардал	823,530	523,235
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	53,120	(156,456)
<i>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>		
Алт, үнэт металын цэвэр (өсөлт)	(1,482,533)	(307,723)
Эрдэнэсийн сангийн цэвэр (өсөлт)	(1,253)	-
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн цэвэр бууралт/(өсөлт)	795,149	(2,034,511)
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр бууралт	413,777	225,184
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслийн цэвэр (өсөлт)	(608,976)	-
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн цэвэр өсөлт	-	(18,567)
Засгийн газрын үнэт цаасны цэвэр (өсөлт)	(5,332)	(12,010)
Бусад хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт)	140,733	(3,713)
Төв банкны үнэт цаасны цэвэр өсөлт	1,545,088	2,866,561
Засгийн газрын хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	(810,409)	866,898
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр өсөлт	1,006,592	445,196
Гадаад өр төлбөрийн цэвэр (бууралт)/ өсөлт	(7,877)	1,056
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/ (бууралт)	69,922	(4,127)
Үйл ажиллагаанаас олсон татварын болон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ	1,108,001	1,867,788
Хүлээн авсан хүү	236,956	303,247
Төлсөн хүү	(815,516)	(447,541)
Үйл ажиллагаанаас олсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	529,441	1,723,494

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт	(25,438)	(6,195)
Үндсэн хөрөнгийн борлуулалт	566	54
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслийн худалдан авалт	(4,633,328)	-
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн худалдан авалт	-	(2,672,486)
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслийн борлуулалт	3,640,586	-
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн борлуулалт	-	2,405,586
Засгийн газрын үнэт цаасны борлуулалт болон эргэн төлөлт	103,535	177,977
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(914,079)	(95,064)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний бууралт	62,222	82,767
Санхүүгийн үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ	62,222	82,767
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	49,521	8,447
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	(272,895)	1,719,644
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,212,984	1,493,340
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,940,089	3,212,984

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ТАНИЛЦУУЛГА БОЛОН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

Танилцуулга. Монголбанк (цаашид “Банк”) нь Монгол Улсын Төв банк бөгөөд Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулиудын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор анх байгуулагдсан.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг болно. Монголбанкны системд орон нутгийн нийт 17 хэлтэс, салбар болоод Лондон, Их Британи дахь төлөөлөгчийн газар багтдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Банк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- Эцсийн зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болон дахин санхүүжилтийн системийг зохион байгуулах;
- Бусад хамтын ажиллагаа бүхий төв банкууд, олон улсын банк болон санхүүгийн байгууллагуудад Монгол Улсыг төлөөлөх;
- Санхүү, зээлтэй холбоотой бусад чиг үүргүүдийг хуульд тодорхойлсон хэм хэмжээний дагуу гүйцэтгэх.

Хуульд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах, худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагууд, Олон улсын байгууллагуудын дансыг Банкинд байршуулах болон өөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг

Банкны дүрмийн санг Монгол Улсын төр бүрэн эзэмшдэг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих явдал юм. Түүнчлэн, Банкны ирэх оны жилийн төсвийг батлах, түүний биелэлт гүйцэтгэлийн талаар олон нийтэд тайлагнах, тайлант жилийн ашгийн хуваарилалтыг хийх зэрэг Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрх мэдлийн хүрээнд бусад чиг үүргийг Захирлуудын зөвлөл гүйцэтгэдэг.

Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил. Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 3, 15160.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ТАНИЛЦУУЛГА БОЛОН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны үйл ажиллагааны орчин. Монгол Улсын эдийн засаг нь инфляцын болон хүүгийн өндөр түвшин зэрэг хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулж байна. 2010, 2011 онуудад тогтмол өсөлттэй байсан дотоодын эдийн засагт 2012 болон 2013 онд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал, 2012 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөс үүдэн гадны хөрөнгө оруулалт буурсан зэрэгтэй уялдан эдийн засгийн хөгжил саарах хандлага илэрч байна. 2014 оны сүүлийн улирлаас өргөн хэрэглээний барааны үнэ огцом унаж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийн удаашралд томоохон нөлөө үзүүлсэн. Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашрал мөн адил 2015 болон 2016 онуудад үргэлжилсэн.

2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Мүүдийс үнэлгээний агентлагийн тогтоосон Монгол улсын зээлжих зэрэглэл “Саа1, тогтвортой” хэвээр байсан. 2018 оны 1 дүгээр сарын 18-нд Мүүдийс үнэлгээний агентлаг Монгол улсын үнэлгээг Саа1-ээс В3, хэтийн төлвийг тогтвортой хэвээр үлдээсэн. Үнэлгээний өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс нь төлбөрийн тэнцлийн болон гадаад өрийн дарамт багассан, Монгол Улсын зээлжих зэрэглэлийн түүхий эдийн үнээс хамааралтай байдал буурах хандлага ажиглагдсантай холбоотой.

2017 оны хоёр дугаар улиралд Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) “Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр”-т Монгол Улс хамрагдахболсон (Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Япон, Солонгос болон БНХАУ-ын дэмжлэгтэй) бөгөөд ОУВС-гийн нийт санхүүжилт нь 5,500 сая ам.доллар, 3 жилийн хугацаатай. 2017 онд Монгол Улсын Засгийн газар 2023 онд эргэн төлөгдөх 5.625 хувийн хүүтэй 800 сая ам.долларын бондыг олон улсад гаргах замаар дахин санхүүжилтийг амжилттай гүйцэтгэсэн. 2018 онд Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт (ГШХО) 164.4 сая ам.доллараар өссөн бол харин Монгол Улсаас гадаад улсад оруулсан хөрөнгө оруулалт 0.5 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Хөтөлбөрийн нэг тулгуур нь банкны системийг эрүүлжүүлэх Монголбанкныг чадавхижуулах иж бүрэн арга хэмжээ байсан. Хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас Монгол Улсын арилжааны банкуудад Активын Чанарын Үнэлгээ (АЧҮ)-г зохион байгуулсан. Урьдчилсан үр дүнг 2018 оны 1 дүгээр сард банкуудад мэдээлсэн. АЧҮ-ний дараа Монголбанк АЧҮ-ний урьдчилсан үр дүнд үндэслэн банк тус бүрийн санхүүгийн байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтыг 2018 оны 6 дугаар сард хийж дуусгасан бөгөөд үр дүн болоод банкуудын өөрийн хөрөнгийн холбогдох дүгнэлтийг арилжааны банкуудад мэдээлсэн.

Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХБЗА)-ыг хэмжих зорилгоор Монголбанк макро эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлын төсөөлөл зэрэг ирээдүйг харсан хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдээллүүдийг ашигласан. Гэвч аливаа эдийн засгийн таамаглалын адилаар тэдгээрийн тохиолдох магадлал, төсөөлөл нь тодорхой бус байх өндөр боломжтой бөгөөд тиймээс бодит үр дүн нь төсөөллөөс ихээхэн өөр байх магадлалтай. Тодруулга 39-д Монголбанк ХБЗА загварт ирээдүйг харсан мэдээллүүдийг хэрхэн ашигласан талаар илүү дэлгэрэнгүй тусгасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТОГТОЛЦОО, ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ БОЛОН ТОЛИЛУУЛГА

Тайлан бэлтгэх үндэслэл. Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх болон үндсэн хөрөнгө, Эрдэнэсийн сан, санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээг тайлант үеийн орлого зарлагад бодит үнэ цэнийн дагуу бүртгэх мөн бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн дагуу бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэж тайлагнасан болно. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудыг Тодруулга 3-т толилуулсан. 2018 оны 1-р сарын 1-ээс хүчинтэй болсон СТОУС 9 болон СТОУС 15-ийг авч хэрэглэхэд үүссэн нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтүүдээс бусдаар эдгээр бодлогуудыг өөрөөр заагаагүй бол толилуулагдсан бүх тайлант үеүдэд нэгэн адил дагаж мөрдсөн болно. Тодруулга 3 болон 46-г үзнэ үү.

Тайлагналын мөнгөн нэгж. Энэхүү санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-өөр илэрхийлэгдсэн болно.

Санхүүгийн тайланг баталгаажуулсны дараа өөрчлөлт хийх тухай Банкны удирдлага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан өдрөөс хойш хугацаанд эдгээр санхүүгийн тайлангуудад өөрчлөлт хийх эрхтэй болно.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Санхүүгийн хэрэгсэл – гол хэмжилтийн нэр томьёо. Бодит үнэ цэнэ нь мэдээлэл бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн буй үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдан авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой гүйлгээ хангалттай их хэмжээгээр тогтмол гардаг, тэдгээрийн үнийн мэдээллийг хэдийд ч авах боломжтой газрыг хэлнэ. Санхүүгийн хэрэгслийн санал болгож байгаа үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад санхүүгийн байгууллагуудаас тогтмол нийтэд зарладаг буюу мэдээлэл нь нээлттэй олдох боломжтой ба эдгээр үнийн дагуу зах зээл дээр холбоогүй этгээдүүдийн хооронд байнгын тогтмол гүйлгээ хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үздэг.

Харин зах зээлийн үнийн талаар мэдээлэл олдохгүй тохиолдолд зарим санхүүгийн хэрэгслийг тэдгээрийн бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл холбоогүй талуудын хооронд сүүлийн үед хийгдсэн хэлцлийн үнэ, эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэх гэх мэт үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцдог. Үнэлгээний аргачлалууд нь зах зээлд тогтмол ажиглагдаагүй мэдээлэл ашиглах тохиолдолд таамаглал хийхийг шаардаж болно. Хэрэв энэ мэт таамаглалыг зохистой өөр боломжит хувилбараар өөрчилсөн тохиолдолд орлого, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөрийн дүнд томоохон өөрчлөлт гарч болохоор бол холбогдох тодруулгуудыг эдгээр санхүүгийн тайлангуудад хийсэн болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт болон урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэгслийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардал, мөн нэрлэсэн үнээс аливаа урамшууллын эсвэл хямдруулалтын дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт багтана. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан урамшуулал ба хямдруулалтыг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны турш дансны үнээс тооцогдох хүүгийн түвшинг тогтмол байлгах аргаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын орлого, эсвэл гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны турш хямдруулж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн түвшин юм.

Үр ашигт хүүг хувьсах хүүтэй хэрэгслийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч уг хэрэгсэлд тусгагдсан хувьсах хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хямдруулалтыг, мөн зах зээлийн түвшинд тохируулагдахгүй бусад хувьсах хүчин зүйлүүдээс үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулан тооцно.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авсан эсвэл үүсгэсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө зээлийн үнэ цэнэ буурсан бол үр ашигт хүүг ч мөн үнэ цэнийн бууралтад тохируулан бүртгэнэ, жишээ нь: гэрээнд заасан эргэн төлөлтийн оронд анх хүлээн зөвшөөрсөн ирээдүйн мөнгөн урсгалд тулгуурлан тооцоолно.

Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх. Тайлант үеийн орлого зарлагад бодит үнэ цэнэ нь илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслүүдийг анх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх бүртгэх бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр баталгаажсан байдаг. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан бөгөөд үүнийг зөвхөн ижил төстэй хэрэгслийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа хүлээгдэж буй зээлийн алдагдлын (“ХЗА”) санг хорогдуулсан өртгөөр бүртгэж хэмжих санхүүгийн хөрөнгөд болон бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийг бүртгэж хэмжих өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтад хүлээн зөвшөөрөх ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн алдагдалд хүргэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл. Банк нь санхүүгийн хөрөнгийг дараах хэмжилтийн төрлүүдээр ангилна: Орлого зарлагаарх бодит үнэ цэнэ (“ОЗБҮЦ”), Дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (“ДОБҮЦ”) болон Хорогдуулсан өртөг (“ХӨ”). Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) банкны холбоотой хөрөнгүүдийг удирдах бизнесийн модел (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес модел. Бизнес модел нь Банк хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлвэл Банкны зорилго нь (i) зөвхөн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес моделд хамааруулан ангилах ба Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес моделийг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Банкны хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн бизнес моделийг тодорхойлоход Банкны ашигласан үнэлэлтүүдийг тодруулга 4-өөс үзнэ үү.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог. Бизнес модел нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй (ЗХҮТ) эсэхэд үнэлгээ өгнө. Гэрээний мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуутдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд тогтвортой эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхэд үнэлгээ өгнө.

Гэрээний нөхцлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. ЗХҮТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгүүдэд ЗХҮТ шалгалт хийхэд Банкны ашигласан үнэлэлтүүдийг тодруулга 4-өөс үзнэ үү.

Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал. Багцыг удирдаж байгаа бизнес модел бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэгслийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес модел өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлагналын үеийн эхнээс хэрэгжинэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сан. Банк нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, баталгаатай холбоотой хүлээгдэж буй алдагдлыг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг ("ХЗА") хэмжиж, алдагдлын хасагдуулгыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жигнэсэн дүн; (ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг Санхүүгийн байдлын тайланд ХЗА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон баталгааны хувьд ХЗА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь тайлагнана. ДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд хорогдуулсан өртгийг хассан дүн нь орлого зарлагаар хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод ДОБҮЦ-рх өрийн хэрэглүүрийн алдагдлыг хассан дүнгээр тайлагнагдана.

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа зээлийн чанарт үндэслэсэн үнэ цэнийн бууралтад "3 шатлал" бүхий дараах загварыг ашиглана. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугааа дуусах хүртэл (12 сарын ХЗА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ.

Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХЗА).

Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэх ба ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Банкны зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолт болон дефолтын тодорхойлолыг Тодруулга 39-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХЗА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дах ХЗА-тай ижил хэмжигдэнэ. ХЗА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал болон тооцооллын аргуудыг Тодруулга 39-өөс үзнэ үү.

Санхүүгийн хөрөнгө - Өөрчлөлт. Банк нь санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцох тохиолдол гардаг. Банк нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өмчийн өгөөж), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх зээлийн сунгалт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож банк нь анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн банк нь шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь хамтрагчийн санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Банк нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөд эрсдэл болон ашиг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон ашиг өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөхгүй. Банк нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн ашиг алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах. Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал. Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахиас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгийн хэмжилтээр ангилна, үүнд (1) орлого зарлагаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр, (2) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалтуудад хамаарна.

Санхүүгийн өр төлбөр - Үл хүлээн зөвшөөрөлт. Санхүүгийн өр төлбөр нь төлж барагдуулснаар үл хүлээн зөвшөөрөгдөнө. (мөн гэрээгээр хүлээсэн үүрэг нь хүчингүй болсон цуцлагдсан үед үл хүлээн зөвшөөрөгдөнө.)

Компани болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл хугацаа бүхий өрийн хэрэглүүр, болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөр үгүй болж шинэ санхүүгийн өр төлбөр бий болсонд тооцогдоно. Шинэ нөхцлөөрх мөнгөн гүйлгээний аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр үгүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн ашиг алдагдал болно. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамж зардал нь өр төлбөрийн дансны үнэд нэмэгдэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацаанд ноогдуулан хорогдуулж тооцно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дансны өртгийн эдийн засгийн шинж чанар нь хөрөнгийн гүйлгээний шинжтэй болсоноос бусад тохиолдолд өрийн хэрэглүүр үл хүлээн зөвшөөрнө гэж үзээгүй өрийн өөрчлөлтийг орлого зарлагаар бүртгэсэн олз, гарзтай нь хамт хуримтлагдсан өөрчлөлтийн аргаар тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлсийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө болон богино хугацаанд зарцуулж болох гурван сараас бага хугацаатайгаар байршуулсан хугацаатай хадгаламж, хугацаагүй хадгаламж орно, мөн түүнчилэн дотоодын валютаар засгийн газрын байгууллагуудад болон дотоодын банкуудад байршуулсан хугацаагүй хадгаламжууд орно. Тодруулга 7-г харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийсэн эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулснаас үүссэн бөгөөд эдгээр нь Үр Ашигт хүүгийн аргыг ашиглан үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийг багтаасан (2) орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр заагдаагүй тул хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн.

Алт ба үнэт метал. Олон улсын стандартын дагуу алт, үнэт металыг гадаадын банкинд биет болон биет бус хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад валютын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металлууд нь трой унцаар хэмжигдэж бүртгэгдэх ба Банкны албан ханшийн дагуу төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханш нь Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан үнэт металын ам.долларын ханшийг Банкнаас зарласан төгрөг-ам.долларын харьцах албан ханшаар төгрөгт хөрвүүлснээр илэрхийлэгддэг болно. Алтыг дээр дурдсан байдлаар эзэмшихээс гадна Банк нь Монгол Улс дахь алт олборлогч аж ахуйн нэгж, иргэдээс цэвэршүүлээгүй алт худалдан авч гадаад зах зээлд цэвэршүүлэн худалддаг (Тодруулга 14).

Алтыг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөх ба ханшийн тэгшитгэлийг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алт ба мөнгөний зах зээлийн үнийг харгалзан үздэг. Ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба энэхүү бодит бус ашиг, алдагдлыг жилийн эцэст өөрийн хөрөнгө дэх “Үнэт металын дахин үнэлгээний сан”-д хаадаг (Тодруулга 26).

Бусад үнэт метал болох дурсгалын зоос болон цэвэршүүлээгүй алт, мөнгө зэргийг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

Эрдэнэсийн сан. Эрдэнэсийн санг 2017 онд бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хүлээн зөвшөөрсөн. Удирдлага нь 2018 оноос эхлэн НББОУС 16-ын дагуу дахин үнэлгээний загварыг ашигласан бөгөөд Эрдэнэсийн сан дахь эд зүйлсийг Олон улсын үнэлгээний стандартын дагуу дахин үнэлсэн. Эрдэнэсийн сангийн дансны өртөг нь тайлант хугацааны эцэст бодит үнэ цэнээр тодорхойлох дүнгээс материаллаг зөрүүгүй байхаар хангалттай давтамжтайгаар байнга үнэлдэг.

Дахин үнэлгээний нэмэгдэл нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдсэн бөгөөд өөрийн хөрөнгө дэх дахин үнэлгээний санг нэмэгдүүлсэн. Ижил төрлийн хөрөнгийн өмнөх үеийн нэмэгдлийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд эздийн өмч дэх өмнөх онуудад хүлээн зөвшөөрөгдсөн байсан дахин үнэлгээний илүүдлийг бууруулсан, бусад бууралтууд нь тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн. Өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн нэмэгдэл нь хэрэгжих үед хуримтлагдсан алдагдал эсвэл ашиг руу шууд шилждэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаад валютын хөрвүүлэг. Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны үндэсний мөнгөн тэмдэгт байна. Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм.

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг холбогдох тайлант үеийн эцэст төгрөгийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжид хөрвүүлж бүртгэнэ. Төлбөр тооцоо хийх болон жилийн эцсийн Төгрөгийн албан ханшид мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэхэд үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд (гадаад валютын хөрвүүлгийн ашиг, алдагдлаар) хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ.

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валют бүхий дүнг хөрвүүлэхэд ашиглагдсан ханш:

	2018 оны 12 дугаар сарын 31 (Төг)	2017 оны 12 дугаар сарын 31 (Төг)
Ам.доллар	2,642.92	2,427.13
		3,441.48
		2,897.87
		371.58
		21,532,489.53
Зээлжих тусгай эрх	3,664.81	3,441.48
Евро	3,028.65	2,897.87
Юань	385.73	371.58
Иен	23.94	21.53

Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө. Банк харилцагч банк руу мөнгө шилжүүлснээр бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ: (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй, (2) орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэхгүй.

Банкууд ба бусад зээлдэгч нарт олгосон зээл, тэдгээрээс авах бусад авлага. Банк нь цааш арилжаалах зорилгогүйгээр харилцагчаас хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, үүсмэл бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх мөнгө шилжүүлсэн үед, Банкууд болон бусад зээлдэгч нарт (жишээ нь Сангийн яам, байгууллагууд) олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө. Эдгээрийг (Сангийн яамны гаргасан засгийн газрын бонд гэх мэт) бизнес моделд үндэслэн хорогдуулсан өртгөөр ангилах бөгөөд мөнгөн урсгалын онцлог нь зээлтэй адил гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй ба зээлийг сайн дураар орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхгүй. Болдошгүй алдагдлын санг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдлыг харсан ХЗА-ын загвараар тооцоолно. ХЗА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 39-өөс үзнэ үү.

СТОУС 13-д тодорхойлсны дагуу тухайн зээл болон бусад авлагыг үндсэн зах зээлийн хэрэгсэл гэж үзсэн тохиолдолд, зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон зээл болон бусад авлагыг анх хүлээн зөвшөөрч бүртгэхэд гарах алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон тухайн зээл болон бусад авлага нь үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд ашиг эсвэл алдагдлаар тайлагнана. Зээл ба бусад авлагын холбогдох ажил гүйлгээ нь Банкны чиг үүрэг болох мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих болон Монголын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд хамаарч байвал үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангасан гэж үзнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 13-ын дагуу үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй, Төв банкны үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй хамааралгүй зээл, бусад авлагыг зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон тохиолдолд анх хүлээн зөвшөөрч бүртгэхэд алдагдлыг хүлээн зөвшөөрөх ба ашиг эсвэл алдагдлаар тайлагнана. Удирдлагын зүгээс энэ талаар хийсэн дүгнэлтийн талаар Тодруулга 4-ийг үзнэ үү.

Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүд. Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогддог худалдах буцаан худалдан авах гэрээг (“репо хэлцэл”) баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. “Репо хэлцэл”-ийн дор худалдсан үнэт цааснуудыг санхүүгийн бүртгэлээс хасдаггүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу тус хөрөнгийг борлуулах болон дахин барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг “Буцаан худалдан авах авлага” гэж ангилахаас бусад тохиолдолд үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд дахин ангилдаггүй.

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөхөөр олгосон буцаан худалдах хэлцлийн (“урвуу репо хэлцэл”) дагуу худалдан авсан үнэт цаасыг гадаадын байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Буцаан худалдан авах болон худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн түвшингөөр “репо” хэлцлийн хугацааны турш хуримтлуулна.

Буцаан худалдан авах болон худалдах гэрээгээр зарсан үнэт цаасны ангилалд үндэслэн Банк нь буцаан худалдан авах гэрээнүүдийг хорогдуулсан өртгөөр ангилна.

Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт. Бизнес модел болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн Банк нь өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөрх эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээрх гэж ангилна. Хэрэв өрийн үнэт цаас нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй бол мөн хэрэв нягтлан бодох бүртгэлийн зөрүүг ихээхэн багасгахын тулд сайн дураар орлого зарлагаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй бол хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Хэрэв өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах, зарах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй бол мөн хэрэв ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй бол өрийн үнэт цаасыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Эдгээр хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хүлээгдэж буй алдагдлын загвараар тооцоолсон болзошгүй алдагдлын хорогдуулгыг тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дансны өртгийн бусад өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг данснаас хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй ологоос орлого зарлагад дахин ангилна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт. Хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг Банкнаас гаргасан өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж үзнэ, жишээ нь бэлэн мөнгө төлөх гэрээний үүрэг хариуцлагыг агуулаагүй хэрэгсэл мөн хувьцаа гаргагчийн цэвэр хөрөнгөд ашиг сонирхол нь байгаа гэдгийг нотлох хэрэгсэл. Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ, учир нь эдгээр хөрөнгө оруулалтууд нь зөвхөн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүртэх гэхээсээ илүү стратегийн зорилготой байна. Бодит үнэ цэнийн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба борлуулах үед ч ашиг, алдагдалд дахин ангилаахгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз үүсвэл үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Банк төлбөр хүлээн авах эрхтэй болох үед ногдол ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж гэхээс илүү хөрөнгө оруулалтын буцаан төлөлт байдлаар авахаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Засгийн газрын үнэт цаас. Энэ хөрөнгөд Банк өөрөө эзэмшиж, эргүүлэн авах зорилготой, эргэн төлөлтийг тодорхойлох боломжтой, тусгайлан заасан хугацаанд эргүүлэн төлөгдөх санхүүгийн үүсмэл бус хөрөнгүүд орно. Удирдлага нь засгийн газрын үнэт цаасны ангиллыг анх хүлээн зөвшөөрөхдөө тодорхойлох бөгөөд тайлант үеийн эцэст ангилал нь зохистой эсэхэд үнэлэлт өгнө. Засгийн газрын үнэт цаасыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн гадаад валютын форвард, своп болон хүүгийн своп хэлцлүүд багтана. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг бол өр төлбөрөөр тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Банк нь хейджийн бүртгэлийг хэрэглэдэггүй.

Бусад хөрөнгө. Бусад хөрөнгө нь авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Өрийн бичгийн авлагаас бусад авлага нь аккрузл суурийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Авлагын болзошгүй алдагдлын нөөц санг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдлыг харсан ХЗА-ын загвараар тодорхойлно. ХЗА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 39-өөс үзнэ үү.

Өрийн бичгийн авлага нь орлого зарлагаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн дараа үеийн хэмжилтийг хийхдээ тайлант үе бүрийн зах зээлийн хүүгээр мөнгөн урсгалын хямдруулалтын аргыг ашиглана. Өрийн бичгийн хувьд зах зээлийн хүү нь Монголбанкны бодлогын хүү дээр нэмэх нь 2 хувь байна.

Барилга болон бусад үндсэн хөрөнгө. Барилгыг дор дурьдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банк эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст дахин үнэлж баталгаажуулдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгийн холбогдох дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний хорогдлыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийн сангаас бууруулна; харин бусад бүх хорогдлыг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг, алдагдлаар шууд хаана. 2017 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байхгүй гэж удирдлага үзэж байна.

Банк эзэмшиж буй тоног төхөөрөмжийг бүргэхдээ өртгөөс үнэ цэнийн бууралт болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь бүртгэнэ. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант хугацааны эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулах зардлыг хассан дүн эсвэл түүний ашиглалтын үнэ цэнийн дүнгийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулж гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийдэг.

Олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулдаг ба олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад (бусад үйл ажиллагааны орлого, зардлын хэсэгт) бүртгэнэ.

Элэгдэл. Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Харин, үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн хувьд тэдгээрийн өртгийг доор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

	Ашиглалтын хугацаа, жилээр
Барилга	6 – 60 жил
Оффисын болон компьютер, тоног төхөөрөмж	3 – 20 жил

Банк ашиглаглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийн үлдэх өртгийг тооцохдоо тухайн үед борлуулалтаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг авдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацааг тайлант хугацааны эцэст дахин үнэлж, шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Биет бус хөрөнгө. Банкны биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай ба капиталжуулсан компьютерын програм хангамжууд багтсан байна. Худалдаж авсан компьютерын програм хангамжуудыг ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгасан. Биет бус хөрөнгийн дүнг 4 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө нь Монголбанкнаас 1993 оны 9 дүгээр сард гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт бөгөөд тэдгээрийг нэрлэсэн үнээр нь өр төлбөрөөр бүртгэдэг. Банк нь бусад банкууд болон харилцагчид бэлэн мөнгө олгох үед гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнийн дагуу өр төлбөрөөр бүртгэдэг. Банк бэлтгэл сан болон гүйлгээ кассет буй төгрөгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулж тооцдоггүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төв Банкны үнэт цаас. Банкны гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

Засгийн газрын хөрөнгө. Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын данс нь Засгийн газар болон бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр ба үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Засгийн газрын хөрөнгийн дийлэнх нь Олон Улсын Валютын Сан (ОУВС), Герман улсын Засгийн газар (КФВ), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлтэй холбоотой. (Тодруулга 19).

Гадаад өр төлбөр. Гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөр нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Гадаад төлбөрийн дийлэнх хэсгийг Хятадын Ардын Банк (Хятадын Төв банк)-аас авсан хэлэлцээр хамаарна. (Тодруулга 24).

Дотоодын банкуудын хөрөнгө. Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхэд дотоодын банкуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Болзошгүй алдагдлын нөөцийн сан. Энэ нь өр төлбөрийн цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай болон энэхүү үүргийг хүлээх нь найдвартай тооцоологдож, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд нөөцийн санг тооцож бүртгэнэ.

Олон Улсын Валютын Сантай хамааралтай үйл ажиллагаа. Монгол Улс болон Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) харилцаан дах Банкны үндсэн үүргээс шалтгаалж Банк нь ОУВС-тай хамтран ажилладаг. Банкны санхүүгийн тайланд СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС-ийн хөтөлбөртэй холбоотой тооцоог хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн Банк нь СТОУС-ын хүрээнд хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-д хамаарал бүхий тооцоог өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөрүүд. Эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн ОУВС-тай холбоотой хөрөнгөнд Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-ээр илэрхийлэгдсэн хөрөнгө багтана (Тодруулга 8). ОУВС-д өгөх өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөрүүд багтана (Тодруулга 24).

ЗТЭ-ээр бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах албан ханшаар хөрвүүлсэн. Төгрөг, ЗТЭ-ийн албан ханшийг ОУВС-гийн тогтоосон ЗТЭ, ам.долларын ханшийн мэдээлэл болон Банкны тайлант хугацааны ам.доллар болон төгрөгийн албан ханшид үндэслэн тооцсон.

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай холбоотой хөрөнгүүд. Банк нь холбогдох ОУВС-гийн сангуудыг худалдан авалттай холбоотой гэрээт эрх, үүрэггүй учир ОУВС-тай холбоотой тодорхой хөрөнгүүд СТОУС-ын дагуух хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтод нийцдэггүй. Эдгээр хөрөнгөнд ОУВС-д хувь нийлүүлсэн хөрөнгө болон ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд авсан зээл багтана. Банк нь Монгол Улсын Засгийн газарт ОУВС-тай харилцахад нь санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Иймд, Монгол Улсын ОУВС-аас авах авлага болон (ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө зэрэг) ОУВС-д төлөх өр төлбөрүүд нь Сангийн яамны хөрөнгө, өр төлбөр болох учир Банкны санхүүгийн тайланд тусгагдаагүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэхүү хувь хөрөнгөнд тулгуурлан Монгол Улс нь ОУВС-гийн гишүүн орны хувьд зээлж авч болох тусгай төрлийн хөрөнгийн хуваарилалтын дүн болно. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улс орон тус бүрийн хувьд өөр байдаг бөгөөд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-гийн Удирдах Зөвлөлөөс тогтоодог. Гишүүн байгууллагын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн квот ногдох оролцогчийн хувь хүртэх хувь хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсэг нь МУ-ын Сангийн яамны зүгээс баталгаажуулсан үнэт цааснаас бүрдэх ба энэхүү үнэт цаас нь хүүгүй. Мөн үлдэх хэсэг нь ОУВС-д өгөх төлбөрүүдээс бүрдэх ба данс №1, №2 –ын талаар тодруулсан болно. Зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хувьд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 72.3 сая ЗТЭ (2017 онд 72.3 сая ЗТЭ) байна. Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү квотын төлбөрийг хийдэг тул Сангийн яамны актив хөрөнгөнд бүртгэгдэнэ.

ОУВС-д гаргасан үнэт цаас. Эдгээр үнэт цаас нь ОУВС-гийн зүгээс Монгол Улсын үндэсний валютад хуваарилагдах хувийг төлөөлөх ба дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоонд үндэслэн баталгаажуулсан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ хийсэн байгуулсан тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

ОУВС-ийн данс №1 болон №2. Сангийн худалдан авалт, дахин худалдан авалт болон хувь нийлүүлсэн хөрөнгийн ажил гүйлгээ гүйцэтгэхэд данс №1-г ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд данс №2-г ашигладаг. Данс №1 болон №2 нь 2017 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр материаллаг бус үлдэгдэлтэй байна.

Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ). 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ-ийн хүрээнд ОУВС-гаас Монгол Улсад олгосон жилийн 1.53-аас 1.59 хувийн хүүтэй зээл юм. Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-нд Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Монголбанкинд шилжүүлсэн.

Зээл болон түүний эргэн төлөлт нь Зээлжих Тусгай Эрх (“ЗТЭ”)-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк нь Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг хийнэ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд өгөх өр төлбөрийн хэмжээ 3 жилийн хугацаатай, 157.9 сая ЗТЭ буюу 578,771 сая төгрөг (2017: 84.0 сая ЗТЭ буюу 288,976 сая төгрөг) байна. (Тодруулга 22).

Дүрмийн сан. Дүрмийн сан нь Өөрийн хөрөнгөнд багтдаг (Тодруулга 26).

Ерөнхий нөөцийн сан. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар жилийн цэвэр орлогын хамгийн багадаа 40 хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилах ба үлэх хэсгийг (ө.х. хамгийн ихдээ 60 хүртэлх хувийг) Улсын Төсвийн данс руу шилжүүлж болно. Ерөнхий нөөцийн сан нь зөвхөн тодорхой хугацааны туршид хуримтлуулсан ба Банк өөрөө захиран зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг агуулдаг. Энэ санд Улсын төсөвт хуваарилсан болон цаашид хуваарилах дүнг оруулдаггүй. Учир нь эдгээр нь Засгийн газарт тухайн тайлант жилдээ шилждэг. Тайлант хугацааны бодит бус ашиг, алдагдал гарсан үйл ажиллагааны алдагдлыг хаах хангалттай нөөц байхгүй тохиолдолд ерөнхий нөөцийн сангаас хаадагнөхдөг болно. 2018 болон 2017 онд Банк нь хуримтлагдсан алдагдалтай ажилласан тул шилжүүлэг хийгээгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад нөөц. Бусад нөөцөд гадаад валют, алт, үнэт метал, барилгын болон эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сан болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний санг оруулдаг (Тодруулга 26). Банк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу гадаад валют, алт үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг гадаад валют болон мөнгөжсөн алт, үнэт металын дахин үнэлгээний санд жил бүрийн эцэст шилжүүлдэг ба харин бодит бус алдагдлыг холбогдох сангуудаар хаадаг.

Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага. Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байдаг ба үүнд аккредитив болон Хятадын Ардын банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон санхүүжилт болон Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон санхүүжилт юм (Тодруулга 37).

Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлага нь 1) анхны хүлээн зөвшөөрөлтийн хорогдуулалтыг тооцоогүй төлбөрийн тооцооны үлдэгдэл үүн дээр нэмээд 2) хүлээгдэж буй алдагдлын загвараар тодохойлсон эрсдэлийн сангийн дүнгээр хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дүнд хураамж авдаг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацаанд харгалзуулан орлого гэж хүлээн зөвшөөрдөг.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлдэгээс бусад өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг. Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлдэг өрийн хэрэгслийн (өрийн бичиг) хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцоолж Тайлант үеийн ашиг алдагдлын тайланд “Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалын зөрүү” хэсэгт харуулна.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

Бэлэн мөнгө хэвлэхтэй холбогдож гарсан зардлууд. Банк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээрийг үйлдвэрлэлээс Банкны бэлтгэл фондод шилжих үед зардал гэж хүлээн зөвшөөрдөг.

Ажилчдын зардал болон холбогдох шимтгэлүүд. Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг (ээлжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, шагнал урамшуулал болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) Банк ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралтын мөнгө, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг, ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин өвчний улмаас чөлөө авах гэх мэт нөхөн олговортой богино хугацаат чөлөө авалтыг чөлөө авсан тухайн үед хүлээн зөвшөөрдөг болно.

Ажилтнуудын тэтгэмж. Банк нь өөрийн дотоод журамд үндэслэн ажилтнуудын ажлын нөхцөл байдлыг сайжруулах, нийгмийн халамжийн асуудлыг шийдэх үүднээс тодорхой хөрөнгийг нийгмийн хөгжлийн санд хуваарилж, хуримтлуулдаг. Эдгээр дансыг тэтгэмж, нөхөн олговор, ажилтнуудын гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллыг олгох, ажилтнуудын нийгмийн халамжийн хүрээнд бусад хэрэгцээг хангах зэрэгт ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Удирдлага нь 2017 оны 12 дугаар сарын 31 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тусламж, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тусламж тэтгэмжийн үүргүүдийн өнөөгийн үнэ цэнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа үнэлгээний тооцоо (актуар)-ны олз гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

Орлогын албан татвар. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байдаг.

Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын байдлаар тодруулах нь. Банк нь үйл ажиллагааны тодорхой мөчлөггүй бөгөөд санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь тайлагнадаггүй болно. Харин үүний оронд хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн хөрвөх чадварын дарааллаар тодруулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг тус бүрийн хувьд тайлант хугацааны эцсээс 12 сараас дотогш эсвэл дээш хугацаанд төлөгдөх эсвэл хүлээн авах байдлаар нь дараах хүснэгтэд нэгтгэж тодруулав.

	2018 оны 12 дугаар сарын 31			2017 оны 12 дугаар сарын 31		
	Төлөгдөх болон хүлээн авах		Нийт	Төлөгдөх болон хүлээн авах		Нийт
	дүн			дүн		
	Тайлант хугацаа-наас 12 сарын дотор	Тайлант хугацаа-наас 12 сарын дараа		Тайлант хугацаа-наас 12 сарын дотор	Тайлант хугацаа-наас 12 сарын дараа	
<i>Сая төгрөгөөр</i>						
Бэлэн мөнгө	72,027	-	72,027	76,895	-	76,895
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	2,868,239	-	2,868,239	3,136,251	-	3,136,251
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	1,206,765	3,470,424	4,677,189	-	-	-
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	5,139	6,595	11,734	-	-	-
Санхүүгийн хэрэгсэл – борлуулахад бэлэн	-	-	-	371,975	2,594,287	2,966,262
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,406,320	57,292	2,463,612	3,019,141	64,846	3,083,987
Алт ба үнэт метал	2,185,657	-	2,185,657	544,207	-	544,207
Эрдэнэсийн сан	-	931,241	931,241	-	-	-
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	50,943	148,714	199,657	12,686	43,046	55,732
Засгийн газрын үнэт цаас	699	63,632	64,331	105,238	57,789	163,027
Дотоодын банкуудад олгосон зээл	267,184	175,109	442,293	134,304	726,054	860,358
Бусад хөрөнгө	105,510	735,280	840,790	15,215	679,688	694,903
Үндсэн болон биет бус хөрөнгө	-	74,451	74,451	-	34,635	34,635
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	4,144	-	4,144	4,778	-	4,778
Нийт хөрөнгө	9,172,627	5,662,738	14,835,365	7,420,690	4,200,345	11,621,035
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(968,618)	-	(968,618)	(906,396)	-	(906,396)
Төв банкны үнэт цаас	(5,005,515)	-	(5,005,515)	(3,444,401)	-	(3,444,401)
Засгийн газрын хөрөнгө	(1,100,174)	(29,933)	(1,130,107)	(1,850,408)	(30,256)	(1,880,664)
Дотоодын банкуудын хөрөнгө	(4,215,585)	-	(4,215,585)	(3,116,298)	-	(3,116,298)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(94,592)	(274,118)	(368,710)	(84,706)	(226,766)	(311,472)
Гадаад өр төлбөр	(4,906,130)	-	(4,906,130)	(4,737,952)	-	(4,737,952)
Бусад өр төлбөр	(114,766)	(1,929)	(116,695)	(41,947)	(3,185)	(45,132)
Нийт өр төлбөр	(16,405,380)	(305,980)	(16,711,360)	(14,182,108)	(260,207)	(14,442,315)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Банк нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн нь дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэрхэн нөлөө үзүүлэх талаар ач холбогдол бүхий таамаглал, үнэлэлтүүдийг хийдэг. Удирдлага нь өөрсдийн туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн үнэлэлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилан тооцооллыг тогтмол хянадаг болно. Мөн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад ач холбогдол бүхий тооцооллуудаас гадна тодорхой үнэлэлтүүдийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө болон өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд томоохон (мэдэгдэхүйц) хэмжээний тохируулга хийх шаардлага үүсэж болох ба үүнд дараах зүйлс хамаарна.

Тасралтгүй байх зарчим. Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны өөрийн хөрөнгө сөрөг, өр төлбөртэй гарсан ба Банк нь Үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргагч этгээд тул төгрөгийн хувьд хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж үзсэн бөгөөд урьдчилан харах болон ирээдүйд тасралтгүй байх зарчмын дагуу Банк үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхгүй байх эрсдэл тохиолдохгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

Өрийн үнэт цаасны санхүүгийн хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт. ХЗА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна. ХЗА-ын хэмжилтын арга зүйн дэлгэрэнгүйг Тодруулга 39-өөс харна уу. Зээлийн эрсдэлийн санд дараах бүрэлдэхүүнүүд чухал нөлөөтэй: дефолтын тодорхойлолт, зээлийн эрсдэлийн томоохон өсөлт, дефолт болох магадлал, дефолт болсон үеийн дүн, дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ мөн макро эдийн засгийн хувилбарын загвар.

Банк нь Хорогдуулсан Өртгөөр болон Бусад Дэлгэрэнгүй Орлогоорх Бодит Үнэ Цэнээр гэж ангилагдсан бүхий л өрийн үнэт цаасуудад ХЗА-ын хэмжилтийг хийдэг ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол болон бодит зээлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах модел болон түүнд ашиглах өгөгдлүүдийг байнга хянаж үздэг.

Зээлдэгч талууд нь олон улсын санхүүгийн байгууллагууд эсвэл дотоодын банкууд учир Банк ХЗА-г хэмжихдээ олон улсын үнэлгээний байгууллагуудын гаргасан зээлийн үнэлгээг суурь болгосон хялбарчилсан арга зүйг ашигладаг. Удирдлага нь Дефолт болох Магадлалын Үнэлгээний Судалгаанд тулгуурлан зээлдэгч талын зээлийн үнэлгээ нь ирээдүйг харсан мэдээллийг агуулдаг гэж таамагладаг.

Түүний дагуу тухайн үнэлгээгээ дараагийн 12 сарын хугацааны турш хадгалах өндөр магадлал (80%)-тай гэдгийг харгалзан Банк нь хамгийн шилдэг нэг хувилбарыг ашигладаг. Энэ дүгнэлтэнд хүрэхийн тулд Банк дефолт болох магадлалын хувьд үнэлгээг +/- 1 түвшингээр өөрчлөн мэдрэмтгий байдлын дүн шинжилгээг хийсэн бөгөөд үүний үр дүнд ХЗА-ийн дүнд 740 сая төгрөгийн (2017: 960 сая төгрөг) материаллаг бус нөлөө гарсан. Хэрэв дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь одоогийнхтой харьцуулвал 10 хувиар их эсвэл бага тохиолдолд, ХЗА нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 784 сая төгрөгөөр (2017: 1,200 сая төгрөг) өснө эсвэл буурна.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Банк тайлант үеийн эцэст санхүүгийг хэрэглүүрийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Үнэлгээгээр тайлант үеийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Банк нь бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйг харсан мэдээлийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг. Тодруулга 39-ийг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бизнес моделийн үнэлгээ. Бизнес модел дээрээс үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага бизнес моделийн үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэгслүүдийн багц болон ижил байдлын түвшинг тодорхойлохдоо үнэлэлт өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ Банк нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Зээл чанаргүйдсэнээс үүдэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ нь “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн моделтой таарч байна. Зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх борлуулалтууд ч мөн дангаараа болон бүлгээрээ олон давтамжтай биш эсвэл үнийн дүнгийн хувьд их биш гэдгийг харгалзан “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн моделтой таарч байна. Мөн түүнчилэн зөвхөн стрессийн тохиолдлын үед эсвэл Банкны хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд Банкны зүгээс таамаглах боломжгүй байх ба бизнесийн моделийн зорилгын хувьд тохиолдлын гэж үзэх учир тухайн санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй.

“Гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах” бизнес модел нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь мөн энэхүү бизнес моделийн зорилгыг биелүүлэхэд чухал, үүнд хөрвөх чадвартай байдлаа удирдахын тулд, тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд, эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулахын тул гэх мэт.

Үлдсэн ангилалын гол зорилго нь худалдан борлуулсанаас үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор удирдаж байгаа санхүүгийн хөрөнгийн багцууд багтах бөгөөд жишээ нь өмнө нь худалдан борлуулсан төлөв байх ёстой. Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес моделийн хувьд заримдаа тохиолддог.

СТОУС 9-д шилжих үед Банк борлуулахад бэлэн үнэт цааснуудынхаа багцыг хэрхэн эдгээр хөрөнгийг удирдаж байгаа гэдгээс хамааран 2 дэд багцад хуваасан. Ойролцоогоор 60% нь хөрвөх чадвартай багц гэж үзэн “Гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах” ангилалд багтаж үлдсэн нь зөвхөн стрессийн тохиолдлын үед зарагдах үнэт цаасууд гэж үзсэн учир “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” ангилалд багтсан.

Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ. Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс (“ЗХҮТ”) бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Мөнгөний үнэ цэнийн элемент нь хувирах магадлалтай, жишээ нь хэрэв гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэгслийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй байдаг, жишээ нь зээлийн хүүнд банк хоорондын 3 сарын хүүг ашигладаг боловч хүү нь сар бүр өөрчлөгддөг. Хувиргасан мөнгөний үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэгсэлтэй харьцуулалт хийх байдлаар үнэлах бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрт болон хэрэглүүрийн хугацааны туршид хуримтлуулан хийнэ. Үнэлгээг хамгийн боломжит бүх тохиолдолд хийсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдож болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд ч мөн хийсэн байна. Мөнгөн урсгал нь жишиг үзүүлэлтээс ихээхэн зөрүүтэй байх тохиолдолд үнэлгээ хийгдсэн хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ гэж үзэхгүй бөгөөд тухайн хэрэглүүрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэнэ. ЗХҮТ шалгуурыг даваагүй хэрэглүүрүүд ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Тодруулга 5-ыг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сангийн яамнаас авсан зээлийн болон дотоодын банкинд олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт. Банк нь 40,186 сая төгрөг (2017 онд 32,326 сая төгрөг)-ийн Сангийн яамнаас авсан зээлтэй (Тодруулга 22) ба энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Герман улсын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн Хөгжлийн Банк болон Герман улсын (KfW) Засгийн газрын санхүүжилттай.

Энэ эх үүсвэр нь маш бага буюу жилийн 0.75-аас 1 хувийн хүүтэй, сонгогдсон эдийн засгийн секторууд болон бусад бага хүү шаардлагатай өөр бусад тусгай зорилтуудыг хангах зорилгоор зээлдүүлэх нөхцөлтэй.

Бид энэхүү зээлийг анхны хүлээн зөвшөөрөлт болон эхэлж бүртгэхдээ ашиг бүртгэх шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн. Ингэхдээ эдгээр зээлийг харилцан тохиролцсон төсөлд заасан тусгай зорилготой зах зээлд зориулсан буюу нийтийн ашиг сонирхолд үйлчлэх хүүгүй эсвэл маш бага хүүтэй зээлийн хэрэгсэл хэмээн удирдлага үзсэн. Энэхүү зээлийн эх үүсвэрийг ашиглан тодорхой шалгуур хангасан арилжааны банкуудад бага хүүгээр санхүүжилт хийх буюу зээл олгох боломжтой байна. Иймд эдгээр зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

Санхүүжилтийн үр дүнд Банк нь шаардлага хангасан банкуудад хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох боломжтой болсон. Удирдлага нь дээрх хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх үед алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Эдгээр зээлүүд нь холбоогүй талуудад олгогдсон учир зээлийг зах зээлийн хүүгээр олгосон бөгөөд анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн. Дээрх үнэлэмжид эдгээр хэрэгслүүд нь анхдагч зах зээлд олгогдсон гэдгийг авч үзсэн болно.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ. Банк эрсдэлийн удирдлагын зорилгоор бусад банкуудтай үүсмэл хэрэгслийн хэлцлүүдийг тогтмол хийдэг. Эдгээр үүсмэл хэрэгслийг бодит үнэ цэнээр бүртгэдэг.

2014 оны эхний улирлаас эхлэн Банк нь дотоодын банкуудтай урт хугацааны шинэ своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 2-5 хүртэлх жилийн хугацаатай урт хугацаат төгрөг/ам.долларын своп хэлцлүүд болно. Банк нь 2017 оны 12 дугаар сараас хойш дотоодын банкуудтай шинэ урт хугацаат хүүгийн своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 1-ээс 8 жилийн хугацаатай хүүгийн томъёололд үндэслэсэн төгрөг-ам.долларын своп хэлцэл юм.

Дээрх хэлцлүүдийн форвард ханшийг Мөнгөний Бодлогын Газраас эконометрик загвар ашигласан үнэлгээний аргачлалаар тооцоолсон. Дээрх урт хугацаат хэрэгслүүдийн үнийн талаар зах зээлийн мэдээлэл байхгүй. Удирдлага эконометрик загвар ашиглан форвард ханшийг тооцоолох нь хүүгийн аргад суурилсан томъёог ашигласнаас илүү оновчтой гэж үзэж байна. Ажиглагдахуйц зах зээлийн мэдээлэлд суурилагагүй төсөөлөл ашиглан үнэлсэн хэрэгслийн талаарх мэдээллийг Тодруулга 42-оос үзнэ үү.

Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн ба хэлцлүүд зах зээлд оролцогчдын хувьд сайн дурын үндсэн дээр явагдсан тул олз гарз үүсэхгүй гэж удирдлага үзсэн. Мөн тус үнэлэмж, дүгнэлтийг хийхэд үндсэн зах зээлийн хэрэгслийг илэрхийлж байна гэж удирдлага үзсэн болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад 2012 оны 11 дүгээр сараас олгож эхэлсэн. Эдгээр зээлүүдийг Засгийн газраас тогтоосон нөхцөлөөр олгосон ба Банк нь эдгээр зээлүүдийн нөхцөлийг тодорхойлоход ямар нэгэн эрхгүй байсан болно. Мөн тус хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газар тодорхойлж, тогтоосон бөгөөд Банкнаас санхүүжилтийг нь өгсөн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан компаниуд хүлээн авах эрхтэй. Үүний үр дүнд дотоодын банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 0.89-өөс 4 хувь байх боломжийг Засгийн газар бүрдүүлсэн. Бид эдгээр зээлүүдийн хүүг зах зээлийн хүүтэй адилтган үзэж, анх хүлээн зөвшөөрөх үед аливаа ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн. Энэхүү зээл нь Төв банкны үндсэн үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах зорилгын хүрээнд зах зээлд мөнгөний нийлүүлэлтийг хийсэн бөгөөд зээлүүд тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) мөн болохыг бид харгалзаж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 436,781 сая төгрөг (2017 онд 836,153 сая төгрөг) байна. Дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 9, холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3-г харна уу.

Хадгаламжийн даатгалын корпорацид (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэг (зээлийн) анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Төрийн банкинд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацид 119,900 сая төгрөгийг жилийн 0.5 хувийн хүү болон 85,000 сая төгрөгийг жилийн тэг хүүтэй 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олгосон. Монгол улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго болон банкны системийн дахин санхүүжилтийг эцсийн зээлдүүлэгчийн хувьд зохион байгуулсан онцлог байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлага тус санхүүгийн дэмжлэг бүхий зээл үндсэн зах зээлийн хүүгийн түвшинг илэрхийлнэ гэж дүгнэсэн. Эдгээр зээлийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 193,710 сая төгрөг (2017 онд 193,709 сая төгрөг). Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 18-аас үзнэ үү.

Зах зээлийн түвшингөөс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт. СТОУС 9-д санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх дүн нь түүний бодит үнэ цэнэ байна гэж заасан. Санхүүгийн хэрэгсэл нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй болон эсвэл зах зээлийн бус хүүгээр олгогдсон тохиолдолд бодит үнэ цэнийг холбогдох үнэлгээний аргуудыг ашиглаж тодорхойлж болно. Тус үнэлэмжийг хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төстэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн аргыг ашиглана. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Тодруулга 3)-д тодруулсны дагуу, удирдлага нь мөн чанарын хувьд Төв банкны үндсэн чиг үүргийг илэрхийлж чадахгүй байгаа дараах ажил гүйлгээнүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай гэж үзсэн.

- Банк нь 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Хөгжлийн банкны нийт 60,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 4 хувийн хүүтэй буюу зах зээлийн үнээс доогуур хүүтэй өрийн бичгийг эзэмшиж байв. Эдгээр өрийн бичгийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 31,397 сая төгрөг байсан бөгөөд Хөгжлийн банкны үнэт цаасны нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн хоорондын зөрүү болох 28,603 сая төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны ашиг/алдагдалд хүлээн зөвшөөрсөн. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн бичгийн дансны үнэ 44,305 сая төгрөг (2017: 39,860 сая төгрөг) байсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 10-аас үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- “Сайн” хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд Банк 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1-3 хувийн хүүтэй засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан. Удирдлага эдгээрийг 123,668 сая төгрөгийн бодит үнэ цэнэ бүхий санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн ба анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь 330,044 сая төгрөг байсан. Энэ гарзыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Сайн” хөтөлбөртэй холбоотой үнэт цаасны дансны үнэ 65,265 сая төгрөг (2017: 60,112 сая төгрөг) байсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 17-оос үзнэ үү.
- Банк нь дотоодын харилцагч нарт тодорхой шалгуур нөхцөлүүдийг хангасан тохиолдолд зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доор болтол бууруулах боломжтой зээлийг өрийн бичиг барьцаалж 2014 онд 350,000 сая төгрөг, 2016 онд 465,000 сая төгрөгөөр олгосон байна. Удирдлага гэрээний нөхцөл, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг холбогдох мэдээлэлд тулгуурлан эдгээр зээлүүдийн анх үүсгэх үеийн тохирох үр ашигт хүүг үнэлсэн байна. Удирдлага эдгээр зээлдэгчид заасан нөхцөлийг хангах магадлал өндөр гэж дүгнэсэн байна. Тиймээс эдгээр бууруулсан хүү нь Монгол улсад байх ижил төрлийн санхүүгийн хэрэгслийн зах зээлийн хүүг төлөөлөхгүй тул удирдлага анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг тооцоолсон. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд 84,574 сая төгрөгийн алдагдлыг анх хүлээн зөвшөөрсөн ба тухайн өдрөөр авлагын хувьд бодит үнэ 265,426 сая төгрөг байна гэсэн тооцоог хийсэн. Мөн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тухайн зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ нь 371,722 сая төгрөг, мөн өдрөөр хүүгийн орлогыг зах зээлийн түвшингөөс доогуур олгосон хүүгийн түвшинг харгалзуулан тооцоход 93,278 сая төгрөгний алдагдлыг хүлээж байна. СТОУС 9-ийг анх авч хэрэгжүүлсэн өдрөөс ЗХҮТ шалгуурын дагуу эдгээр авлагыг орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх хөрөнгө гэж ангилсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 18-аас үзнэ үү.
- Банк 2016 онд урвуу буцаан худалдан авах хэлцэл хийсэн. Энэ гэрээ нь 2016 оны 9 сарын 30-ны өдрийг хүртэл жилийн хувьсах хүүгээс 3 хувь хүүг хасаж тооцох ба 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс жилийн 7.5 хувь тогтмол хүүтэй болсон. Удирдлага тус хэлцлийг зах зээлийн хүүгээс доогуур хүү гэж үзэж байгаа бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, хүлээн зөвшөөрөх анхны бодит үнэ цэнэ нь 150,000 сая төгрөг, хүлээн зөвшөөрөлтийн алдагдал нь 23,426 сая төгрөг байсан. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх дансны үнэ нь 67,403 сая төгрөг (2017: 159,857 сая төгрөг) байсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 13-аас үзнэ үү.

Зах зээлийн хүүгээс доогуур үнэлэгдэх хөрөнгүүдийн анх хүлээн зөвшөөрсөн алдагдлыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Дээрх ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлтийн хувьд алдагдлын хэмжээг тодорхойлохдоо, холбогдох ажил гүйлгээний талаарх мэдээллийг хооронд нь харьцуулах болон дараах итгэл үнэмшлүүдэд үндэслэн дүгнэлтийг хийсэн. Үүнд :

- Банкны бодлогын хүү нь Монгол улсын Засгийн газар болон тухайн зээлдэгчийн хувьд эрсдэл гарсан тохиолдолд арилжааны банкуудад олгосон санхүүжилт нь зах зээлийн хүүгийн түвшинг ойролцоогоор илэрхийлж төлөөлөхүйц байна гэж үзсэн;

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Банкны бодлогын хүү нь жилд 2 хувиар ахиуц байдлаар нэмэгдсэн байгаа нь дотоодын компаниудад өрийн бичгээр (Тодруулга 15) баталгаажиж олгогдсон төгрөгийн зээлийн хүүгийн түвшиний эрсдэлийг ойролцоогоор илэрхийлнэ гэж үзсэн.

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт. Банк Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д хяналтын эрхтэй эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд түүнийг нэгтгэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ХДК-ийн эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаа дахь оролцооноос өгөөж хүртэх нөхцөл байдал, ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар. Банк ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Банк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу Үндэсний хороо нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:
- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга; ХДК-ийн Гүйцэтгэх захирал;

Гурван гишүүнийг Банкны Ерөнхийлөгч, Сангийн сайд болон Банкуудын холбооноос нэр дэвшүүлнэ, харин Банкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар томилно. (Банкуудын холбоо нь банкуудаас бүрдэх бөгөөд Банк ордоггүй байна.) Корпорацитай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны долоон гишүүний саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давуу эрхгүй байна. Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг дангаар удирдах эрхгүй. Мөн Банк бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд Удирдлага ХДК-ийн үйл ажиллагааг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн болно.

Хадгаламжийн даатгалын корпорацид (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэгийн үнэ цэнийн бууралтын буцаалт. 2013 онд Банк Монголын банкны секторыг тогтворжуулах үндсэн зорилгоор 119,900 сая төгрөгийн жилийн 0.5%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай зээлийг ХДК-д олгосон. Уг зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-нд эргэн төлөгдөх, жил бүр хүү төлөх гэрээний нөхцөлтэй. Төрийн банкны хувьцааг худалдан авах Засгийн газрын шийдвэрийн хүрээнд Банк мөн онд ХДК-д 85,000 сая төгрөгийн богино хугацаат санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд ХДК нь Төрийн банк ХХК-ийн 75 хувийг эзэмших болсон. Гэрээнд зааснаар, Төрийн банк ХХК-ийн хувьчлалын орлогоос болон Төрийн банк ХХК-ийн тухайн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлүүлнэ гэж заасан байдаг.

Төрийн банк хувьчлагдах эсэх нь өмнөх онуудад тодорхойгүй байсан учир 85,000 сая төгрөгийн зээлийг 2014 онд мөн 119,900 сая төгрөгийн зээлийг 2016 онд нийт днгээр нь эрсдэлийн сан байгуулсан. 2018 оны 5 дугаар сард засгийн газар хэлэлцэж “2018 – 2020 онуудад төрий өмчийн банк/ компаниудын хувьчлал”-ийг УИХ-д танилцуулахаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын намрын чуулганаар батлуулна гэсэн хүлээлттэй байна. Тиймээс удирдлага 2018 онд бий болсон байдлыг харгалзан үнэ цэнийн бууралтыг дахин үнэлсэн. Банк зээлүүдийг 3 дугаар шатлалаар үнэлсэн бөгөөд зээлийн эрсдэлийн санг 115,000 сая гэж үнэлсэн. Ингэснээр 78,700 сая төгрөгийн эрсдэлийн сангийн буцаалтыг орлого зарлагаар хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 18-ыг үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт. Банк нь Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналтын эрхтэй эсэх болон тэдгээрийг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагатай эсэхийг тодорхойлохдоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн:

- Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкныг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Хэдийгээр Банк нь Эрх хүлээн авах үйл ажиллагааны хүрээнд банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуу Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн газрын нэрийн өмнөөс олгох болно. Ийм учраас эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн газрын бондын хэлбэртэй байна гэж удирдлага үзэж байна;
- Эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанаас авсан үр өгөөж бага байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн хэдийгээр Банк нь эрх хүлээн авсан банкуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

Дүрмийн сангийн нэмэгдэл. 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн 10 дугаар тушаалын дагуу Банк эрсдэлийн сангийн буцаалтыг хурмтлагдсан алдагдлын данснаас тусгаарлан дүрмийн санг 55,000 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. 2017 оын 9 дүгээр сарын 25-ны өдрийн Банкнаас Улсын Их Хуралд (УИХ) хүргүүлсэн саналд үндэслэн 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн УИХ-ын 70 дугаар тогтоолоор дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлэх зөвшөөрлийг Банкинд олгосон. Эдийн засгийн байнгын хороо (ЭЗБХ) нь 2019 оны 3 дугаар сарын 4-ний 11/2200 тоот албан бичгээр гүйлгээний хэрэгжилтийг баталгаажуулсан. Тиймээс, удирдлагын зүгээс энэхүү гүйлгээ нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа бөгөөд тайлбарын тодорхой бус байдлын эрсдэл нь бага гэж үзэж байна. Удирдлага нь УИХ-ын 70 дугаар тогтоолд УИХ-аас өөрийн онцгой эрхээ Банкинд шилжүүлсэн тодорхой заалт байхгүйтай холбогдуулан Банкны дүрмийн санг нэмэгдүүлсэн шийдвэрийн эрх зүйн үндэслэлийн талаар гуравдагч тал маргах тохиолдолд УИХ-аас өөр байр суурь илэрхийлэх улмаар А-10 дугаар тушаалыг хүчингүйд тооцуулах арга хэмжээ авах эрсдэлийг үнэлсэн. Тодруулга 26, 37 болон 42-г харна уу.

Барилгын дахин үнэлгээ. Банк нь барилга байгууламжийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад орлогод дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг. Банк 2018 онд барилгын бодит үнэ цэнийг үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулсан. Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн бусад хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн. Дахин үнэлгээгээр 18,500 сая төгрөгийн нэмэгдэл үүссэн бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 19 болон 26-г харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрдэнэсийн сан. Банк нь Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Эрдэнэсийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах ганц байгууллага юм. Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болон өв уламжлагдсан үнэт зүйлс мөн 1925 онд гаргасан мөнгөн зоос зэргээс бүрдэнэ. Эдгээр зүйлсийг музейд олон нийтэд үзүүлдэг бөгөөд музейн тасалбараас олсон орлогыг Банкны ашиг, алдагдлын тайланд бусад үйл ажиллагааны орлогоор бүртгэдэг. Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газар энэхүү Сангийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, харуул хамгаалалтын удирдлагыг хариуцдаг. Тиймээс удирдлага Эрдэнэсийн сангийн эдийн засгийн үр өгөөж нь Банкинд орж байгаа бөгөөд Санг Монгол Улсын Эрдэнэсийн сангийн хуулиар Банк хянадаг учир Эрдэнэсийн санг санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзэж байна. 1938 онд зооснуудыг гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудыг Монголбанкны өмнөх буюу түүнд эрхээ шилжүүлсэн банк гаргасан боловч засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж удирдлага үзэж байгаа учраас хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх нь зөв гэж үзэж байна.

Зоос нь дараах хүчин зүйлст үндэслэн хүлээн зөвшөөрөх шалгууруудыг хангасан гэж Банкны удирдлага үзэж байна:

- 1925 онд гаргасан Монгол Улсын мөнгөн зооснуудыг Монгол Улсын Сангийн яамны шийдвэрээр 1938 онд гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудын оронд шинэ мөнгөн тэмдэгтийг гаргасан.
- Эрдэнэсийн санг байгуулах засгийн газрын шийдвэрийн дараа засгийн газраас эдгээр зооснуудыг Санд хандивласан бөгөөд Монголбанк нь Санг удирдах үүрэг хариуцлагын хүрээнд зооснуудыг хянах, хамгаалах үүрэг хүлээсэн.
- Засгийн газраас эдгээр зоосыг зарах, шилжүүлэх зөвшөөрлийг авсаны дагуу гуравдагч талд зоосийг худалдан борлуулсан/шилжүүлсэнээс үүссэн олз, гарзыг хуримтлуулах эрхтэй.

Хэмжилт. Эрдэнэсийн сан нь 2017 оноос өмнө өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг байсан. 2018 оноос эхлэн Банк Эрдэнэсийн санг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний компанийн бэлтгэсэн тайланд үндэслэн бодит үнэ цэнээр хэмжин бүртгэсэн. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эрдэнэсийн сангийн дансний өртөг 6,247 сая төгрөгөөс дахин үнэлгээний дараах дүн болох 931,241 сая төгрөг болж өссөн. Олон улсын үнэлгээний стандартын дагуу үнэлгээнд шууд харьцуулалтын арга болон өртгийн аргыг ашигласан.

Зах зээл дээр шууд ажиглагдах мэдээлэл дээр үндэслээгүй таамаглалыг ашиглан үнэлсэн зүйлсийн бодит үнэ цэнийн талаар мэдээллийг Тодруулга 40-өөс харна уу.

Тайлант үеийн эхэнд шинэ нягтлан бодох бүртгэлийн журмыг өмнөх бүх онуудад ашиглаж хуримтлагдсан нөлөөг тодорхойлох нь боломжгүй байсан учир Удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн журмыг аль болох боломжит өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдсэн. Энэ үнэлгээнд удирдлагын тухайн эд зүйлс дэх туршлагад тулгуурласан үнэлэлт өгөх, таамаглал гаргах шаардлагатай байдаг бөгөөд Тодруулга 40-өөс дэлгэрэнгүйг харна уу. Үнэлгээнд ашигласан гол өгөгдлүүдийн мэдрэмтгийн байдлын шинжилгээг Тодруулга 15-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ

СТОУС 9, “Санхүүгийн хэрэгслүүд”-ын өөрчлөлт: Банк нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн СТОУС 9 - "Санхүүгийн хэрэгсэл" -ыг мөрдөж эхэлсэн. Банк нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн өмнөх оны дүнг дахин тайлагнахгүй байхаар шийдсэн бөгөөд энэхүү стандартыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөр буюу 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн эхний үлдэгдэлд залруулга хийхээр болсон. Үүний үр дүнд, СТОУС 7 - "Санхүүгийн хэрэгслийн тодруулга" -ын шинэчилсэн шаардлагуудын дагуу, зөвхөн тайлант хугацаатай холбогдолтой тодруулгуудыг тодруулсан.

Зэрэгцүүлэгдэх тайлант үеийн тодруулгууд нь өмнөх тайлант үед хийсэн тодруулгуудтай ижил болно. Энэ онд хамаарах чухал стандартуудыг Тодруулга 3-т тайлбарласан. 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө хамаарах мөн харьцуулагдах мэдээлэлд хамаарах стандартуудыг Тодруулга 44-т тодруулсан.

Дараах хүснэгтэд НББОУС 39-ийн дагуу өмнө нь хэмжиж байсан санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн дансны үнийг нэгтгэж, 2018 оны 1-р сарын 1-ний өдөр СТОУС 9-ийг мөрдсөний дараа тодорхойлсон шинэ дүнгүүдийг нэгтгэсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Хэмжилтийн ангилал		2017 оны 12-р сарын 31-ний байдлаар НББОУС 39-ийн дагуух дансны үнэ	СТОУС-ийг хэрэгжүүлсний дараах нөлөө				2018 оны 12-р сарын 31-ний байдлаар СТОУС 9-ийн дагуух дансны үнэ
	НББОУС 39	СТОУС 9		Дахин ангилал		Дахин хэмжилт		
				Зайлшгүй	Сайн дурын	ХЗА	Бусад	
Сая төгрөгөөр								
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	З&А	ХӨ	76,895	-	-	-	-	76,895
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	З&А	ХӨ	3,136,251	-	-	-	-	3,136,251
Дотоодын банкуудад олгосон зээл	З&А	ХӨ	860,358	-	-	(8,130)	-	852,228
Урвуу Буцаан худалдан авах гэрээ	З&А	ХӨ	3,083,987	-	-	-	-	3,083,987
Бусад санхүүгийн хөрөнгө								
Өрийн бичиг	З&А	ОЗБҮЦ	690,933	-	-	-	(1,211)	689,722
Бусад хөрөнгө	З&А	ХӨ	9	-	-	-	-	9
Алт ба үнэт метал	АЗХ	ОЗБҮЦ	429,440	-	-	-	-	429,440
Үүсмэл санхүүгийн хэргсэл	АЗХ	ОЗБҮЦ	55,732	-	-	-	-	55,732
Investments in debt securities								
ОУ-ын Төлбөр Тооцооны банкны Бонд	ББХ	ДОБҮЦ	314,953	-	-	-	-	314,953
АНУ-ын Засгийн газрын бонд	ББХ	ДОБҮЦ	247,591	-	-	-	-	247,591
РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	ББХ	ДОБҮЦ	248,872	-	-	-	-	248,872
Давуу эрхтэй ИЗББ	ББХ	ХӨ	2,103,252	-	-	-	-	2,103,252
Хөгжлийн банкны үнэт цаас	ББХ	ХӨ	39,860	-	-	-	-	39,860
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт								
МИК –д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт – бодит үнэ цэнээр	ББХ	ДОБҮЦ	5,139	-	-	-	-	5,139
Өмчийн хөрөнгө оруулалт - өртгөөр	ББХ	ДОБҮЦ	6,595	-	-	-	-	6,595
Засгийн газрын үнэт цаас	ДХХЭХ	ХӨ	163,027	-	-	-	-	163,027

а) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн бүх ангиллуудыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртгөөрх" хэмжилтийн ангилалруу дахин ангилсан. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Тодруулга 7-д тодруулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)***б) Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө***

Тодруулга 8-д тодруулсанчлан Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн бүх ангиллудыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртгөөрх" хэмжилтийн ангилалруу дахин ангилсан.

в) Дотоодын банкуудад олгосон зээл

Тодруулга 9-д тодруулсанчлан дотоодын банкуудад олгосон зээлийн ангиллыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртгөөрх" хэмжилтийн ангилалруу дахин ангилсан. Дотоодын банкуудад олгосон зээлийн СТОУС 9-ийн дагуух хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний шилжилтийн өдрөөрх байдлаар 8,130 сая төгрөгөөр өссөн.

г) Урвуу буцаан худалдан авах хэлцэл

Тодруулга 10-д тодруулсанчлан урвуу буцаан худалдан авах хэлцлийн ангиллыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртгөөрх" хэмжилтийн ангилалруу дахин ангилсан.

д) Бусад санхүүгийн хөрөнгө

Өрийн бичгийн авлагыг НББОУС 39 -ын дагуу хорогдуулсан өртгөөрх "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжилтийн ангилалруу дахин ангилсан нь ЗХҮТ шалгуурын дагуу гэрээний нөхцөлөөр тодорхой үйл ажиллагааны үүрэг хариуцлагын хүрээнд хүүгийн түвшинг бууруулах нөхцөлтэй байсан бөгөөд энэ нь мөнгөний үнэ цэнэ болон зээлийн эрсдэлийг нөхөх ямар ч хамааралгүй байсантай холбоотой.

Үлдсэн бусад санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртгөөрх" хэмжилтийн ангилалруу дахин ангилсан.

е) Алт ба үнэт метал

Алт ба үнэт металын ангиллыг НББОУС 39 -ын дагуу Борлуулах зорилгоор эзэмшиж буй хэмжилтийн категориас СТОУС 9-ын дагуу орлого зарлагаарх бодит үнэ цэнийн хэмжилтийн ангилал руу дахин ангилсан.

ё) Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн ангиллыг НББОУС 39 -ын дагуу Борлуулах зорилгоор эзэмшиж буй хэмжилтийн төрлөөс СТОУС 9-ын дагуу орлого зарлагаарх бодит үнэ цэнийн хэмжилтийн ангилалруу дахин ангилсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)**ж) Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт**

Дахин ангилал хийгдсэн шалтгаануудыг доор харуулав:

Хөрвөх чадвартай багц дахь үнэт цааснууд нь гэрээт мөнгөн урсгалыг нь цуглуулах зорилготой гэж тодорхойлогдсон. Банкны хөрвөх чадвартай гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах зорилготой багцууд дахь үнэт цааснуудын бизнес моделийг үнэлсний дараагаар Банк нь тусгайлан удирддаг, өмнөх туршлагаас харахад (Банкны зорилго хэвээр байна) гэрээний мөнгөн урсгалыг нь цуглуулах зорилготой тодорхой хэдэн үнэт цааснуудыг таньсан. Иймээс Банк эдгээр бүлэг үнэт цааснуудад тохирох бизнес моделийг мөнгөн урсгалыг цуглуулах зорилготой гэж үнэлсэн. Өмнө нь борлуулахад бэлэн үнэт цаас ангилалд байсан эдгээр үнэт цааснуудыг анх ашигласан өдрөөс нь хорогдуулсан өртгөөрх гэж ангилагдсан байсан. Банкны үлдсэн хөрвөх чадвартай багцыг гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах гэж ангилсан.

Хэмжих аргад нь өөрчлөлт ороогүй өмнөх ангиллаас дахин ангилагдсан. Доорх өрийн хэрэгслүүд нь СТОУС 9-ийн дагуу шинэ категорит дахин ангилагдсан ба өмнөх НББОУС 39-ийн категориос чөлөөлөгдөж хэмжилтийн суурьт өөрчлөлт ороогүй байна:

- Өмнө нь борлуулахад бэлэн хөрөнгөд ангилагдаж байсан ба одоо бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх ангилалд орсон
- Дуусах хугацаа хүртэл нь байлгах хөрөнгөд ангилагдаж байсан одоо хорогдуулсан өртгөөр хэмжигдэх ангилалд орсон. (засгийн газрын үнэт цаас)

з) Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт

СТОУС 9-өөр зөвшөөрсний дагуу Банк нь зарим стратегийн өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтуудаа буцаах боломжгүйгээр Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжих ангилалд ангилсан. Эдгээр үнэт цааснууд нь өмнө нь борлуулахад бэлэн хөрөнгөд ангилагдаж байсан. Эдгээр үнэт цааснуудын бодит үнэ цэнийн өөрчлөлт нь үнэ цэнийн бууралт үүсэх үед эсвэл зарах үед ашиг, алдагдлаар дахин хүлээн зөвшөөрөгдөхгүй болно.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх үнэ цэнийн бууралтын сан болон 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаарх зээлийн эрсдэлийн сангийн хоорондын тохируулга. НББОУС 39-ийн учирсан алдагдлын загварын дагуу хэмжсэн дотоодын банкуудад олгосон зээлийн сан 964 сая төгрөг байсан бол 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар СТОУС 9-ийн хүлээгдэж буй алдагдлын загварын дагуу хэмжигдсэн шинэ зээлийн эрсдэлийн сангийн дүн 9,094 сая төгрөг байсан. Бусад өрийн үнэт цаасны санхүүгийн хэрэгслийн дүн материаллаг бус зөрүүтэй байсан.

2017 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар санхүүгийн үүсмэл хэрэгслээс бусад Банкны бүх санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр бүртгэсэн. Үүсмэл хэрэгсэл нь НББОУС 39-ийн ОЗБҮЦ хэмжилтийн ангилалд багтана. Бусад өрийн үнэт цаасны санхүүгийн хэрэгслийн дүн материаллаг бус зөрүүтэй байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх СТОУС 9-д шилжсэний дараах нөөц болон хуримтлагдсан ашгийн нөлөөний шинжилгээг харуулав

Сая төгрөгөөр	Банкны эздэд хамаарах			
	Дүрмийн сан	Хуримтлагдсан алдагдал	Бусад нөөц	Нийт
СТОУС 9-с өмнөх 2017.12.31-ний байдлаарх дүн	5,000	(2,844,603)	18,323	(2,821,280)
СТОУС 9-ийн дагуу дахин ангилагдсан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн дахин хэмжилт	-	(1,211)	-	(1,211)
Хорогдуулсан өртгөөрх өрийн санхүүгийн хөрөнгийн болон зээлтэй холбоотой үүрэг хариуцлагын СТОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн ХЗА	-	(8,130)	-	(8,130)
2018.01.01 байдлаар (СТОУС 9-ийн дагуу)	5,000	(2,853,944)	18,323	(2,830,621)

Сөрөг төлбөртэй урьдчилсан төлбөрийн нөхцөлүүд - СТОУС 9-д орсон өөрчлөлтүүд (2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайланд дагаж мөрдөнө). Банк нь нэмэлт өөрчлөлтийг анх 2018 оны 1 дүгээр сарын 1-нд гарсан хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэ эхэлсэн. Нэмэлт өөрчлөлт нь хорогдуулсан өртгөөс бага дүнгээр урьдчилж төлөх боломжтой зээл ба өрийн үнэт цаасыг хорогдуулсан өртгөөр хэмжих боломжийг олгодог. Жишээлбэл, бодит үнэ цэнээр эсвэл хэрэглүүрийн үлдсэн хугацаандах зах зээлийн хүүгийн түвшингийн өсөлтийг тооцсон өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү зээлдэгчид төлбөл зохих төлбөрийн дүнгээр бүртгэнэ. Үүнээс гадна, стандартын дүгнэлтэнд нэмсэн хэсэг нь СТОУС 9-ын одоо байгаа удирдамжийг дахин баталж байгаа ба үл хүлээн зөвшөөрөх байдалд хүргээгүй хорогдуулсан өртгөөр хэмжигдэх тодорхой санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт эсвэл залруулгууд нь орлого үр дүнгийн тайланд олз, гарзаар бүртгэгдэнэ. Тиймээс Банк нь зээлийн өөрчлөлтийн улмаас үүсэх ашиг, алдагдалын нөлөөллөөс зайлсхийхийн тулд зээлийн үлдсэн хугацааны үр ашигт хүүний түвшинг шинэчлэдэггүй. Банкны хувьд шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд томоохон хэмжээний нөлөөлөл үзүүлэхгүй.

СТОУС 15 "Хэрэглэгчидтэй хийх гэрээний орлого" (2014 оны 5 дугаар сарын 28-нд батлагдсан ба 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө мөн СТОУС 15-ын Нэмэлт өөрчлөлт, Харилцагчидтай хийсэн гэрээний орлого (2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө) Банк нь СТОУС 15 "Хэрэглэгчидтэй хийх гэрээний орлого"-ыг анх дагаж мөрдөх ёстой 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Шинэ стандартыг өнгөрснийг эргэн харсан хувиргасан аргыг ашиглан хэрэгжүүлсэн бөгөөд нийлмэл нөлөө нь 2018 оны 1 дүгээр сарын 1-нд хуримтлагдсан ашигт хүлээн зөвшөөрсөн Шинэ стандартаар бараа, ажил үйлчилгээг харилцагчид шилжүүлсэн үед ажил гүйлгээний үнээр орлогыг заавал хүлээн зөвшөөрнө гэсэн үндсэн зарчимтай.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ
(ҮРГЭЛЖЛЭЛ)**

Салгаж болохуйц багцын бараа, ажил үйлчилгээний орлогыг салгаж бүртгэнэ, гэхдээ гэрээний хөнгөлөлт, урамшууллыг холбогдох зүйлд нь заавал хуваарилж бүртгэнэ гэж заасан. Хэрэв аливаа шалтгааны улмаас орж ирэхүнийн дүн нь өөр өөр үед буцаалт хийгдэх эрсдэлгүй бол хамгийн бага дүнг хүлээн зөвшөөрнө. Харилцагчидтай байгуулсан гэрээний эрсдэлийг бууруулахтай холбоотой гарсан зардлыг капиталжуулж гэрээний орлого олох хугацаанд хорогдуулна. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш нэмэлт өөрчлөлт орсон дараах стандартуудыг Банк дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд Банкны хувьд материаллаг нөлөө байхгүй байна:

- СТОУС 2-ын өөрчлөлт, Хувьцаанд суурилсан төлбөр (2016 оны 6 дугаар сарын 20-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө).
- СТОУС 4 Даатгалын гэрээнд СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийг ашиглах - СТОУС 4-ийн өөрчлөлт (2016 оны 9 дүгээр сарын 12-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн түр зуурын хөнгөлөлтийг сонгосон компаниуд, эсвэл давхарлах сонголтыг хийсэн компаниудын хувьд СТОУС 9-ийг ашиглаж эхлэх үеэс мөрдөгдөнө).
- 2014-2016 оны СТОУС-ын жилүүдийн сайжруулалт - СТОУС 1 ба НББОУС 28-ын өөрчлөлт (2016 оны 12 дугаар сарын 8-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө).
- СТОУТХ 22 “Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүд болон урьдчилан анхаарал хандуулах” (2016 оны 12 дугаар сарын 8-ны өдөр гаргасан ба 2018 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад хүчин төгөлдөр)
- Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн шилжүүлэг - НББОУС 40-ийн өөрчлөлт (2016 оны 12 дугаар сарын 8-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД

2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

СТОУС 16, Түрээс (2016 оны 1 дүгээр сарын 13-нд батлагдсан ба 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад хүчин төгөлдөр). Шинэ стандартаар түрээсийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон тодруулгыг хэрхэн бэлтгэх талаар зарчмуудыг бий болгосон. Бүх түрээсийн хувьд түрээслэгч нь түрээсийн эхэнд хөрөнгийг ашиглах эрхийг гэрээ хүчин төгөлдөр болсон хугацаанаас эхлэн эзэмших ба хэрэв түрээсийн төлбөр олон удаагийн төлбөрөөр хийх бол түрээслэгч түрээслүүлэгчээс санхүүжилт авсан гэж үзнэ. НББОУС 17-ын дагуу түрээсийг үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилна гэж заасан байсныг хасаж түрээсийн бүртгэлийн нэг л загварыг СТОУС 16-аар танилцуулсан. Түрээслэгч (а) 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийн түрээсийн хөрөнгийн үнэ цэнэ бага байхаас бусад тохиолдолд, түрээслүүлж буй хөрөнгийн өртөг материаллаг бус байхаас бусад бүх түрээсийн тохиолдолд холбогдох өр төлбөрийг бүртгэх ба б) орлогын тайланд түрээсийн хөрөнгийн элэгдлийг түрээсийн төлбөрийн хүүгийн зардлаас тусад нь тайлагнана. НББОУС 17-д заасан түрээслүүлэгчтэй холбоотой бүртгэлийн заалтын ихэнх хэсгийг СТОУС 16-д оруулсан. Тиймээс түрээслүүлэгч түрээсийн шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийг ангилж, ангиллын дагуу санхүүгийн тайланд өөр өөрөөр тусгадаг. Банкны хувьд санхүүгийн тайланд материаллаг хэмжээний нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

СТОУТХ 23 “Орлогын татварын журмын тодорхойгүй байдал”. (2017 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө.) НББОУС 12 нь орлогын татвар болон хойшлогдсон татварыг хэрхэн бүртгэхийг тодорхой заасан боловч татварын тодорхойгүй байдлын нөлөөллийг хэрхэн тусгахыг заагаагүй. Орлогын албан татварын журмууд дээр тодорхойгүй байдал үүссэн үед НББОУС 12-ын хэмжигдэхүүний шаардлагууд болон хүлээн зөвшөөрөлтийг хэрхэн хэрэглэх талаар тайлбарт тодруулж өгдөг. Тодорхойгүй байдлын үр дүнг урьдчилан таамаглахдаа илүү сайн хандлагад суурилсан татварын журмын нэг болон хэд хэдэн бусад тодорхойгүй байдлуудыг хамтад нь эсвэл тус бүрд нь татварын журмын тодорхойгүй байдал бүрийг авч үзэх эсэхийг ах ахуйн нэгж байгууллага тодорхойлох хэрэгтэй. Татварын албаныхан татварын дүнг шалгах болно гэдгийг аж ахуйн нэгж байгууллага авч үзэх хэрэгтэй ба хяналт шалгалт хийх үед холбогдох бүх мэдээллийн талаарх бүрэн мэдлэгтэй эсэх, шалгалт хийх эрхтэй эсэхийг авч үзэх хэрэгтэй.

Хэрвээ аж ахуйн нэгж байгууллага нь татварын албаныхан татварын журмын тодорхой байдлыг хүлээн зөвшөөрөх болно гэдэгт магадлалгүй байгаа бол тодорхойгүй байдлын нөлөөлөл нь холбогдох татварын ашиг эсвэл алдагдал, татварын суурь, ашиглагдаагүй татварын алдагдал, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт эсвэл татварын хэмжээг тодорхойлоход тусгагдана. Энд аж ахуйн нэгж байгууллага тодорхойгүй байдлын үр дүнг илүү сайн урьдчилан таамаглахдаа ямар арга хэрэглэсэн гэдгээс хамаарч, хамгийн их магадлалтай дүн буюу хүлээгдэж буй үнэ цэнийг ашигладаг. Шинэ мэдээлэл эсвэл бодит болон нөхцөл байдлуудад нөлөөлөх жишээнүүд нь үнэлэлт эсвэл мэргэжлийн шийдлийн дахин үнэлгээнд орж үр дүнг харуулж чадах боловч эдгээр нь татварын албаны хийсэн үйлдэл эсвэл хяналт шалгалтууд, татварын албаны тогтоосон дүрэм журмын өөрчлөлтүүд эсвэл татварын албаны хяналт шалгалт хийх эсвэл татварын журмын хяналтыг дахин хийх эрхийн хугацаа дуусгавар болох зэргээр хязгаарлагдаагүй байдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Татварын алба татварын журамтай холбоотойгоор тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд тусдаа тайлбарт шаардагдсан үнэлэлт тооцоолол, мэргэжлийн шийдэлд нөлөөлөх шинэ мэдээлэл эсвэл бодит байдал, нөхцөл байдлуудын өөрчлөлтийг бүрдүүлэх боломжгүй юм. Банк нь шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

СТОУС 17 Даатгалын гэрээнүүд (2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2021 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). СТОУС 17 нь СТОУС 4-ыг орлосон бөгөөд практикт хэрэглэгдэж байгаа даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийг хөтөлж хэрэгжүүлэхийг компаниудад олгосон. Үүний үр дүнд ижил төрлийн даатгалын компаниудаас бусад тохиолдолд санхүүгийн гүйцэтгэлийг зэрэгцүүлэн харьцуулахад Хөрөнгө оруулагч нарт хэцүү байсан. СТОУС 17 нь Даатгагчийн эзэмшиж байгаа давхар даатгалын гэрээг хамруулсан даатгалын бүх төрлийн гэрээнүүдийг тайлбарлах нэг зарчимд суурилсан стандарт юм. Стандарт нь групп даатгалын гэрээнүүдийн хэмжигдэхүүн, хүлээн зөвшөөрөлтийг шаарддаг: (i) мөнгөн гүйлгээний гүйцэтгэлийн талаарх бэлэн байгаа бүх мэдээллүүдийг зах зээлийн мэдээлэлд нийцэхүйц байдлаар нэгтгэсэн ирээдүйн мөнгөн гүйлгээний эрсдэлд тохируулагдсан одоогийн үнэ цэнэ (гүйцэтгэлийн мөнгөн гүйлгээ): нэмэх (хэрэв энэ үнэ өр төлбөр бол) эсвэл хасах (хэрэв энэ үнэ хөрөнгө бол) (ii) гэрээний хэрэгжээгүй ашгийг харуулсан дүн (гэрээт үйлчилгээний ашиг). Даатгагч нь даатгалын гэрээний хугацаанд даатгалын бүлэг гэрээний ашгийг хүлээн зөвшөөрч, эрсдэлээс чөлөөлөгдөнө. Хэрэв бүлэг гэрээнүүд алдагдалд хүрэх эсвэл алдагдал гарвал аж ахуйн нэгж нь алдагдалыг нэн даруй хүлээн зөвшөөрөх болно. Банк нь шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

Хараат компани ба хамтарсан үйлдвэр дэх урт хугацааны ашиг сонирхол - НББОУС 28-д оруулсан өөрчлөлтүүд (2017 оны 10 дугаар сарын 12-нд гарсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтүүд нь тайлан гаргаж буй байгууллагууд СТОУС 9-ийг урт хугацаат зээл, давуу эрхтэй хувьцаа болон энгийн хувьцааны хөрөнгө оруулагчийн эрхээс илүү гарсан хөрөнгө оруулагчид ноогдох хараат компаний алдагдлын хэсгээр өмчийн аргаар оруулсан хөрөнгө оруулалтыг бууруулахаас өмнөх цэвэр хөрөнгө оруулалт зэрэг санхүүгийн хэрэглүүрт мөрдөгдөнө. Банк нь шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

2015-2017 оны үед СТОУС-ын жилийн өөрчлөлтийг сайжруулах - СТОУС 3, СТОУС 11, НББОУС 12 ба НББОУС 23-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдан гарсан ба 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтийн хамрах хүрээ нь дөрвөн стандартанд нөлөө үзүүлж байна. СТОУС 3 нь Нэгтгэгч бизнесийн хяналтыг олж авах үед хамтарсан үйл ажиллагаа дахь өмнөх хувь оролцоогоо дахин хэмжих хэрэгтэй. Үүний эсрэгээр, СТОУС 11 нь хараат компани нь хамтарсан үйлдвэр болж хувирах эсвэл эсрэгээрээ хамтарсан үйлдвэр хараат болоход, мөрдөж буй шаардлагын адилаар хамтарсан үйл ажиллагааны хамтарсан хяналтыг олж авснаар хөрөнгө оруулагчид өмнө нь эзэмшсэн хувь оролцоог дахин хэмжих шаардлагагүй гэдгийг тайлбарлаж байна. Өөрчлөгдсөн НББОУС 12 нь тухайн аж ахуйн нэгж холбогдох хуваарилагдах ашгийг (жишээ нь орлого болон үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлого) үүсгэсэн ажил гүйлгээ буюу үйл явдлыг хүлээн зөвшөөрсөн бол ногдол ашгийн орлогын татварыг хүлээн зөвшөөрөхийг тусгасан. Энэхүү шаардлагаар зөвхөн хуваарилагдсан болон хуваарилагдаагүй ашигт ногдуулах татварын хувийн зөрүүнээс үүсэх татварын нөлөө биш харин санхүүгийн хэрэглүүр нь хуваарилсан ашиг байх бүх тохиолдолд дээрх шаардлага нь мөрдөгдөнө. НББОУС 23 нь тусгай хөрөнгийн санхүүжилтад тусгайлан зориулан олж авсан зээлийг тусгай хөрөнгө нь бүрэн гүйцэт дуусах хүртэл капиталжуулах боломжтой ерөнхий зээлийн зардлаас хасахыг тусгасан. Банк нь шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

НББОУС 19-д гарсан өөрчлөлтүүд “Нэмэлт өөрчлөлт, хасалт хийх, төлбөр тооцоог төлөвлөх” (2018 оны 2-р сарын 7-нд батлагдан гарсан бөгөөд 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшихи тайлант хугацаануудад дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтүүдэд тогтоосон тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд тэтгэврийн зардлыг хэрхэн тодорхойлох талаар дурьдсан. Төлөвлөгөөнд хийх өөрчлөлт нь нэмэлт өөрчлөлт, хасалт эсвэл төлбөр тооцоо хийгддэг – СТОУС 19 нь цэвэр тогтоосон тэтгэмжийн өр төлбөр буюу хөрөнгийг дахин хэмжихийг шаарддаг. Төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн дараа тайлант үеийн үлдсэн хэсэгт одоогийн үйлчилгээний өртөг болон цэвэр хүүг тодорхойлохын тулд энэхүү нэмэлт өөрчлөлтөөс шинэчлэгдсэн төсөөллийг ашиглахыг нэмэлт өөрчлөлтүүд шаарддаг. Энэхүү нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаас өмнө төлөвлөгөөнд өөрчлөлт орсны дараах хугацаанд эдгээр зардлыг хэрхэн тодорхойлохыг СТОУС 19 тодорхой заагаагүй болно. Шинэчилсэн төсөөллийг ашиглахыг шаардсанаар нэмэлт өөрчлөлтүүд нь санхүүгийн тайланг хэрэглэгчдэд ашигтай мэдээллийг өгөх болно. Банк нь шинэ стандарт хэрэгжсэнээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээнд гарсан өөрчлөлтүүд (2018 оны 3-р сарын 29-нд батлагдан гарсан бөгөөд 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшихи тайланд дагаж мөрдөнө). Энэхүү үзэл баримтлалын хүрээ нь хэмжигдэхүүний талаарх шинэ бүлэг; санхүүгийн гүйцэтгэлийн тайлагналын удирдамж; сайжруулсан тодорхойлолтууд болон удирдамж – ялангуяа өр төлбөрийн тодорхойлолт; санхүүгийн тайлагналын тодорхойгүй байгаа хэмжигдэхүүн болон тодорхойгүй байдал, үүрэг хариуцлага гэх мэт чухал хэсгүүд дэх тодруулгуудыг багтаасан.

Дээр дурдсанаас бусдаар шинэ стандартууд болон өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайлангуудад томоохон нөлөө үзүүлэхгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	Тодруулга	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Бэлэн мөнгө		72,027	76,895
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө:			
- Гадаад валютын богино хугацаат хадгаламж	8	2,081,845	2,034,346
- Хугацаагүй хадгаламж	8	640,138	956,442
- Зээлжих тусгай эрхийн хадгаламж	8	146,231	145,301
Нийт гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө		2,868,214	3,136,089
Хасах нь: Алдагдлын сан		(152)	-
Нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө		2,940,089	3,212,984

Дээрх дүнгүүдийг Мөнгөн Гүйлгээний Тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтын аргыг Тодруулга 39-өөс үзнэ үү.

2018 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн тайлбарын талаар Тодруулга 39-өөс үзнэ үү.

Сая төгрөгөөр	Гадаад валютын богино хугацаат хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Зээлжих тусгай эрхийн хадгаламж	Нийт
- Онц сайн	2,081,845	640,138	146,231	2,868,214
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр	2,081,845	640,138	146,231	2,868,214

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгоор мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн 1-р шатлалд багтсан. 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Мүүдийс агентлагийн өгсөн зэрэглэлийн дагуу доорх хүснэгтэд харуулав:

<i>Сая төгрөгөөр</i>	Хугацаагүй хадгаламж	Гадаад валютын богино хугацаат хадгаламж	Нийт
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>			
- Ааа зэрэглэлтэй	4,790	194,200	198,990
- Аа1 зэрэглэлтэй	758	-	758
- Аа2 зэрэглэлтэй	41,631	-	41,631
- Аа3 зэрэглэлтэй	434,378	167,439	601,817
- А1 зэрэглэлтэй	284,254	-	284,254
- А2 зэрэглэлтэй	190,631	1,672,707	1,863,338
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, зээлжих тусгай эрхийн хадгаламж болон бэлэн мөнгийг оруулахгүйгээр	956,442	2,034,346	2,990,788

Хэрэв Төв банк эсвэл харилцагч олон улсын санхүүгийн байгууллагын хувьд зэрэглэл байхгүй бол (Жишээ нь Английн Төв банк) тэдгээрийн зэрэглэлийг холбогдох улсын зээлжих зэрэглэлийн дагуу үнэлнэ. Бэлэн мөнгө болон ОУВС дахь ЗТЭ-ийн хадгаламжийн хувьд Банк нь зээлийн эрсдэл хүлээгээгүй болно.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн газар зүйн болон мөнгөн тэмдэгтийн эрсдэлийн шинжилгээ, хүүгийн эрсдэлийн шинжилгээ, дуусгавар хугацааны талаар холбогдох шинжилгээг Тодруулга 39-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	2,081,845	2,034,346
Хугацаагүй хадгаламж	640,138	956,442
Зээлжих тусгай эрх	146,231	145,301
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	166	152
Бусад хувь хөрөнгө	11	10
Хасах нь: Алдагдлын сан	(152)	-
Нийт гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	2,868,239	3,136,251

Богино хугацаат хадгаламж. Эдгээр дүнгүүдэд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан ам.доллар, фунт стерлинг, юаны эхний төлөгдөх хугацаа нь 92 өдрөөс (2017: 30 өдөр) өмнө байх богино хугацаат хадгаламжууд орно.

Хугацаагүй хадгаламж. Энэ дүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансны үлдэгдлүүд багтана.

Зээлжих тусгай эрх. Энэхүү үлдэгдэл нь Олон Улсын Валютын Санд Монгол улсаас төлөх хувь хэмжээтэй холбоотой нөөцийн хөрөнгийг нөхөх зээлжих тусгай эрхийн хадгаламжийг харуулна. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 39.9 сая ЗТЭ (2017 онд 42.2 сая ЗТЭ) дүнтэй байсан бөгөөд энэ нь хүүтэй болно.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа ба түүнд хүү тооцдоггүй (Тодруулга 24). Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул энэ хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүсэхгүй.

Бусад хувь хөрөнгө. Энэхүү үлдэгдэл нь Монгол улс СВИФТ сүлжээнд нэгдэн орох үед төлсөн хураамжтай холбоотой.

Доорх хүснэгтэд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгоор 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг үнэлгээгээр харуулав. Бүх үлдэгдэл эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул 1-р шатлалд багтсан. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн тайлбарын талаар болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтын аргыг мөн гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдэлд хамаарах дефолтын тодорхойлолт болон зээлийн эрсдэлийн томоохон өсөлтийн тодорхойлолтыг Тодруулга 39-өөс үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫГ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	Гадаад валютын богино хугацаат хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Зээлжих тусгай эрх	Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	Бусад хувь хөрөнгө	Нийт
- Онц сайн	2,081,845	640,138	146,231	166	11	2,868,391
Нийт дансны дүн	2,081,845	640,138	146,231	166	11	2,868,391
Алдагдлын сан	(19)	(131)	(2)	-	-	(152)
Дансны дүн	2,081,826	640,007	146,229	166	11	2,868,239

2017 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг дүн шинжилгээг Тодруулга 7-д толилуулсан. ОУВС-ын зээлжих тусгай эрх, Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө болон бусад хувь хөрөнгө Банкыг зээлийн эрсдэлд оруулахгүй бөгөөд энэхүү хөрөнгө эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна.

Эдгээр хөрөнгийн аль нь ч барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. Газар зүйн болон зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээ, валютын ханш, хүү болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 39-өөс харна уу.

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	436,781	836,153
Барьцаат зээл	-	13,670
Бусад зээл	10,552	11,499
Зээлийн алдагдлын сангаас өмнөх дотоодын банкуудад олгосон нийт зээл	447,333	861,322
Хасах нь: Зээлийн алдагдлын сан	(5,040)	(964)
Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл	442,293	860,358

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээлийн нийт дансны дүн болон алдагдлын санийн дүнг ангиллаар нь харуулбал:

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31			2017 оны 12 дугаар сарын 31		
	Нийт дансны дүн	Алдагдлын сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Алдагдлын сан	Дансны дүн
Дотоодын банкуудад олгосон зээл						
Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	436,781	(4,887)	431,894	836,153	-	836,153
Барьцаат зээл	-	-	-	13,670	(964)	12,706
Бусад зээл	10,552	(153)	10,399	11,499	-	11,499
Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл						
	447,333	(5,040)	442,293	861,322	(964)	860,358

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

2012 оны 11 дүгээр сараас Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд тодорхой салбаруудын (шатахуун, хүнс, барилга гэх мэт) дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлэх зорилгоор төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон.

Эдгээр зээлүүд Засгийн газрын хамтарсан шийдвэрээр тодорхойлсон нөхцөлийн дагуу олгогдсон бөгөөд Банкны зүгээс нөхцөлийг тогтоох эрх мэдэл байгаагүй. Мөн энэхүү хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газар тодорхойлсон бөгөөд зээл олгох шийдвэр гаргасан тохиолдолд дотоодын банкууд Банкнаас санхүүжилтийг нэхэмжлэн авч, компаниудад дамжуулан олгосон. Дотоодын банкуудад дэд хөтөлбөрөөс шалтгаалан жилийн 0.89-өөс 4.00 хувийн хүүтэй зээл олгосон.

Банк нь Засгийн газар, Монголын ипотекийн корпорац болон дотоодын банкуудтай байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу дотоодын банкуудад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн дүнд давуу эрхтэй ИЗББ авсан.

Банк 2018 болон 2017 онд үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зөвхөн ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг олгосон. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн урьдчилгаа нөхцөл болгон тохиролцсоны дагуу Монголбанк нь Үнэ Тогтворжуулах Хөтөлбөрийн хүрээнд дэх ипотекийн зээлийн багцыг Сангийн яаманд 2018 онд шилжүүлэхээр болсон. Түүнчлэн Монголбанк нь энэхүү зээлийг санхүүжүүлэхгүй бөгөөд одоо байгаа ипотекийн зээлийн эргэн төлөлтөөр дахин санхүүжүүлэхээр тохиролцсон.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 436,781 сая төгрөгийн (2017 онд 834,321 сая төгрөг) санхүүжилтийн үлдэгдэлтэй байна. Банкнаас дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн санхүүжилтийн хүү жилийн 2 хувь болон 4 хувь байсан болно.

Удирдлага үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хувьд хэрэгжүүлсэн эдгээр зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж дүгнэсэн. Тодруулга 4 болон 3-т удирдлагын зүгээс хийсэн холбогдох дүгнэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Барьцаат зээл

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 13,670 сая төгрөгийн жилийн 12.5 хувийн хүүтэй барьцаат зээлийг дотоодын банкинд олгосон. Тус зээл нь харгалзах банкны хувьд зээлийн барьцаагаар хангагдсан болно. 2018 онд эдгээр зээлүүд эргэн төлөгдсөн.

Бусад зээл

Төгрөгөөр олгосон зээл. “Бусад зээл”-ийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 1,491 сая төгрөгийн (2017 онд 651 сая төгрөг) зээл, Герман Улсын Засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 7,533 сая төгрөгийн (2017 онд 8,115 сая төгрөг) зээл багтаж байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон. АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөлтэй холбоотой зээл нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох зорилготой. Зээл нь жилийн 7-оос 10 хувь (2017 онд жилийн 7 хувь)-ийн хүүтэй бөгөөд эргэн төлөлтийн хугацаа олгосон өдрөөс хамаарч ялгаатай байгаа болно.

Монгол Улсын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон зээл нь Герман Улсын Засгийн газар (КФВ)-ын I болон II хөтөлбөрүүдээр дамжин хэрэгждэг.

Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкн дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

Гадаад валютын зээл. “Бусад зээл”-ийн нөгөө хэсэг болох гадаад валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг Герман Улсын Засгийн газрын (КФВ) Монгол Улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон 719 сая төгрөг (2017 онд 1,933 сая төгрөг)-ийн зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах АХБ-ны хөтөлбөрийн 809 сая төгрөг (2017 онд 800 сая төгрөг)-ийн зээл тус бүр бүрдүүлж байна.

Герман Улсын Засгийн газраас Монгол Улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр тусдаа КФВ хөтөлбөрөөр хэрэгжиж байна. Эдгээр зээл нь жилийн 1.25-аас 1.75 хувийн хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажаагүй. Эдгээр хөтөлбөрийн зээлийг дотоодын гурван банкаар дамжуулан КФВ-ийн тогтоосон тодорхой шалгуурт нийцсэн зээлдэгчдэд олгосон. Иймээс эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Энэ зээлтэй холбоотой хийгдсэн удирдлагын үнэлэмжийг Тодруулга 4-өөс харна уу. Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Банк дахь данснаас шууд татах эрхтэй.

Дотоодын банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, банкуудын програм хангамжийг сайжруулах зорилготой зээл нь Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) Лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон. Энэхүү зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2018 оны тайлант үеийн эхэн болон төгсгөлд дотоодын банкуудад олгосон зээлийн нийт дансны дүн болон үнэ цэнийн бууралтын эрсдэлийн нөөцийн хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр	Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	Барьцаат зээл	Бусад зээл	Нийт
2018.01.31-ний байдлаар зээлийн нийт дүн	836,153	13,670	11,499	861,322
Тухайн жилд олгосон зээл	192,692	-	4,492	197,184
Тухайн жилийн эргэн төлөлт	(592,064)	(13,670)	(5,439)	(611,173)
2018.12.31-ний байдлаар зээлийн нийт дүн	436,781	-	10,552	447,333
2018.01.01-ний байдлаар зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц (СТОУС 9-ийн нөлөөний дараа)	8,861	43	190	9,094
Үнэ цэнийн бууралтын буцаалт	(3,974)	(43)	(37)	(4,054)
2018.12.31-ний байдлаар зээлийн алдагдлын сан	4,887	-	153	5,040

2017 оны зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг доор харуулав:

Сая төгрөгөөр	Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	Барьцаат зээл	Бусад зээл	Нийт
2017.01.01-ний байдлаар Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц	-	144	-	144
Үнэ цэнийн бууралтын нөөц	-	820	-	820
2017.12.31-ний байдлаар зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц	-	964	-	964

Доорх хүснэгтэд хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг байгуулсан хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээлийн зээлийн эрсдэлийн шинжилгээг харуулав. Доор харуулсан дотоодын банкуудад олгосон зээлийн дансны дүн нь Банкны эдгээр зээлүүд дэх хамгийн их зээлийн эрсдэлийг харуулж байна. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээлийн чанарыг доор харуулав:

1-р шатлал (12-сарын ХЗА)			
Сая төгрөгөөр	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	Бусад зээл	Нийт
Сайн	369,574	7,649	377,223
Хангалттай	67,207	2,903	70,110
Нийт дансны дүн	436,781	10,552	447,333
Зээлийн эрсдэлийн сан	(4,887)	(153)	(5,040)
Дансны дүн	431,894	10,399	442,293

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн шинжилгээг Мүүдигийн үнэлгээгээр дор үзүүлэв:

<i>Сая төгрөгөөр</i>	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	Барьцаат зээл	Бусад зээл	Нийт
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>				
Саа1	138,313	-	4,324	142,637
Саа2	529,169	-	4,762	533,931
Зэрэглэлгүй	168,671	-	2,413	171,084
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	836,153	-	11,499	847,652
<i>Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй</i>				
- 181-ээс 360 хоногийн хугацаа хэтрэлттэй	-	13,670	-	13,670
Нийт дангаараа үнэ цэнэ нь буурсан зээл	-	13,670	-	13,670
Хасах нь зээлийн алдагдлын сан	-	(964)	-	(964)
Нийт дотоодын банкуудад олгосон зээл	836,153	12,706	11,499	860,358

Тодруулга 39-т тусгаснаар Монгол Улсын томоохон банкуудыг олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагын зүгээс үнэлсэн байдлаар эрэмбэлсэн. Дээрх шинжилгээ олон улсын зэрэглэл олгогч байгууллагуудын хамгийн бага үнэлгээ өгсөн байдалд суурилсан болно. Зэрэглэл олгогдоогүй байгаа Монгол Улсын бусад банкуудын хувьд Банк тухайн банкны хамгийн сүүлийн үеийн санхүүгийн мэдээллүүд, санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн зохистой байдал, холбогдох хөрөнгүүдийн зээлийн чанарыг үнэлэхэд зориулсан бусад мэдээллүүдийг харгалзан авч үздэг болно.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дотоодын банкуудад олгосон зээлийн аль нь ч барьцаагүй байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 13,670 сая төгрөгийн дотоодын банкуудад олгосон барьцаат зээл нь зээлдэгчийн бизнесийн зээлээр барьцаалуулсан байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Сая төгрөгөөр	2018
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх өрийн үнэт цаас	2,255,400
Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас	2,421,789
Нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	4,677,189

Доорх хүснэгтэд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг хэмжих ангиллар харуулав:

Сая төгрөгөөр	Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэх өрийн үнэт цаас	Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас	Нийт
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт:			
Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	789,252	-	789,252
АНУ-ын засгийн газрын үнэт цаас	537,676	-	537,676
Хятадын засгийн газрын бонд	113,770	-	113,770
РАМП хөрөнгө оруулалтын данс	814,822	-	814,822
Давуу эрхтэй ИЗББ	-	2,378,773	2,378,773
Хөгжлийн банкны үнэт цаас	-	44,305	44,305
2018.12.31-ний байдлаар нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт (бодит үнэ цэнээр эсвэл нийт дансны дүн)	2,255,520	2,423,078	4,678,598
Зээлийн эрсдэлийн сан	(120)	(1,289)	(1,409)
2018.12.31-ний байдлаар нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт (дансны дүн)	2,255,400	2,421,789	4,677,189

(а) Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэх өрийн үнэт цаас

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэх өрийн үнэт цаас нь 1-р шатлалд орох ба зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан зээлийн эрсдэлийн үзүүлэлт нь “онц сайн” байна. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийн аргын тайлбарын талаар Тодруулга 39-өөс үзнэ үү.

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) бонд. Өрийн үнэт цаас ба бондын зах зээлийн үнэд тулгуурласан бодит үнэ цэнээр хэмжигддэг. Дээрх бүх бондууд жилийн 2.44 хувийн (2017: жилийн 1.32 хувь) хүүтэй богино хугацаатай буюу дуусах хугацаа нь хамгийн ихдээ 94 хоног (2016: 63 хоног) хүртэлх хугацаатай. Банк эдгээр бондыг өндөр нэр хүндтэй ОУТТБ-ын хувьд бага эрсдэлтэй гэж үзэж хөрөнгө оруулсан. Энэ хөрөнгө оруулалтуудыг 1-р шатлалын гэж үзсэн. Бондууд нь барьцаагүй болно. Тодруулга 39-ыг харна уу.

АНУ-ын Засгийн газрын үнэт цаас. Санхүүгийн жилийн эцсээрх уг хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 204 сая ам.доллар буюу 537,875 сая төгрөг (2017 онд 102 сая ам.доллар буюу 247,591 сая төгрөг) байна. Уг бондын хугацаа нь 2-оос 3 жил (2017: 2-оос 3 жил) ба жилийн 0.9-өөс 2.75 хувийн (2017: жилийн 0.9-өөс 1.4 хувь) хүүний өгөөжтэй болно. Энэ хөрөнгө оруулалтуудыг 1-р шатлалын гэж үзсэн. Барьцаагүй болно. Тодруулга 39-ийг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хятадын засгийн газрын бонд. Банк нь 2018 оны 1-р улиралд Хятадын ардын банкнаас гаргасан юанийн Хятадын засгийн газрын бондод хөрөнгө оруулалт хийсэн. 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх уг хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 291 сая юань буюу 112,383 сая төгрөг байна. Уг бондын хугацаа 1-ээс 3 жил ба жилийн 1.43-аас 3.68 хувийн хүүний өгөөжтэй. Энэ хөрөнгө оруулалтуудыг 1-р шатлалын гэж үзсэн. Барьцаагүй болно. Тодруулга 39-ийг харна уу.

“Рамп” Хөрөнгө оруулалтын данс. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь Дэлхийн банкны “Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлага” төслийг 2011 оноос хэрэгжүүлсэн.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 0.3 сая ам.доллар буюу 770 сая төгрөг (2017 онд 0,3 сая ам.доллар буюу 786 сая төгрөг) бүхий мөнгөн хөрөнгө, 335 сая ам.доллар буюу 814,053 сая төгрөг (2017 онд 102 сая ам.доллар буюу 248,086 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Хөрөнгө оруулалтын данс дахь үнэт цаасны ихэнхи хувийг АНУ-ын Засгийн газрын бонд болон бусад орны Засгийн газрын байгууллагаас гаргасан үнэт цаас бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Мүүдийс болон Фичийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй байсан. Тодруулга 39-г үзнэ үү.

(б) Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас нь 1-р шатлалд орох ба зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан үзүүлэлт нь “сайн” байна. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийн аргын тайлбарын талаар Тодруулга 39-өөс үзнэ үү.

МИК ОССК ХХК-ийн охин компаниудын гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд (Давуу эрхтэй ИЗББ) Банк нь 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдөр МИК ОССК ХХК болон дотоодын банкуудтай “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан. 2016 оноос эхлэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба Монгол Улсын засгийн газар гэрээнд оролцогч тал болсон. Уг гэрээний хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон бага хүүтэй зээлийн төлбөрт МИК Актив ТЗК-иас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авсан, энэ талаар Тодруулга 9-өөс харна уу. Тус бонд нь 20 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй.

Хөгжлийн банкны үнэт цаас. Үнэт цаасны нийт нэрлэсэн үнэ 60,000 сая төгрөг бөгөөд 6 жилийн хугацаатай, 4 хувийн купонтой (2017 онд 60,000 сая төгрөг, 6 жилийн хугацаатай, 4 хувийн хүүтэй). Хүүгийн төлбөр нь хагас жил тутамд төлөгдөх нөхцөлтэй. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дансны үнэ нь 44,305 сая төгрөг (2017: 39,860 сая төгрөг) байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11. ӨМЧИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2018 оны 1 дүгэр сарын 1-нд Банк өмчийн үнэт цаасны бүх хөрөнгө оруулалтуудаа бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэх өмчийн үнэт цаас гэж тодорхойлсон. 2017 онд эдгээр хөрөнгө оруулалтууд нь борлуулахад бэлэн хөрөнгө гэж ангилагдсан байсан. Тодруулга 12-ыг харна уу.

Доорх хүснэгтэд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг харуулав:

Сая төгрөгөөр	Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэх өмчийн үнэт цаас	Нийт
МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт	5,139	5,139
Бусад өмчийн хөрөнгө оруулалт	6,595	6,595
2018.12.31 байдлаар нийт өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	11,734	11,734

МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт. Банк МИК Холдинг ХК-ийн 421,241 ширхэг энгийн хувьцааг (нийт хувьцааны 2.03 хувь) эзэмшдэг бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ 5,139 сая төгрөг (2017 онд 421,241 хувьцаа 5,139 сая төгрөгийн бодит үнэтэй) байв.

Бусад өмчийн хөрөнгө оруулалт. Үүнд Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны ОУ-ын банк болон Монголын банкны холбоонд оруулсан хөрөнгө оруулалтууд багтана.

12. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ – БОРЛУУЛАХАД БЭЛЭН

Сая төгрөгөөр	2017 оны 12 дугаар сарын 31
Борлуулахад бэлэн өрийн үнэт цаас:	
ОУ-ын Төлбөр Тооцооны банкны ам.долларын бонд	314,953
АНУ-ын Засгийн газрын үнэт цаас	247,591
Рамп Хөрөнгө оруулалтын данс	248,872
Давуу эрхтэй ИЗББ	2,103,252
Хөгжлийн банкны үнэт цаас	39,860
Борлуулахад бэлэн өмчийн үнэт цаас:	
МИК ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт, бодит үнэ цэнээр	5,139
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	6,595
Нийт борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	2,966,262

Борлуулахад бэлэн өрийн хэрэсэл нь үнэ цэний бууралтгүй, хугацаа хэтрээгүй бөгөөд барьцаагүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк	2,141,558	2,849,451
Дотоодын банкууд – Төгрөгөөр	322,054	234,536
Хорогдуулсан өртгөөрх нийт буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний дүн	2,463,612	3,083,987

Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжийн хувьд Банк нь “Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 250,000 ам.доллараас давсан дүнгээр Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээ (буцаан худалдан авах репо)-ний дагуу хөрөнгө оруулалт хийгддэг.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 810 сая ам.доллар буюу 2,141,558 сая төгрөг (2017: 1,174 сая ам.доллар буюу 2,849,451 сая төгрөг) байна. Энэхүү хөрөнгө оруулалт 3 хоногийн (2017: 4 хоног) хугацаатай бөгөөд жилийн 2.43 хувийн (2016: 1.46 хувь) хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалтыг байнга барьцаагаар баталгаажуулдаг боловч тус хөтөлбөрийн дагуу үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийснийг тодорхойлох нь хүндрэл бэрхшээлтэй байна.

2018 оны 12 дугаар сарын 31 ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар буцаан худалдан авах репо гэрээ нь 1-р шатлалд орох ба зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан “онц сайн” гэж үнэлэгдсэн байна. Тодруулга 39-ийг үзнэ үү.

Дотоодын банкууд. Дотоодын банкуудтай байгуулсан “Төгрөгийн” буцаан худалдан авах гэрээнүүд нь Хөгжлийн банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цааснуудаар баталгаажсан урт болон богино хугацаат зээлийг илэрхийлдэг.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банкууд дахь төгрөгийн овернайт буцаан худалдан авах хэлцлийн дүн 254,651 сая төгрөг, 4 хоногийн хугацаатай, жилийн 13 хувийн хүүтэй (2017: 74,679 сая төгрөг, 5 хоногийн хугацаатай, жилийн 13 хувийн хүүтэй) байсан. Энэ гэрээ нь засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан.

Төгрөгийн буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээ нь дотоодын банкуудтай хийсэн урт хугацаат гэрээг илэрхийлнэ. Эдгээр нь 75,145 сая төгрөгийн дүнтэй, (2017: 173,425 сая төгрөг) 3-6 жилийн хугацаатай (2017: 3-6 жил) жилийн 7.5 хувийн хүүтэй (2017: жилийн 7.5 хувийн хүүтэй) Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаасаар баталгаажсан. Бодит үнэ цэнийн хувьд анх хүлээн зөвшөөрөх үед 150,000 сая төгрөг байсан.

Бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 23,426 сая төгрөг 2016 оны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн. 2016 онд дотоодын банкуудтай хийсэн урвуу буцаан худалдан авах хэлцлийг анх хүлээн зөвшөөрөхөд үүссэн алдагдлын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс үзнэ үү. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар уг хэлцлүүдийн дансны үнэ 67,403 сая төгрөг (2017: 159,857 сая төгрөг) байсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын үнэлэмжийн талаар Тодруулга 3 болон 4-өөс үзнэ үү. 2018 оны 12 дугаар сарын 31 ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эдгээр үлдэгдэл нь 1-р шатлалд орох ба зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан “сайн” гэж үнэлэгдсэн байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

14. АЛТ БА ҮНЭТ МЕТАЛ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Үнэлгээгээр		
Алт	2,033,388	429,440
Мөнгө	2,362	-
Өртгөөр		
Алт олборлогчдоос худалдан авсан алт,мөнгө	143,244	103,070
Замд яваа цэвэршүүлэхээр ачуулсан алт	5,030	5,450
Дурсгалын зоос	1,633	988
Нийт алт ба үнэт метал	2,185,657	538,948

Мөнгөжсөн алт нь Английн Төв банк болон Скотиа Мокатта банкинд байршдаг. Мөн дотоодын олборлогчдоос худалдан авсан, цэвэршүүлэхээс өмнөх мөнгөжөөгүй алтыг хадгалдаг болно.

Бусад үнэт метал болох дурсгалын зоосыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

15. ЭРДЭНЭСИЙН САН

Сая төгрөгөөр	Зоос	Соёлын үнэт зүйлс	Нийт
2018 оны 1 дүгээр сарын 1 байдлаар дансны үнэ	2,938	2,321	5,259
Нэмэгдсэн	10	1,243	1,253
Дахин үнэлсэн	835,691	89,038	924,729
2018 оны 12 дугаар сарын 31 байдлаар дансны үнэ	838,639	92,602	931,241

Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болон өв уламжлагдсан үнэт зүйлс мөн 1925 онд гаргасан мөнгөн зоос зэргээс бүрдэнэ. Эдгээр зүйлсийг музейд олон нийтэд үзүүлдэг бөгөөд Санг Улсын Эрдэнэсийн сангийн хуулийн дагуу Банк нь хянадаг учир музейн тасалбараас олсон орлогыг Банк хүлээн зөвшөөрдөг. Эрдэнэсийн сангийн эдийн засгийн үр өгөөж нь Банкинд орж байгаа учир санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. 1938 онд зооснуудыг гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудыг Монголбанкны өмнөх буюу түүнд эрхээ шилжүүлсэн банк гаргасан боловч засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж удирдлага үзэж байгаа учраас хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзэж байна.

Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа зоос болон соёлын үнэт зүйлсийг Алт ба Үнэт метал хэсэгт анх бүртгэхдээ бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэсэн. 2018 оноос эхлэн удирдлага НББОУС 16-ын дагуу дахин үнэлгээний загварыг ашигласан бөгөөд хөндлөнгийн үнэлгээний компани болох “Мэйк Диффэрэнс” ХХК-аар олон улсын үнэлгээний стандартын дагуу эрдэнэсийн сангийн эд зүйлсийг дахин үнэлүүлсэн. Эрдэнэсийн сан дахь эд зүйлсийг шууд харьцуулалтын арга болон өртгийн аргаар үнэлсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. ЭРДЭНЭСИЙН САН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Шууд харьцуулалтын арга нь гарал үүсэл, нөхцөл байдал, бэлэг тэмдгийн нэр, одоогийн эзэмшигч, тухайн зүйлийн онцгой байдал зэрэг тодорхой зах зээлийн хүчин зүйлсэд тохируулсан харьцуулж болох үнийг ашиглан олон нийтийн болон онлайн дуудлага худалдаа зэрэг зах зээлд тулгуурласан нотолгоог суурь болгон ашигладаг арга юм. Өртгийн арга нь анхны эд зүйлийн шинж, чанар, материалын насжилттай аль болох ойролцоо ижил чанар, ашиглалт, таваарлаг чанартай хөрөнгийг дахин үйлдвэрлэх өнөөгийн өртгийг тооцоолоход үндэслэсэн үнийг гаргадаг арга юм. Зах зээлд тогтмол ажиглагддаг мэдээлэлд үндэслээгүй таамаглалыг ашиглаж үнэлсэн эд зүйлсийн бодит үнэ цэнийн талаар мэдээллийг Тодруулга 40-өөс харна уу.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эрдэнэсийн сангийн үлдэгдэл 931,241 сая төгрөг бөгөөд дахин үнэлгээний нэмэгдэл нь 924,729 сая төгрөг байна. Дахин үнэлгээний нэмэгдэл нь хамгийн том 20 түүх дурсгалын үнэт зүйлсийн дахин үнэлгээ болон 1925 оны Монгол зоосны дахин үнэлгээнээс бүрдэх бөгөөд тус тус 69,534 сая төгрөг болон 827,886 сая төгрөг байна. Үлдсэн хэсэг нь бусад зоос болон соёлын үнэт зүйлстэй холбоотой. Тодруулга 26-аас харна уу.

Хамгийн том 20 түүхэн үнэт зүйлсийг дахин үнэлэхэд тодорхой залруулгуудыг хийх бөгөөд хэрэв үнийн дүнгийн залруулгын нөлөө 30 хувиас их бол томоохон залруулга гэж үзнэ. Хэрэв томоохон залруулга нь үнэлгээний тайланд авч үзсэн залруулгатай харьцуулахад 20 хувиар их эсвэл бага бол Эрдэнэсийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний дансны үнэ 720 сая төгрөгөөр ихэсэх эсвэл багасах байсан.

Зоосийг дахин үнэлэхэд тодорхой залруулгуудыг хийх бөгөөд хэрэв үнийн дүнгийн залруулгын нөлөө 25 хувиас их бол томоохон залруулга гэж үзнэ. Хэрэв томоохон залруулга нь зоосны үнэлгээний тайланд авч үзсэн залруулгатай харьцуулахад 20 хувиар их эсвэл бага бол Эрдэнэсийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний дансны үнэ 36,164 сая төгрөгөөр ихэсэх эсвэл багасах байсан.

16. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл нь дотоод болон гадаадын банкуудтай байгуулсан гадаад валютын своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг илэрхийлдэг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь зах зээлийн хүүгийн хэлбэлзэл, гадаад валютын ханш болон бусад хувьсагчуудаас шалтгаалан тааламжтай (хөрөнгө), тааламжтай бус (өр төлбөр) нөхцөл байдалтай байдаг. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хэрэгслүүд нь нийт дүнгээрээ байнга мэдэгдэхүйц хэмжээгээр хэлбэлзэж байдаг.

Доорх хүснэгт нь хөрөнгө өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг харуулж байна:

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Гадаад валютын форвард ба своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ		
- Санхүүгийн хөрөнгийн орлого зарлагаарх бодит үнэ цэнэ	199,657	55,732
- Санхүүгийн өр төлбөрийн орлого зарлагаарх бодит үнэ цэнэ	(368,710)	(311,472)
Санхүүгийн хөрөнгийн орлого зарлагаарх цэвэр бодит үнэ цэнэ	(169,053)	(255,740)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь тайлант хугацааны эцсээрх Банкны гадаад валютын форвард ба своп хэлцлийн авлага, өглөгийн бодит үнэ цэнийг харуулж байна. Хүснэгтэд харилцагч талын позици (ба төлбөр)-тэй цэвэршүүлээгүй бохир позицыг харуулсан бөгөөд холбогдох тайлант хугацааны хойших цаг хугацаанд хийгдэх төлбөр тооцоо бүхий хэлцлүүдийг мөн багтаасан болно.

	2018		2017	
	Эерэг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд	Сөрөг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд	Эерэг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд	Сөрөг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд
<i>Сая төгрөгөөр</i>				
Гадаад валютын своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ				
- Ам.долларын өглөг (-)	(399,111)	(2,074,205)	(377,603)	(1,961,774)
- Төгрөгийн авлага (+)	598,768	1,705,495	433,335	1,650,302
Гадаад валютын свопын цэвэр бодит үнэ цэнэ	199,657	(368,710)	55,732	(311,472)

17. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
<i>Сая төгрөгөөр</i>		
Засгийн газрын үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	65,265	163,027
Хасах нь алдагдлын сан	(934)	-
Засгийн газрын нийт үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	64,331	163,027

Зах зээлийн хүүтэй Засгийн газрын үнэт цаас. Банк Засгийн газрын үнэт цаасыг урамшуулалтай, хямдруулалттай, эсвэл нэрлэсэн үнээр анхдагч болон хоёрдогч зах зээлээс худалдан авдаг. 2018 болон 2017 онуудад шинээр засгийн газрын үнэт цаас худалдан аваагүй байна. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэрлэсэн үнэ нь 101,800 сая төгрөг бөгөөд жилийн 9.6-10.3 (2017: 9.6-10.3) хувийн хүүтэй, 2-4 жилийн (2016: 2-4 жил) хугацаатай үнэт цааснуудыг бүгдийг төлсөн байна.

Зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур хүүтэй Засгийн газрын үнэт цаас. Банк Засгийн газрын хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрийн дагуу 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0-3.0 хувийн хүүтэй, 1-15 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнэ анх хүлээн зөвшөөрөх үед 123,668 сая төгрөг байсан. Бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 330,044 сая төгрөгийг 2016 оны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Сайн” хөтөлбөртэй холбоотой үнэ цаасны дансны үнэ 65,265 сая төгрөг (2017: 60,112 сая төгрөг) байсан. Үүнтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хийсэн үнэлэмж болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3 болон 4-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ҮРГЭЛЖЛЭЛ)

Засгийн газрын үнэ цаасны нэрлэсэн үнэ нь 2016 онд 100,000 сая төгрөг байсан бөгөөд жилийн 14 хувь байсан. Энэ нь зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур байсан. Тухайн үнэт цаасны анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 95,349 сая төгрөг байсан бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь “нэг дэх өдрийн хувьд” 4,651 сая төгрөг байсан бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. Засгийн газрын үнэт цаасыг 2017 онд борлуулсан бөгөөд 2,754 сая төгрөгийн засгийн газрын үнэт цаас борлуулсны олзыг 2017 оны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн. Эдгээр үнэт цааснууд хорогдуулсан өртгөөр хэмжигддэг.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн эрсдэлийн хамгийн өндөр магадлалтай үлдэгдэл нь 1-р шатлалд орох ба зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан үзүүлэлт нь “сайн” байна. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийн аргын тайлбарын талаар Тодруулга 39-өөс үзнэ үү.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэт цаасны үлдэгдлүүд нь хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй бөгөөд барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй. Холбоотой талын талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 38-аас харна уу.

18. БУСАД ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Бусад санхүүгийн хөрөнгө		
Өрийн бичгийн авлага	-	703,623
Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага	193,710	193,709
Татан буугдсан Анод банкнаас хүлээн авсан хөрөнгө	60,615	62,798
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага	56,352	52,163
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	23,106	21,219
Торгуулийн авлага	3,353	-
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	(255,851)	(342,570)
Бусад санхүүгийн бус хөрөнгө, хорогдуулсан өртгөөр		
Урьдчилж төлсөн зардал	856	1,036
Бусад	9,993	3,211
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	-	(286)
Нийт бусад хөрөнгө , хорогдуулсан өртгөөр	92,134	694,903
Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх бусад хөрөнгө		
Өрийн бичгийн авлага	748,656	-
Орлого зарлагаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх нийт бусад хөрөнгө	748,656	-
Нийт бусад хөрөнгө	840,790	694,903

Өрийн бичгийн авлага нь дотоодын компаниудаас гаргасан доорх өрийн бичгүүдийг илэрхийлэх бөгөөд үүнд:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 742,500 сая төгрөгийн (2017: 802,500 сая төгрөг) нэрлэсэн үнэтэй дотоодын таван (5) компанийн болон дотоодын нэг банкны гаргасан өрийн бичгүүдийг эзэмшиж байна. Эдгээр өрийн бичгүүд нь 5-6 жилийн хугацаатай бөгөөд гэрээгээр тодорхойлж заасан хүүгийн түвшинтэй болно. Өрийн бичгийн гэрээнүүд нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд хүүгийн түвшин буурах нөхцөлтэйгээр баталгаажсан, тухайлбал эдгээр гэрээнүүд анхны хүүгийн түвшин өндөр байхаар заасан боловч тодорхой нөхцөл байдал хангагдсан тохиолдолд зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доогуур түвшин хүртэл бууруулах боломжтой. Банкны удирдлага болон хуулийн газар эдгээр гүйлгээг Төв банкны болон Монгол Улсын бусад холбогдох хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаа болно.

СТОУС 9-рүү шилжсэнтэй холбоотойгоор өрийн бичгийн авлагын ангилал болон хэмжилт нь хүүгийн түвшинг бууруулах нөхцөл нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, зээлийн эрсдэл зэргийг нөхөх ямар нэг хамааралгүй тодорхой нэг үйл ажиллагааны үүрэг хариуцлагатай хамааралтай байсан учир ЗХҮТ шалгуурын дагуу хорогдуулсан өртгийн ангиллаас орлого зарлагаарх бодит үнэ цэнийн ангилал руу шилжсэн. Дахин ангиллын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 4 болон 5-аас харна уу. Тодруулга 4-т толилуулсны дагуу бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн урсгалын аргаар тооцоолно. Хорогдуулсан өртгийн аргаас орлого зарлагаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн дахин ангилалын олз, гарзын зөрүүг Тодруулга 34-т толилуулсан.

Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага ХДК-аас авах авлага нь 119,900 сая төгрөгийн зээл болон 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээс бүрдэнэ. 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг нь “Төрийн банк” ХХК-ийн хувьчлалын орлогоос 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан. Гэвч “Төрийн банк” ХХК нь хувьчлагдаагүй бөгөөд санхүүгийн дэмжлэг нь төлөгдөөгүй байна. ХДК-д олгосон 119,900 сая төгрөгийн зээл нь Монгол Улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор олгогдсон. Гэрээний холбогдох заалтын дагуу 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр эргэн төлөгдөнө. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийг НББОУС 39-ийн дагуу үнэлж Төрийн банкны хувьчлал зогсонги байдалд орсны улмаас эргэн төлөлт хийгдэх эсэх нь тодорхойгүй гэж дүгнэн бүхэлд нь эрсдэлийн сан байгуулсан (Тодруулга 4).

2018 оны 5 дугаар сарын засгийн газрын хуралдаанаар Төрийн банкны хувьчлалын талаар авч хэлэлцсэн. Удирдлагын үнэлэлтийг Тодруулга 4-өөс харна уу. Хувьчлалтай холбоотой ахиц гарсны үндсэн дээр дахин үнэлгээ хийснээр зээлийг 115,000 сая төгрөгийн эрсдэлийн нөөц сангийн хамт 3-р шатлалаар үнэлж үр дүнд нь 78,700 сая төгрөгийн эрсдэлийн нөөц сангийн буцаалтыг орлого зарлагаар хүлээн зөвшөөрсөн.

Татан буугдсан Анод банкнаас авах авлага 2015 онд Анод банкны эрх хүлээн авагчийн хугацаа дуусах үед Банк 73,662 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан. Үүнээс 2018 болон 2017 онд харгалзан 2,183 сая болон 3,632 сая төгрөгийг эргүүлэн төлүүлсэн. Эдгээр хөрөнгүүдийн хувьд 60,615 сая төгрөгийн (2017 онд 62,798 сая төгрөг) алдагдлын санг өмнөх онтой адил 100 хувь байгуулсан. СТОУС 9-ийн дагуу хөрөнгийг 3-р шатлалаар үнэлж дефолт болох магадлал болон дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь 100% байна.

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг өмнөх жилүүдэд биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах авлага багтаж байгаа бөгөөд. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 37,179 сая төгрөг (2017 онд 34,143 сая төгрөг)-ийн авлагын дүнд найдваргүй байдлыг тооцон болзошгүй алдагдлын нөөцийн санг бүрэн байгуулсан бөгөөд 3-р шатлалаар үнэлж дефолт болох магадлал болон дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь 100% байна..

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад аж ахуйн нэгжүүдээс авах авлагын хувьд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 19,173 сая төгрөг (2017 онд 18,020 сая төгрөг) байна. Өмнөх онуудад авлагыг бүхэлд нь нөөц сан байгуулсан бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3-р шатлалаар авч үзнэж дефолт болох магадлал болон дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь 100% байна.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарга. Холбогдох гадаадын байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон учир эргэн төлөгдөхгүй гэж үзэн 2017 оын 12 дугаар сарын 31-ний байдлаар бүтэн дүнгээр болзошгүй алдагдлын нөөцийн санг байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк эдгээр хөрөнгийг 3-р шатлалаар үнэлсэн, дефолт болох магадлал болон дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь 100% байна.

Бусад санхүүгийн бус хөрөнгө Бусад санхүүгийн бус хөрөнгүүд нь ихэвчлэн эргэн төлөлтүүд, ажилтнуудад олгосон урьдчилгаа, хангамжийн материал, бичиг хэргийн материал болон борлуулахад бэлэн хөрөнгүүдээс бүрдэнэ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар АХБ-аас авах авлага 3,955 сая төгрөг, төслийн хөрөнгө оруулалтын дүн 5,045 сая төгрөг байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Болзошгүй алдагдлын нөөцийн сан. 2018 оны турш хийгдсэн бусад хөрөнгүүдийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	1-р шатлал (12-сарын ХЗА)		3-р шатлал (зээлийн үнэ цэнэ буурахад ХЗА-ийн туршид)				Нийт
	Бусад санхүүгийн хөрөнгө	Нийт	ХДК- аас авах авлага	Анод банкнаас авах авлага	Бусад ААН- үүдээс авах авлага	Гадаадын санхүү-гийн байгуул-лагаас авах авлага	
2018.01.01-нээрх нийт дансны дүн	-	-	193,709	62,798	52,163	21,219	329,889
Нэмэгдсэн (Хуримтлагдсан хүү)	3,353	3,353	1	-	-	-	1
Ханшийн тэгшитгэл	-	-	-	-	4,189	1,887	6,076
Тухайн жилийн эргэн төлөлт	-	-	-	(2,183)	-	-	(2,183)
2018.12.31-нээрх нийт дансны дүн	3,353	3,353	193,710	60,615	56,352	23,106	333,783
2018.01.01-нээрх алдагдлын сан	-	-	193,700	62,798	52,163	21,219	329,880
Гадаад валютаарх болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөрвүүлэлт	203	203	-	-	4,189	1,887	6,076
Тайлант хугацаанд байгуулсан болзошгүй алдагдлын нөөцийн сан	575	575	-	-	-	-	-
Тайлант хугацааны болзошгүй алдагдлын нөөцийн сангийн буцаалт	-	-	(78,700)	(2,183)	-	-	(80,883)
2018.12.31-нээрх болзошгүй алдагдлын нөөцийн сан	778	778	115,000	60,615	56,352	23,106	255,073

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2017 оны турш хийгдсэн бусад хөрөнгүүдийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

	Өрийн бичиг	ХДК- аас авах авлага	Анод банкаас авах авлага	Бусад ААН- үүдээс авах авлага	Гадаадын санхүү-гийн байгуул-лагаас авах авлага	Урьд- чилгаа төлбөр	Бусад	Нийт
<i>Сая төгрөгөөр</i>								
2017.01.01-нээрх үнэ цэнийн бууралтын нөөц	5,944	199,200	66,430	53,374	21,784	77	210	347,019
Гадаад валютаарх болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөрвүүлэлт	-	-	-	(1,211)	(545)	(2)	-	(1,758)
Тайлант хугацаанд байгуулсан болзошгүй алдагдлын нөөцийн сан	6,726	-	-	-	-	-	3	6,729
Тайлант хугацааны болзошгүй алдагдлын нөөцийн сангийн буцаалт	-	(5,500)	(3,632)	-	-	-	(2)	(9,134)
Дахин ангилал	20	-	-	-	(20)	19	(19)	-
2017.12.31-нээрх болзошгүй алдагдлын нөөцийн сан	12,690	193,700	62,798	52,163	21,219	94	192	342,856

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	Барилга байгууламж	Дуусаагүй барилга	Тавилга, компьютер төхөөрөмж	Нийт биет хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт
2017.01.01-ний өдрийн байдлаар өртөг	47,545	82	9,630	57,257	2,166	59,423
Хуримтлагдсан элэгдэл/ хорогдол	(24,950)	-	(4,472)	(29,422)	(1,967)	(31,389)
2017.01.01-нээрх дансны үнэ	22,595	82	5,158	27,835	199	28,034
Нэмэгдсэн	4,104	1,263	3,913	9,280	15	9,295
Хасагдсан-өртгөөр	(384)	-	(1,233)	(1,617)	(1,695)	(3,312)
Акталсан-өртгөөр	(7)	-	(72)	(79)	-	(79)
Элэгдэл/хорогдол	(903)	-	(1,646)	(2,549)	(75)	(2,624)
Хасагдсан-хуримтлагдсан элэгдлээс	335	-	1,228	1,563	1,695	3,258
Акталсан- Хуримтлагдсан элэгдлээс	7	-	56	63	-	63
2017.12.31-ний байдлаар өртөг эсвэл үнэлгээ	51,258	1,345	12,238	64,841	486	65,327
Хуримтлагдсан элэгдэл/ хорогдол	(25,511)	-	(4,834)	(30,345)	(347)	(30,692)
2017.12.31-нээрх дансны үнэ	25,747	1,345	7,404	34,496	139	34,635
Нэмэгдсэн	9,145	13,651	2,632	25,428	10	25,438
Хасагдсан-өртгөөр	(1,139)	-	(1,251)	(2,390)	-	(2,390)
Дахин үнэлсэн	35,159	-	-	35,159	-	35,159
Акталсан-өртгөөр	-	-	(10)	(10)	-	(10)
Элэгдэл/хорогдол	(925)	-	(2,075)	(3,000)	(77)	(3,077)
Хасагдсан-хуримтлагдсан элэгдлээс	576	-	1,248	1,824	-	1,824
Дахин үнэлсэн-хуримтлагдсан элэгдлээс	(17,134)	-	-	(17,134)	-	(17,134)
Акталсан- Хуримтлагдсан элэгдлээс	-	-	6	6	-	6
2018.12.31-нээрх өртөг	94,423	14,996	13,609	123,028	496	123,524
Хуримтлагдсан элэгдэл	(42,994)	-	(5,655)	(48,649)	(424)	(49,073)
2018.12.31-нээрх дансны үнэ	51,429	14,996	7,954	74,379	72	74,451

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк барилга, байгууламжаа 2018 оны 12 дугаар сарын 31-нд бодит үнэ цэнээр дахин үнэлүүлсэн. Үнэлгээг нэр хүндтэй, мэргэжлийн ур чадвартай “Гроут Финанс Аудит” ХХК-аар хийлгэсэн бөгөөд ижил байршилд ижил ангиллын хөрөнгийг үнэлсэн ойрын үеийн туршлагатай байсан. Үнэлгээнд ашигласан үнэлгээний суурь нь зах зээлийн үнэ, орлуулалтын өртөг, хямдруулсан мөнгөн урсгалын арга байсан. Бодит үнэ цэнийг тохирсон үнэлгээний аргаар тооцоолсон ба дараах таамаглалуудыг ашигласан: Ихэнх барилга, байгууламжийн хувьд гол зах зээл дээр харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байсан учир зах зээлийн арга илүү тохиромжтой байсан.

Хөдөөгийн хоёр салбарын хувьд тухайн байршилд ижил төрлийн болон харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байгаагүй бөгөөд байгаа мэдээлэл нь их зөрүүтэй байсан учир өртгийн арга болон орлогын аргыг ашигласан. Ихэнх барилга, байгууламжийн хувьд зах зээл дээр харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байсан учир зах зээлийн арга тохиромжтой байсан.

2018 оны дуусаагүй барилгын 13,651 сая төгрөгийн нэмэгдэл нь (2017: 1,263 сая төгрөг) баригдаж байгаа төв оффис болон салбарын барилгын ажилтай холбоотой.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгийг өртгөөс хасах нь элэгдэл гэж бүртгэсэн бол барилга байгууламжийн дансны дүн нь 13,098 сая төгрөг (2017: 13,852 сая төгрөг) байх байсан. Барилга, байгууламжийн дансны үнийг доор харуулав:

<i>Сая төгрөгөөр</i>	2018	2017
Санхүүгийн байдлын тайланд барилга, байгууламжийн дахин үнэлэгдсэн дүн	43,429	25,747
Өмчийн тайлан дахь дахин үнэлгээний нөөц	(30,331)	(11,895)
Барилга, байгууламжийн өртгөөс хасах нь хуримтлагдсан элэгдлийн дүн	13,098	13,852

Хэрэв одоогийн дансны өртөгт ашигласан үнэтэй харьцуулахад дундаж үнэ 20 хувиар их бол барилгын дансны үнэ болон бусад нөөц дэх дахин үнэлгээний нөөц 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ойролцоогоор 10,286 сая төгрөгөөр (2017: 5,149 сая төгрөг) нэмэгдэнэ. Хэрэв одоогийн дансны өртөгт ашигласан үнэтэй харьцуулахад дундаж үнэ 20 хувиар бага бол Банкны барилгын дахин үнэлгээний нөөц 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ойролцоогоор 10,286 сая төгрөгөөр (2017: 5,149 сая төгрөг) буурна. Удирдлага зах зээлийн өнөөгийн нөхцөлд Банкны барилга байгууламжийн ерөнхий үнэ цэнэ буурах бараг боломжгүй бөгөөд барилга, байгууламжийн үнийн боломжит өсөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөө нь санхүүгийн тайлан хэрэглэгчийн хувьд материаллаг нөлөө байхгүй гэж итгэж байна.

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө байхгүй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	1,094,566	972,295
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(125,968)	(65,919)
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	20	20
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	968,618	906,396

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө:

Сая төгрөгөөр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	972,295	2,398,749	(2,276,478)	1,094,566
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(65,919)	(2,333,671)	2,273,622	(125,968)
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	20	3	(3)	20
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	906,396	65,081	(2,859)	968,618

21. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Сая төгрөгөөр	2017 оны 12 дугаар сарын 31	2016 оны 12 дугаар сарын 31
Төв банкны үнэт цаас	5,005,515	3,444,401
Нийт Төв банкны үнэт цаас	5,005,515	3,444,401

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаасыг илэрхийлнэ. Эдгээр үнэт цаасны дуусах хугацаа нь 7-184 хоног (2017 онд 7-8 хоног) бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 11-ээс 12 хувийн (2017 онд жилийн 11 хувь) хүүтэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Сангийн яамны харилцах данс	504,923	1,553,069
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр:		
- Олон Улсын Валютын Сан (ӨСХ)	578,771	288,976
- Германы Засгийн газар (КФВ)	17,017	17,103
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	23,169	15,223
- Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)	6,227	6,293
Төрийн Байгууллагуудад төлөх Нийт Өр Төлбөр	1,130,107	1,880,664

Сангийн яамны харилцах дансууд. Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны харилцах дансууд юм. Эдгээр дансууд нь хугацаагүй бөгөөд хүү тооцдоггүй бөгөөд харин 2018 оноос нэг данс жилийн 4.16 хувийн (2017: хүүгүй) хүүтэй байна.

Олон улсын байгууллагуудаас авсан зээллэгтэй холбоотойгоор Сангийн яаманд төлөх өр төлбөр. Эдгээр нь Монгол Улсын Засгийн газар Олон Улсын Валютын Сан (ОУВС), “КФВ” (Герман Улсын Засгийн газрыг төлөөлж), Азийн Хөгжлийн Банктай (АХБ) болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-тай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол Улсын Сангийн яам санхүүгийн зуучлагчаар, Банк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС). 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ нь ОУВС-гаас Монгол улсад ӨСХ-ийн хүрээнд олгосон жилийн 1.53-аас 1.59 хувийн хүүтэй зээл юм.

Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-нд Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Банк руу шилжүүлсэн. Эдгээр зээл нь Сангийн яамны өр төлбөр болно. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагч болохын хувьд ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотой өрийн бичгийг гаргасан бөгөөд дээрх зээлийн эргэн төлөлтийг ОУВС-гийн өмнө хүлээнэ. Зээл болон түүний эргэн төлөлт нь Зээлжих Тусгай Эрх (“ЗТЭ”)-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг хийнэ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд өгөх өр төлбөрийн хэмжээ гурван жилийн хугацаатай 158 сая ЗТЭ буюу 578,771 сая төгрөг (2017: 84.0 сая ЗТЭ буюу 288,976 сая төгрөг) байсан.

КФВ-аас авсан зээл нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой 1995 он болон 2003 оны хөтөлбөрийн дагуу олгогдсон. Эдгээр зээлүүд нь еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүүтэй, тус тус 30-аас 40 жилийн хугацаатай. Зээлийн үндсэн төлөлт 2005 оноос эхэлсэн ба 2012 оноос эхлэн хоёр дахь хөтөлбөрийн үндсэн төлбөр төлөгдөж эхэлсэн.

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээл нь жилийн 1 болон 2.5 хувийн хүүтэй, 17- оос 27 жилийн хугацаатай байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сангийн яам нь Засгийн газрыг төлөөлөн хэрэгжүүлэгч агентын үүрэг гүйцэтгэдэг учир Банк ОУВС, КФВ болон АХБ-ны төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь ОУВС, КФВ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна.

Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас ОУВС, КФВ болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, ОУВС, КФВ, АХБ болон Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгогдсон зээлийн дэлгэрэнгүйг Тодруулга 9-өөс харна уу. Эдгээр өр төлбөрүүдтэй холбоотой удирдлагын үнэлэмжийг Тодруулга 4-өөс харна уу.

Олон улсын хөгжлийн ассоциациас Монгол улсыг төлөөлж Сангийн яамны авсан зээл нь хувийн хэвшлийг дэмжих төсөл болон санхүүгийн чадавхыг дээшлүүлэх төслүүдэд зориулагдсан бөгөөд Сангийн яамнаас жилийн 1-3 хувийн хүүтэй, 14-өөс 15 жилийн хугацаатай зээлүүд болно.

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тусгай нөхцөлийн (ковенант) зөрчил байхгүй болно.

23. ДОТООДЫН БАНКУУДЫН ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Харилцах дансууд:		
- төгрөгөөр	1,453,953	1,496,262
- валютаар	2,487,064	1,561,493
Төгрөгийн овернайт хадгаламж	274,568	58,543
Нийт дотоодын банкуудын хадгаламж	4,215,585	3,116,298

Холбогдох дансууд нь дотоодын банкуудаас Банкинд зайлшгүй байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжуудаас бүрдэх бөгөөд тэдгээрийн хадгаламж эзэмшигчиддээ төлөх өр төлбөрийн тодорхой хувиар тооцогддог.

2018 оны 12 дугаар сарын 31-нээрх төгрөгийн овернайт хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 9 хувийн хүүтэй 2 хоногийн хугацаатай (2017: 9 хувийн хүүтэй 5 хоногийн хугацаатай) хадгаламж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24. ГАДААД ӨР ТӨЛБӨР

<i>Сая төгрөгөөр</i>	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ХАБ-тай байгуулсан хэлэлцээр	4,727,193	4,569,233
ОУВС-гийн ЗТЭ-ийн хуваарилалт	178,685	167,797
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	166	152
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	39	39
Дэлхийн банкны харилцах данс	43	723
АХБ-ны харилцах данс	4	8
Нийт гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	4,906,130	4,737,952

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцэл. Энэхүү данс нь Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан 7-оос 8 сарын (2017: 5-аас 8 сарын) хугацаатай юанийн санхүүжилт бөгөөд Банк дотоодын банкуудыг юаниар санхүүжүүлэхэд ашигладаг. Хүү нь Шанхай-Интер банкны санал болгосон хүүгийн түвшин дээр 200 суурь нэгж нэмсэнтэй тэнцүү. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 37-оос харна уу.

Зээлжих тусгай эрхийн хуваарилалт (цаашид “ЗТЭ” гэх) ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Банкны ОУВС-д өгөх өр төлбөрийг илэрхийлэх ба Тодруулга 8-д энэ талаар тодруулсан. Хуваарилалтын цэвэр хуримтлал нь 178,685 сая төгрөг буюу 48,757 сая ЗТЭ (2017: 167,797 сая төгрөг буюу 48,757 сая ЗТЭ)-тэй тэнцүү байна.

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25. БУСАД ӨР ТӨЛБӨР

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Бусад санхүүгийн өр төлбөр		
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө	98,913	29,978
Бусад өглөг	15,853	11,969
Бусад өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	1,929	3,185
Нийт бусад өр төлбөр	116,695	45,132

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж. Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь Үнэт цаасны төлбөр тооцооны төв, Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах дансуудаас бүрдэнэ.

Нийгмийн хөгжлийн сан. Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг ажилтнуудын ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтанд тэтгэмж, тусламж олгох, ажлын үзүүлэлтээр урамшуулах, ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны удирдлага санхүүгийн жилийн эцсээр Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай гэж үзсэн.

26. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД

Сая төгрөгөөр	2018 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Дүрмийн сан	60,000	5,000

Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгийг илэрхийлнэ. Төв банкны тухай хуулинд Монгол Улсын Их Хурал нь Банкнаас тавьсан саналыг үндэслэн дүрмийн сангийн дүнг тогтоох эрх бүхий байгууллага юм гэж заасан. 2017 оын 9 дүгээр сарын 25-ны өдрийн Банкнаас Улсын Их Хуралд (УИХ) хүргүүлсэн саналд үндэслэн 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн УИХ-ын 70 дугаар тогтоолоор дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлэх зөвшөөрлийг Банкинд олгосон. 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн 10 дугаар тушаалын дагуу Банк нь эрсдэлийн сангийн буцаалтыг хурмтлагдсан алдагдлын данснаас тусгаарлан дүрмийн санг 55,000 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. 2018 оны 8 дугаар сарын 2-нд болон 2018 оны 12 дугаар сарын 24-нд Банк энэ ажлын хэрэгжилтийн талаар УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороонд (ЭЗБХ) тайлагнасан. ЭЗБХ нь 2019 оны 3 дугаар сарын 4-ний 11/2200 тоот албан бичгээр гүйлгээний хэрэгжилтийг баталгаажуулсан. Тодруулга 4, 37 болон 42-ыг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад нөөцийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Тодруулга	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	Дэлгэрэнгүй орлогоорх бодит цэнээр илэрхийлэх хөрөнгө оруулалтын үнэт цаасны дахин үнэлгээний сан	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	Үнэт металын дахин үнэлгээний сан	Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сан	Нийт
2017 оны 1 дүгээр сарын 1-нээр		3,367	-	11,895	1,140	-	16,402
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал		(2,726)	-	-	-	-	(2,726)
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн		690	-	-	-	-	690
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц рүү шилжүүлсэн	29	-	-	-	3,957	-	3,957
2017 оны 12 дугаар сарын 31-нээр, СТОУС 9-өөс өмнө		1,331	-	11,895	5,097	-	18,323
Хөрөнгө оруулалтын үнэт цаасуудыг борлуулахад бэлэн ангиллаас бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ангилалруу дахин ангилсан		(1,331)	1,331	-	-	-	-
2018 оны 1 дүгээр сарын 1-нээр (СТОУС 9-ийн дагуу)		-	1,331	11,895	5,097	-	18,323
Дэлгэрэнгүй орлогоорх бодит цэнээр илэрхийлэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал		-	(6,535)	-	-	-	(6,535)
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн		-	9,641	-	-	-	9,641
Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний илүүдэл		-	-	-	-	924,729	924,729
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний илүүдэл		-	-	18,436	-	-	18,436
Хуримтлагдсан алдагдлаас шилжүүлсэн	29, 32	-	-	-	171,246	-	171,246
2018 оны 12 дугаар сарын 31-нээр		-	4,437	30,331	176,343	924,729	1,135,840

Дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэх өрийн үнэт цаасны дахин үнэлгээний нөөц. Энэхүү сан нь дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэх өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц. Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн нэмэгдлийг өөрийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний санд бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 19-өөс харна уу.

Мөнгөжсөн алт, үнэт металын болон Гадаад валютын дахин үнэлгээний сан. Энэхүү сан нь мөнгөжсөн алт, үнэт металын ханшийн тэгшитгэлээс үүссэн мөн гадаад валютаарх мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийн ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус ашгийг бүртгэсэн. Тодруулга 29 болон 32-оос харна уу.

Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нөөц. Энэ санд Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 4 болон 15-аас харна уу.

27. ХҮҮГИЙН ОРЛОГО БА ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2018	2017
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого		
Өрийн үнэт цаас, ХӨ болон ДОБҮЦ	149,675	98,288
Буцаан худалдан авах гэрээ	44,609	30,912
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	44,571	11,612
Дотоодын банкуудад олгосон зээл	20,539	41,924
Засгийн газрын үнэт цаас	15,760	39,067
Дотоодын үнэт цаас	-	80,353
Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон нийт хүүгийн орлого	275,154	302,156
Хүүгийн зардал		
Төв банкны үнэт цаас	(453,313)	(186,720)
Гадаад өр төлбөр	(274,747)	(263,221)
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал	(55,295)	(65,100)
Засгийн газрын хөрөнгө	(31,174)	(2,299)
Дотоодын банкуудын хөрөнгө	(7,360)	(4,544)
Бусад хүүгийн зардал	(1,641)	(1,351)
Нийт хүүгийн зардал	(823,530)	(523,235)
Цэвэр хүүгийн зардал	(548,376)	(221,079)

СТОУС 9-рүү шилжсэнтэй холбоотойгоор дотоодын үнэт цааснууд (өрийн бичгийн авлага)-ын ангилал, хэмжилтийг ЗХҮТ шалгуурын дагуу хорогдуулсан өртгөөс орлого зарлагаарх бодит үнэ цэнэ ангилал руу өөрчлөгдсөн. Дотоодын үнэт цаасанд хамааралтай хүүгийн орлогыг “Орлого зарлага нь бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн ашиг” хэсэгт тайлагнасан. Дэлгэрэнгүйг Тодруулга 34-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. АЛТ БА ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ АШИГ

Сая төгрөгөөр	2018	2017
Мөнгөжсөн алт, үнэт металын арилжааны бодит ашиг	7,244	24,047
Алт ба үнэт металын арилжааны ашиг/(алдагдал)	538	(375)
Алт ба үнэт металын арилжааны бусад ашиг/(алдагдал)	10,925	(402)
Алт ба үнэт металын арилжааны ашиг	18,707	23,270

29. АЛТ БА ҮНЭТ МЕТАЛЫН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН АШИГ

Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашгийг илэрхийлэх ба тайлант жилд 164,176 сая төгрөгийн (2017: 3,957 сая) ашигтай байв.

30. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ АШИГ

Сая төгрөгөөр	2018	2017
Тайлант болон өмнөх үеийн своп хэлцлийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	125,556	673,299
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний ашиг	125,556	673,299

31. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ АЛДАГДАЛ

Сая төгрөгөөр	2018	2017
Гадаад валютын арилжааны ашиг	2,285	34
Үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит алдагдал	(118,447)	(148,737)
Гадаад валютын арилжааны алдагдал	(116,162)	(148,703)

32. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН АШИГ/ (АЛДАГДАЛ)

Сая төгрөгөөр	2018	2017
Гадаад валютын хөрвүүлгийн бодит ашиг	127,105	5,102
Гадаад валютын хөрвүүлгийн бодит бус ашиг/ (алдагдал)	7,070	(180,897)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/ (алдагдал)	134,175	(175,795)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. ӨРИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОРЛУУЛСНЫ АЛДАГДАЛ

Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт борлуулсны алдагдал нь хөрөнгийг дахин үнэлсэнээс үүссэн бодит ашиг, алдагдлын зөрүүг илэрхийлнэ. Тайлант үеийн эцэст өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт борлуулсны ашиг, алдагдлын зөрүү нь 9,641 сая төгрөг (2017: 690 сая төгрөг) байна.

34. ОРЛОГО ЗАРЛАГА НЬ БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДДЭГ САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН АШИГ

Сая төгрөгөөр	ОЗБҮЦ-ээр илэрхийлэх Үнэт цаас
2018 оны 1 дүгээр сарын 1-ний бодит үнэ цэнэ	689,723
Тухайн жилийн эргэн төлөлт	(118,064)
Тухайн жилийн орлого зарлагаар хүлээн зөвшөөрсөн ашиг	176,997
2018 оны 12 дугаар сарын 31-ний бодит үнэ цэнэ	748,656

35. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

Сая төгрөгөөр	2018	2017
Шимтгэлийн орлого	9,414	6,767
Дотоодын банкнаас авсан торгуулийн орлого	3,353	4,610
Дотоодын банкнаас авсан нэг удаагийн хүүгийн орлого	1,053	-
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	531	515
Үйл ажиллагааны бусад орлого	1,652	870
Нийт үйл ажиллагааны бусад орлого	16,003	12,762

Банк нь өөрийн тавьсан шаардлагын дагуу арилжааны банкуудаас заавал байлгах нөөцийг авч байршуулдаг. Заавал байлгах нөөцийн хэмжээг 14 хоногоор тооцдог (Тодруулга 23). 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх дотоодын банкуудын байршуулсан заавал байлгах нөөцөөс олсон хүүгийн орлогын дүн 3,353 сая төгрөг (2017 онд 4,610 сая төгрөг) байсан.

Шимтгэлийн орлогод их болон бага дүнтэй банк хоорондын гүйлгээ, картны болон гадаад валютаарх гүйлгээний шимтгэлийн орлого багтана. Үйл ажиллагааны бусад орлого гэдэгт мөнгөн тэмдэгт болон зоос борлуулсанаас олсон орлого орно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36. ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2018	2017
Цалингийн зардал	15,320	13,382
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	7,232	5,100
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдол	3,077	2,624
Алт тээвэрлэх хүргүүлэх зардал	2,353	2,438
Харилцаа холбоо, ашиглалтын зардал	1,650	1,697
Тээврийн болон албан томилолтын зардал	1,217	1,012
Харуул хамгаалалтын зардал	1,198	1,217
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал	1,154	11,140
Зар сурталчилгааны зардал	1,062	1,004
Системийн засварын зардал	943	778
Алтны санхүүжилттэй холбоотой зардал	894	614
Сургалтын зардал	541	265
Үндсэн хөрөнгийн засварын зардал	524	245
Хуулийн үйлчилгээний зардал	439	7,684
Үндсэн хөрөнгө дахин үнэлсэний гарз	411	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	4	16
Бусад зардал	3,706	2,311
Нийт захиргааны болон үйл ажиллагааны бусад зардал	41,725	51,527

ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк нь Монгол Улсын арилжааны банкуудын Активын Чанарын Үнэлгээг (АЧҮ) багтаасан Төлбөрийн Чадварын Үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн. АЧҮ-тэй холбоотой гарсан зардлыг 2017 онд гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардалд ангилсан. 2018 онд энэ зардал гараагүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Шийдэгдээгүй хэрэг. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банкны эсрэг зарга мэдүүлэх явдал гарах боломжтой. Швейцар болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг хоёр санхүүгийн байгууллагад холбогдох аккредитивийн гэрээтэй холбоотой шүүхийн маргаанд 2008 оноос хойш Банк хариуцагчаар татагдан, шүүх үйл ажиллагаа явагдсан. Эдгээр хэргүүд дээр Банк өөрийн байр сууриа баттай хамгаалж байсан ч, аккредитивийн гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргийг харгалзан 2009 онд нийт дүнгээр (хүүг оруулан) нь болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулсан. 2017 оны 7 дугаар сарын 25-нд Женевийн шүүхээр аккредитивийн гэрээтэй холбоотой маргаан Банкны талд шийдвэрлэгдсэн учир дээрх болзошгүй алдагдлын санг буцаан 2017 оны орлогын тайланд бүртгэсэн. Банк 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Монгобанкны Ерөнхийлөгчийн 10 дугаар тушаалын дагуу хуримтлагдсан алдагдалаасаа эрсдэлийн сангийн буцаалтыг тусгаарлан дүрмийн сангаа 55,000 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Тодруулга 4, 26 болон 42-ыг харна уу.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх заргуудаас өөр ямар нэгэн материаллаг гарз учруулах нэхэмжлэгчээр дуудагдсан шүүн таслах хуулийн хэргийн талаар удирдлагад мэдээлэл байхгүй байна. Иймд ямар нэг санг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг. Банк нь Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Гаргасан аккредитивүүд нь зээл болон аккредитивийн хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ, доорх мэдээлэлд анхаарал хандуулна уу. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн үүргийн хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм.

Гэвч ихэнх зээл нь зээлийн эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдлын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн үүргийн хэмжээнээс бага байна.

Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

	2018 оны 12 дугаар сарын	
Сая төгрөгөөр	31	2017 оны 12 дугаар сарын 31
Болзошгүй өр төлбөр		
Импортын аккредитивүүд	(90,565)	(155,868)
Төлбөрийн үүрэг хариуцлага		
Хятадын ардын банкинд өгөх ашиглаагүй зээлийн шугамын эх үүсвэр	(5,400,000)	(5,400,000)
Нийт зээлтэй холбоотой үүрэг хариуцлага	(5,490,565)	(5,555,868)

Импортын аккредитивүүд. Импортын аккредитив нь Монгол Улсын Засгийн газарт импортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Импортын аккредитивээр Банк Монгол Улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр. Банк нь 2011 оны 5 дугаар сард Хятадын Ардын банктай “Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлэлцээр”-ийн гэрээ байгуулсан ба гэрээг 2014 оны 8 дугаар сард болон 2017 оны 7 дугаар сард шинэчлэн баталсан. Төв банкууд уг мөнгийг хоёр улсын хоорондох худалдааг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах болон гэрээгээр тохирсон бусад зорилгоор ашиглах боломжтой.

Гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь хятадын юаниар төгрөг, монгол төгрөгөөр юань худалдан авах, худалдах хэлцлийг цаашид тодорхой хугацаанд хийх боломжтой. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа 12 сар хүртэл байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөө талаас авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 15,000 сая юань (2017: 15,000 сая юань), Хятадын Ардын банкны хувьд 5,400,000 сая төгрөгөөр (2017: 5,400,000 сая төгрөг) хязгаарлагдана.

Хөрөнгийг ашиглах банк хөрөнгийн хэмжээндээ гэрээнд заагдсан хүүг тооцон төлөх үүрэгтэй. Банк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь Шанхай-Интер банкны санал болгосон түвшин (“ШИБОР”) дээр 200 үндсэн оноо нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин Хятадын Ардын банк төгрөг ашигласан тохиолдолд, харгалзах ашиглалтын хугацаанд хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны зээлтэй холбоотой үүрэг хариуцлага нь ашиглагдсан дүн болох 12,000 сая юань буюу 4,628,760 сая төгрөг (2017: 12,000 сая юань буюу 4,458,960 сая төгрөг) ба ашиглагдаагүй дүн болох 3,000 сая юань буюу 1,157,190 сая төгрөг (2017: 3,000 сая юань буюу 1,114,740 сая төгрөг) байгаа нь Банкны хувьд цаашид хүлээн авч болох санхүүжилтийн үүргийг илэрхийлнэ.

Банкны удирдлага нь аккредитивийн гэрээ болон зээлийн шугамтай холбоотой өр төлбөрийн дүн нь материаллаг бус гэж үзсэн. Эдгээр ашиглагдаагүй зээлийн шугам болон аккредитив нь санхүүжилт хийгдэлгүйгээр хугацаа дуусах боломжтой. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийг зээлийн хөрвүүлгийн факторын аргаар үнэлсэн бөгөөд эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг бус дүнг илтгэнэ. Иймд Банк ямар нэг санг зээлийн үүрэг хариуцлагын хувьд болон санхүүгийн баталгааны хувьд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Нэг хяналтын дор байдаг, эсвэл нэг тал нөгөө талыг хянах эрхтэй буюу нөгөө талд санхүүгийн ба үйл ажиллагааны шийдвэр гаргахад нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг бол тэдгээрийг ерөнхийдөө холбоотой талууд гэж үздэг. Боломжит холбоотой талуудыг авч үзэхдээ тухайн харилцааны мөн чанарыг уг харилцааны хуулийн хэлбэрээс илүүтэй анхаарсан.

Банк 2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон данснуудын үлдэгдлийг тодруулгад тусгасан. Үүнд: Засгийн газар (Сангийн яам зэрэг удирдлагыг нь Улсын Их Хурал болон Засгийн газраас томилдог байгууллагуудыг оролцуулна), Сангийн яам бүрэн эзэмшиж УИХ-аас удирдлагыг томилдог дотоодын банк болох Төрийн банк, мөн засгийн газрын эзэмшилд байж ЗГ-аас удирдлагыг томилдог Хөгжлийн банк, ба ХДК хамаарна. ХДК нь бүрэн төрийн өмчит бөгөөд үйл ажиллагааных нь бүх шийдвэр Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгчийн тэргүүлдэг Үндэсний Хорооны долоон гишүүний саналаар батлагдах ёстой.

Банк НББОУС 24-т орсон өөрчлөлт болох “Төрийн байгууллагуудын тодруулгад тавигдах шаардлагыг хэсэгчлэн чөлөөлөх” заалтыг ашигласан. Иймд төрийн байгууллагуудтай хийсэн материаллаг бус гүйлгээнүүдийг тус санхүүгийн тайланд тусгаагүй болно.

2018 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна:

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	ХДК	Нийт
Хүүгийн орлого	15,760	5,960	6,845	545	29,110
Хүүгийн зардал	(31,174)	(51,480)	(27,390)	-	(110,044)
Хураамж шимтгэлийн орлого	210	1,248	-	-	1,458
Нийт	(15,204)	(44,272)	(20,545)	545	(79,476)

2018 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудын эзэмшиж буй дансны үлдэгдэл доорх байдалтай байна:

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	ХДК	Нийт
Засгийн газрын үнэт цаас	64,331	-	-	-	64,331
Хөгжлийн банкны үнэт цаас	-	-	44,305	-	44,305
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	7,718	-	-	7,718
Дотоодын банкуудад олгосон зээл	-	57,565	-	-	57,565
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	-	-	-	193,710	193,710
Дотоодын банкуудтай хийсэн своп хэлцэл	-	797	56,044	-	56,841
Төв банкны үнэт цаас	-	(668,087)	(558,933)	-	(1,227,020)
Дотоодын банкуудын хөрөнгө	-	(233,381)	(1,870)	-	(235,251)
Банк бус байгууллагуудын хөрөнгө	-	-	-	(98,092)	(98,092)
Засгийн газрын хөрөнгө	(1,130,107)	-	-	-	(1,130,107)
Total	(1,065,776)	(835,388)	(460,454)	95,618	(2,266,000)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2017 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна. Үүнд:

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	Нийт
Хүүгийн орлого	39,067	4,535	6,173	49,775
Хүүгийн зардал	(2,299)	(23,717)	-	(26,016)
Хураамж шимтгэлийн орлого	480	147	10	637
Засгийн газрын үнэт цаас борлуулсны олз	2,754	-	-	2,754
Нийт	40,002	(19,035)	6,183	27,150

2017 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудын эзэмшиж буй дансны үлдэгдэл доорх байдалтай байна:

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	ХДК	Нийт
Засгийн газрын үнэт цаас	163,027	-	-	-	163,027
Хөгжлийн банкны үнэт цаас	-	-	39,860	-	39,860
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	7,721	-	-	7,721
Дотоодын банкуудад олгосон зээл	-	91,444	-	-	91,444
Төв банкны үнэт цаас	-	(379,621)	-	-	(379,621)
Дотоодын банкуудын хөрөнгө	-	(217,597)	(21,620)	-	(239,217)
Банк бус байгууллагуудын хөрөнгө	-	-	-	(29,854)	(29,854)
Засгийн газрын хөрөнгө	(1,880,664)	-	-	-	(1,880,664)
Нийт	(1,717,637)	(498,053)	18,240	(29,854)	(2,227,304)

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Удирдлага холбоотой талуудын ажил гүйлгээнд анх хүлээн зөвшөөрөлтийн олз/гарз бүртгэх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Уг үнэлэмжийг хийхдээ удирдлага нь дээрх ажил гүйлгээ нь анхдагч зах зээлд хийгдсэн гэдгийг анхаарсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс харна уу.

Холбоотой талд олгосон зээлээс бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагаар хангагдаагүй болно. Холбоотой талуудын өглөг эсвэл авлагад зориулж ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

Импортын аккредитив гэрээ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 90,565 сая төгрөгийн (2017: 155,868 сая төгрөг) холбоотой талуудын импортын аккредитив гэрээний өр төлбөртэй байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 37-оос харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны үндсэн удирдлагын цалин болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толилуулав:

Сая төгрөгөөр	2018	2017
Цалин хөлс	790	922
Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл	106	123
Тэтгэмжүүд	96	194
Бусад олговор	10	150

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг ба эдгээрийг зөв тодорхойлж, хэмжиж, хянаж байснаар эрсдэлийг хязгаарлаж, бусад хяналтын бодлогоор удирддаг. Эрсдэлийг зохистой удирдах нь банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал инфляцыг зохистой түвшинд барих мөнгөний зөв бодлого явуулахад чухал ач холбогдолтой. Эрсдэлүүд нь банкны гол зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Ийм өндөр үр дагавартай эрсдэл Банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын хөрвүүлгээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Үүнээс гадна Банк нь зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн, үйл ажиллагааны, нэр хүндийн зэрэг эрсдэлд өртөж болно. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус ба газар, хэлтэс тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлогыг баримталдаг. Банк нь Монгол Улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй судалж байна.

Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн Удирдлагын бүтэц. Захирлуудын зөвлөл нь эрсдэлийг хянах ба энэ асуудлаар эцсийн хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банк доторх ерөнхий эрсдэлийн үйл явцыг нь хянах үүрэгтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны санхүүгийн эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн үндсэн нэгж бөгөөд Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын талаар зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны захирал, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал (2016: Зах зээлийн газрын захирал), Тайлан бүртгэлийн газрын захирал (2016: Төлбөр тооцоо бүртгэлийн газрын захирал) нар багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулдаг байна. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгасан байдаг. Мөн Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой харилцагч банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт тавих лимитийг улирал тутамд батлах ба энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга хэрэгсэл болдог.

Банкны санхүүгийн эрсдэлүүдээс гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал байдаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын үйл ажиллагаа нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдахад түлхүү чиглэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба, бусад холбогдох газруудад хяналт тавих, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэлийн бодлогын хэрэгжилт нийцтэй байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдаг. Санхүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор ашигласан аргуудыг доор толилуулав.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн удирдлагын алба ("ЭУА") нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих үүрэгтэй. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого боловсруулах, бенчмаркийн биелэлтийг хангуулах, лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн түүнчлэн ЭУА гадаад валютын улсын нөөцийн эрсдэл, бүртгэлийн системтэй холбоотой эрсдэлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг хямралын үед санхүүжүүлэх, богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай зохих хэмжээний гадаад валютын нөөцийг бүрэлдүүлэн бэлэн байлгахад оршино. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж буй гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Валютын зах зээлийн ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын гадаад валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх зэрэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянах нь гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь гадаад активыг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд нөөцийг байршуулах чөлөөтэй хөрвөх валютыг сонгох, валютуудын бэлэн байлгах хэмжээ, ямар бүтэцтэй байлгах, хөрвөх чадварын болон аюулгүй байлгах шаардлагуудад нийцүүлж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг ямар түвшинд барих, хүүгийн эрсдэлийг хянахын тулд хэрэгслүүдийн хугацаа ямар байх ёстой гэх мэт параметруудийг тогтоох зэрэг багтдаг.

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхой нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал нь хөрөнгийн багцын бүтэц буюу хөрөнгийн бүрдэл хэсэг, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын нөөцийн хязгаарлалт зэргийг удирдах, хянах үүрэгтэй.

Дотоод аудитын газар. Банк нь зорилгодоо хүрэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд Банкны үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод аудитын газар (ДАГ)-ын эрхэм зорилго юм. ДАГ нь Банкны мөрдөж буй бодлого, холбогдох горимуудын төлөвлөлт болон зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагад хяналт тавих санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн иж бүрэн байдал, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхийг шалгах үүрэг бүхий нэгж болно.

ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан дотоод боловсон хүчний нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж эрсдэлийн ерөнхий үнэлгээг тодорхойлж гүйцэтгэдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн цаг тухай бүр хийдэг. ДАГ нь Банкны 2018 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж хяналт шалгалтын ажлын дэс дарааллыг тогтоосон байна.

Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жинлэсэн онооны нийт дүнг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагааны хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДАГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДАГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

Зээлийн Эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, харилцагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм. Банкны харилцагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог бөгөөд энэ нь санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон тэнцлийн гадуурх зээлтэй холбоотой үүрэг хариуцлагыг үүсгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээр тусгагддаг. Санхүүгийн баталгаа, ашиглаагүй зээлийн шугам болон импортын аккредитивын хувьд хамгийн их өртөх магадлалтай эрсдэл нь үүрэг хариуцлагын дүнгийн хэмжээ байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулалтын хөрөнгийг зөв сонгох, хөрөнгө оруулалтын хөрөнгийн зээлийн чанарыг хянах, хөрөнгө оруулалтын хөрөнгө бүрийн оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаарлалт тавьж өгөх зэргээр удирдаж, хянана. Хөрөнгө оруулалтын төрлөөр нь зээлийн эрсдэлийн хэмжээнд тавих хязгаарлалтын хэмжээ болон оролцогч талыг сонгоход удирдлагаас байнга зөвшөөрөл авна. Эдгээр эрсдлүүдийг тойрох байдлаар хянадаг бөгөөд жил бүр эсвэл бүр ойр давтамжтайгаар хяналт тавина.

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэгслийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Банк нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллаг (Мүүдийс, Стандарт энд Пүүрс, Фитч)-ын гаргасан эсдэлийн үнэлгээг ашигладаг. Олон улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой бус байдлаас үүдэн Банк нь тодорхой талуудтай тэдний үнэлгээг авч үзэхгүйгээр худалдаа хийхээ бүрэн больсон бөгөөд оролцогч талын эрсдэлээ зохистойгоор авч үзээгүйгээс үүдэн системийн эрсдэлд хүргэх боломжтой байдаг.

Доорх хүснэгтэд хөндлөнгийн зээлийн үнэлгээг дефолтын магадлалтай хувьтай нь хамт үндсэн хэмжүүртэй нь тохируулж харуулсан:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн үнэлгээний тохирох үнэлгээ (Мүүдийс)	агентлагийн өгсөн Дефолтын магадлалын интервал
Онц сайн	AAA to A3	0,003% - 0,1%
Сайн	BAA1 to B3	0,2% - 4,6%
Хангалттай	CAA1 to CAA3	6,9% - 14,8%
Тусгайлан хянах	CA to C	21% - 38,4%
Дефолт	Дефолт	100%

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- *Онц сайн* – зээлийн чанар маш сайн, зээлийн эрсдэл бага;
- *Сайн* – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- *Хангалттай* – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- *Тусгайлан хянах* – ойроос хянах шаардлагатай, сайжруулах удирдлагыг баримтлах хэрэгслүүд;
- *Дефолт* – дефолт болсон хэрэгсэл.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг Ааа-с Аа3 болон Ааа зэрэглэлтэй Засгийн газар (эсвэл Төв банк)-ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас А3 болон түүнээс дээш зэрэглэл авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ);
2. Засгийн газрын үнэт цаас;
3. Хөгжлийн банкны үнэт цаас;
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл.

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах үүрэгтэй ба хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагааг цуцалдаг.

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Үнэлэгдээгүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхэд хэрэглэдэг мэдээлэл болон бусад мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг. Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашигладаггүй байна.

Хязгаарлалт. Цаашилбал гадаад валютын улсын нөөцийн хувьд бүх харилцагчдад зээлийн хязгаар тогтоосон бөгөөд энэ нь зээлдэгчийн зэрэглэл, хөрөнгө, бусад хүчин зүйлд үндэслэнэ. Монголбанкны Ерөнхийлөгч нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдлийн удирдлагын алба өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 9 болон 18)-ийн насжилтын шинжилгээг хийж зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг Захирлуудын Зөвлөлд танилцуулах бөгөөд тус хурал дээр хэлэлцэн үзэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Тодруулга 37-д толилуулснаар Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар эсвэл түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктай хийсэн гэрээтэй холбоотой (Тодруулга 37) ба ашиглаагүй хэмжээг тодорхойлно. Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 9-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон своп хэлэлцээрийн ашиглах хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг, хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 37).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХЗА)-ын хэмжилт. Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь ирээдүйн бэлэн мөнгөний дутагдалын одоогийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жигнэсэн тооцоолол (өгөгдсөн хугацаанд дефолт болох эрсдэлээр жигнэсэн зээлийн алдагдлын жигнэсэн дундаж) юм. ХЗА хэмжилт нь олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогддог. ХЗА-ын хэмжилтийг Банкны хэрэглэдэг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн тогтооно: Үүнд дефолт болох магадлал, Дефолт болсон үеийн дүн, Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ (дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ) болон дискаунтчилсан үр дүн орно.

Дефолт болсон үеийн дүн гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгч ирээдүйд дефолт болох үед хэдий хэмжээний өртэй байх таамаглал юм. Зээлтэй холбоотой үүрэг хариуцлагын дефолт болсон үеийн дүн-г Зээлийн хувиргалтын факторыг ашиглан тооцоолно. ЗХФ гэдэг нь үүрэг хариуцлага бүхий үнийн дүнг тодорхойлсон тайлант хугацаанд тайлан тэнцэлд тусгагдах үнийн дүнд хувиргах магадлалыг харуулсан коэффициент юм. Дефолт болох магадлал гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд дефолт болох магадлалыг тооцоолдог. дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ гэдэг нь дефолтоос болж үүссэн алдагдлын тооцоолол. Үүнийг төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэнэ. Ихэвчилэн дефолт болсон үеийн дүн-ийн хувиар илэрхийлдэг. ХЗА нь тайлант хугацааны эцэст дискаунтчилагдан одоогийн үнэ цэнээр бүртгэгддэг. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтын хувь тодорхойлогдоно.

Энэхүү санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагын тооцоолсон ХЗА нь захиргааны зорилгоор голдуу ашиглагддаг циклийнх туршид тооцоолох тооцооллоос илүүтэйгээр тухайн цаг хугацааны тооцоолол байна. Тооцоолол нь *ирээдүйг харсан мэдээллийг* авч үздэг бөгөөд үүнд ХЗА нь зээлийн эрсдэлд нөлөө үзүүлэх макро эдийн засгийн гол хувьсагчуудын магадлалаар жигнэсэн дүнд тусгагддаг.

ХЗА загварчлал нь Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай (ЗЧҮҮБ) санхүүгийн хөрөнгүүдээс ялгаагүй боловч дараах зүйлсээр ялгаатай: (а) гэрээний мөнгөн урсгалд суурилхаас илүүтэйгээр хөрөнгийн анх хүлээн зөвшөөрсөн үед төлөгдөж болох байсан мөнгөн урсгалд суурилж нийт дансны үнэ болон хямдруулалтын хүүгээ тооцолно, (б) ХЗА нь үргэлж ХЗА-ын ашиглалтын хугацааны турш байна. ЗЧҮҮБ хөрөнгө гэдэг нь анх хүлээн зөвшөөрөгдсөний дараа зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүд, жишээ нь: өнгөрсөн хугацаанд нийлүүлж авсан бизнесээс гарч ирсэн үнэ цэнийн бууралттай зээлүүд.

Дефолт болох магадлал хэмжих зорилгоор Банк нь доорхоос нэг буюу хэд хэдэн шалгуурыг хангасан нөхцөл байдлыг дефолт гэж тодорхойлдог:

- Зээлдэгч гэрээний төлбөрийг 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн;
- Зээлдэгч төлөхгүй байх магадлалын доорх шалгууруудыг хангасан:
 - Гэрээний үүрэгт хүү эсвэл үндсэн төлөлтийг төлөөгүй эсвэл хугацаа хэтэрсэн.
 - Дампуурлаа зарласан эсвэл хуулийн эрх хүлээн авсанаас үүдэн гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн эргэн төлөлтийг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх магадлалтай болсон.
 - Валютын ханшын хямрал.
 - Зээлийн гэрээний эргэн төлөлтийн нөхцөлд өөрчлөлт орсон эсвэл эрх бүхий байгууллагаас гэрээ байгуулсанаас үүдэн санхүүгийн үүрэг хариуцлагыг нь бууруулсан, үүнд гэрээний валютыг хүчээр өөрчилсөн (зээлдэгч эсвэл зээлдэгчийн эрх бүхий байгууллагаас) эсвэл анхны амлалтын зарим зүйлсийг хүчээр өөрчилсөн, жишээ нь индекс, дуусах хугацаа гэх мэт.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дефолт болох шалгуур үзүүлэлтүүдийг дараалсан 6 сарын турш хангаагүй үед хэрэгслийг дефолт гэж үзэхээ болино. Энэ 6 сарын хугацааг Монголбанкны хөрөнгийг ангилах, сан байгуулах, зээл гаргах журманд зааж өгсөн байна.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн томоохон өсөлт (SICR) байгаа эсэх үнэлгээг дангаар нь болон багцын түвшинд хийнэ. Санхүүгийн хөрөнгө 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн бол анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн томоохон өөрчлөлт байсан гэсэн таамаглалыг няцаагаагүй байна.

Банк нь хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгөд зээлийн доогуур эрсдэлийн үнэлгээг ашиглахгүй байхаар шийдсэн. Тиймээс хөрөнгө оруулалтын зэрэгтэй хөрөнгийг зээлийн эрсдэлийн томоохон өсөлт байгаа эсэхийг үнэлнэ.

Банк нь санхүүгийн хэрэгслийг доорх тооны болон чанарын үзүүлэлтүүдэдээс нэг буюу хэд хэдэн шалгууруудыг хангасан тохиолдолд SICR байна гэж үзнэ.

- 30 болон 90 хоногоор хугацаа хэтэрсэн.
- Эрсдэлийн ангилал нь “Анхаарал хандуулах” гэж ангилагдсан.
- Тайлант хугацааны дефолт болох магадлал коэффициентийг хөндлөнгийн үнэлгээнд суурилсан хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох магадлал коэффициенттэй харьцуулна. Хөндлөнгийн үнэлгээ 2 зэрэгээр буурахад зээлийн эрсдэлийн томоохон өсөлт гэж үзнэ.
- Тухайн бизнесийн үйл ажиллагаа явуулж буй газрын бизнес, санхүү, эдийн засгийн нөхцөлд томоохон сөрөг өөрчлөлт гарсан.
- Аж, ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн үзүүлэлтэд бодитоор эсвэл хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлт гарсан.
- Хэрэв дефолт шинж тэмдэг байгаа бол дансыг 3-р шатлалд хуваарилна.

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ХЗА-ын түвшин нь зээлдэгчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ихээхэн өссөн байгаа эсэхээс хамаарна. Энэ нь ХЗА хэмжилтийн 3-шатлалт загвар. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн үнэ цэнэ буураагүй мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд томоохон өсөлт гараагүй санхүүгийн хэрэгслийг 12 сарын ХЗА (1-р шатлал)-д үндэслэн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулна. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш SICR гарсан бол санхүүгийн хэрэгслийг 2-р шатлалруу шилжүүлэх боловч зээлийн үнэ цэнэ хараахан буураагүй бөгөөд эрсдэлийн санг ХЗА-ын хугацаанд үндэслэн байгуулна.

Хэрэв санхүүгийн хэрэгслийн зээлийн үнэ цэнэ буурсан бол санхүүгийн хэрэгслийг 3-р шатлалд шилжүүлэх бөгөөд эрсдэлийн санг ХЗА-ын хугацаанд үндэслэн байгуулна. Хөрөнгө 3-р шатлалд байснаар нийт дансны үнэд суурилсан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхөө зогсоох бөгөөд хүүгийн орлогоо тооцоолохдоо ХЗА-г хассан дансны үнэд хөрөнгийн үр ашигт хүүгийн аргыг ашиглана.

Хэрэв SICR шалгуур хангагдахаа больсон гэдэг нь нотлогдсон бол хэрэгслийг 1-р шатлалруу буцааж шилжүүлнэ. Чанарын үзүүлэлтээр үнийн дүнг 2-р шатлалруу шилжүүлсэн бол Банк энэ үзүүлэлт хэвээр байгаа эсвэл өөрчлөгдсөн эсэхэд хяналт тавина.

ХЗА нь дараах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн (дефолт болсон үеийн дүн, дефолт болох магадлал ба дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ) үржвэрүүдийн нийлбэр юм: Дээр тайлбарласны дагуу тодорхойлогдсон дефолт болсон үеийн дүн, дефолт болох магадлал ба дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ, мөн хэрэглүүрийн үр ашигт хүүний түвшинг ашиглан үнэлэх дискаунтчилсан дүнгийн нийлбэр юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХЗА нь хугацааны турш дахь эрсдэлийн параметруудийг (дефолт болсон үеийн дүн, дефолт болох магадлал, дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ) урьдчилан тооцоолсон хугацаа, хамтын сегмент тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид жил бүр тодорхойлогддог. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгүүд хамтдаа үржигдэж, оршин тогтнох магадлалыг тохируулна (жишээ нь зээл нь өмнөх саруудад төлөгдөөгүй эсвэл дефолт болсон). Энэ нь ирээдүйн ХЗА-г тооцоолж дараа нь тайлангийн огноо руу буцаан дискаунтчилан нэгтгэх юм. ХЗА-н тооцоололд ашигласан дискаунтын түвшин нь анхны үр ашигт хүүний түвшин буюу түүнтэй ойролцоо дүн байна.

Зээлийн эрсдэлийн параметрийг тооцоолох гол зарчмууд. Банк зээлийн эрсдэлийн параметр нь зайлшгүй эсвэл хөндлөнгийн мэдээлэлд үндэслэсэн үед түүхэн мэдээлэл хязгаарлагдмал учир тооцоололдоо хялбарчилсан аргыг ашиглана.

Дефолт болсон үеийн дүнг бүтээгдэхүүний төрлөөс хамааран өөр өөр байдаг хүлээгдэж буй төлбөрийн байдалд үндэслэн тодорхойлно. Дефолт болсон үеийн дүнг 12 сар эсвэл нийт хугацааны туршид бүтээгдэхүүнийг хорогдуулан зээлдэгчийн төлөх ёстой гэрээний эргэн төлөлтүүдэд үндэслэнэ. Зээлдэгчийн илүү төлөлтөөр залруулга хийнэ. Зээлийн шугаман бүтээгдэхүүний хувьд дефолт болсон үеийн дүнг одоогийн ашигласан байгаа дүн дээр дефолт болох үед ашиглаагүй дүнгийн хязгаарыг харгалзаж үзсэн “зээлийн хувиргалтын фактор”-ыг нэмж тооцоолдог.

Эдгээр таамаглал нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн хязгаарыг ашигласан байдал болон бусад зээлдэгчийн зан байдлын онцлогоос хамааран олон янз байна.

ХЗА-г тооцоолоход 2 төрлийн дефолт болох магадлал-г ашиглана: 12 сарын болон ашиглалтын хугацааны дефолт болох магадлал. 12 сарын дефолт болох магадлал-гийн үнэлгээг хийхэд хөндлөнгийн олон улсын байгууллагаас гаргасан хамгийн сүүлийн үеийн ашиглах боломжтой дефолтын мэдээллийг тохиромжтой бол ирээдүйг харсан мэдээлэлд тохируулж өөрчилсөн мэдээлэлд суурилна. Ашиглалтын хугацааны дефолт болох магадлал нь санхүүгийн хэрэгслийн үлдсэн ашиглалтын хугацаанд тохиолдох дефолтын магадлалыг тооцоолох ба энэ нь санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацааны турш дахь 12 сарын дефолт болох магадлал-ын нийлбэр юм.

Дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь дефолт болсон үнийн дүнд Банкны хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. Банк нь түүхэн мэдээлэл хязгаарлагдмал учир дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ тооцоололдоо Бэйзэлийн тоон нөлөөллийн судалгаа 3, Техникийн зааварчилгаа, дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ суурийн аргыг ашигладаг.

Санхүүгийн баталгаа болон зээлийн үүрэг хариуцлагын ХЗА-ын хэмжилт. Эдгээр санхүүгийн хэрэгслийн ХЗА-ын хэмжилтэд дээр тайлбарласан тэнцлийн дүнд ашигладагтай ижил үе шатуудыг багтаах ба дефолт болсон үеийн дүнгийн тооцооллоор ялгагдана. Дефолт болсон үеийн дүн бол зээлийн хувиргалтын фактор (“ЗХФ”) болон үүрэг хариуцлага хүлээсэн үнийн дүнгийн бүтээгдэхүүн юм.

Хөндлөнгийн үнэлгээнд суурилсан үнэлгээний зарчим. Ихэнх зээлд хөндлөнгийн зээлийн эрсдэлийн үнэлгээ байдаг бөгөөд тухайн үнэлгээний байгууллагын гаргасан дефолтын статистик мэдээллээс дефолт болох магадлал-н зээлийн эрсдэлийн параметрийг тооцоолоход ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээлийн хувьсагчууд болох хүү болон валютын хөрвүүлгээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд зөрүүг тодорхойлох явдал юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

Ханшийн эрсдэл. Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметруудээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага.
- Гадаад валютын нөөц болон гадаад валютаар илэрхийлэгдэх урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад эзлэх тухайн гадаад валютын хамгийн их байх хэмжээ.

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Захирлуудын зөвлөлөөс жил бүр баталдаг

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ийн ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтөд ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгийн үзүүлэх мэдрэмтгий байдлыг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр бууралтыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

Сая төгрөгөөр	2018.12.31-нээрх ашиг/ алдагдал болон өмч дахь нөлөө	2017.12.31-нээрх ашиг/ алдагдал болон өмч дахь нөлөө
Ам.доллар 10 хувиар чангарахад (2017: 10%)	130,316	169,719
Ам.доллар 10 хувиар сулрахад (2017: 10%)	(130,316)	(169,719)
Юань 10 хувиар чангарахад (2017: 10%)	(410,144)	(402,028)
Юань 10 хувиар сулрахад (2017: 10%)	410,144	402,028
Евро 10 хувиар чангарахад (2017: 10%)	(1,896)	363
Евро 10 хувиар сулрахад (2017: 10%)	1,896	(363)
ЗТЭ 10 хувиар чангарахад (2017: 10%)	(62,050)	(32,058)
ЗТЭ 10 хувиар сулрахад (2017: 10%)	62,050	32,058
Бусад валют 10 хувиар чангарахад (2017: 10%)	201,827	45,706
Бусад валют 10 хувиар сулрахад (2017: 10%)	(201,827)	(45,706)

Эрсдэлийн нөлөөний хэмжээ нь Банкны үндсэн үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг) болон ЗТЭ-д хамаарагдах мөнгөн нэгжээс бусад валютын хувьд тооцоологдсон болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2018 оны 12 дугаар сарын 31-нээр Банкны мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц оруулж буй валют болон ЗТЭ-ийг харуулж байна.

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Бусад	Нийт
Бэлэн мөнгө	49	66,292	29	722	-	4,935	72,027
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	1,763,160	641,367	131,186	146,229	186,297	2,868,239
Дотоодын банкуудад олгосон зээл	440,765	809	-	719	-	-	442,293
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,421,706	2,141,713	113,770	-	-	-	4,677,189
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	5,201	-	-	6,533	-	-	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	322,054	2,141,558	-	-	-	-	2,463,612
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	2,035,750	2,035,750
Засгийн газрын үнэт цаас	64,331	-	-	-	-	-	64,331
Бусад санхүүгийн хөрөнгө	829,941	-	-	-	-	-	829,941
Нийт санхүүгийн хөрөнгө	4,084,047	6,113,532	755,166	139,160	146,229	2,226,982	13,465,116
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(968,618)	-	-	-	-	-	(968,618)
Төв банкны үнэт цаас	(5,005,515)	-	-	-	-	-	(5,005,515)
Засгийн газрын хөрөнгө	(208,069)	(295,985)	-	(19,737)	(588,042)	(18,274)	(1,130,107)
Дотоодын банкуудын хөрөнгө	(1,728,521)	(2,028,829)	(129,414)	(138,385)	-	(190,436)	(4,215,585)
Гадаад өр төлбөр	(85)	(166)	(4,727,194)	-	(178,685)	-	(4,906,130)
Бусад санхүүгийн өр төлбөр	(102,688)	(12,078)	-	-	-	-	(114,766)
Нийт санхүүгийн өр төлбөр	(8,013,496)	(2,337,058)	(4,856,608)	(158,122)	(766,727)	(208,710)	(16,340,721)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,304,263	(2,473,316)	-	-	-	-	(169,053)
Цэвэр позиц	(1,625,186)	1,303,158	(4,101,442)	(18,962)	(620,498)	2,018,272	(3,044,658)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2017 оны 12 дугаар сарын 31-нээр Банкны мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц оруулж буй валют болон ЗТЭ-ийг харуулж байна.

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Бусад	Нийт
Бэлэн мөнгө	43	70,588	28	1,512	-	4,724	76,895
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	1,848,552	600,306	194,447	145,301	347,645	3,136,251
Дотоодын банкуудад олгосон зээл	857,625	800	-	1,933	-	-	860,358
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	2,143,112	811,416	-	-	-	-	2,954,528
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	234,536	2,849,451	-	-	-	-	3,083,987
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	429,440	429,440
Засгийн газрын үнэт цаас	163,027	-	-	-	-	-	163,027
Бусад санхүүгийн хөрөнгө	690,942	-	-	-	-	-	690,942
Нийт санхүүгийн хөрөнгө	4,089,285	5,580,807	600,334	197,892	145,301	781,809	11,395,428
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(906,396)	-	-	-	-	-	(906,396)
Төв банкны үнэт цаас	(3,444,401)	-	-	-	-	-	(3,444,401)
Засгийн газрын хөрөнгө	(1,040,687)	(500,590)	(15,328)	(18,577)	(298,084)	(7,398)	(1,880,664)
Дотоодын хөрөнгө	(1,554,805)	(1,032,408)	(36,047)	(175,685)	-	(317,353)	(3,116,298)
Гадаад өр төлбөр	(769)	(152)	(4,569,234)	-	(167,797)	-	(4,737,952)
Нийт санхүүгийн өр төлбөр	(6,977,913)	(1,544,242)	(4,620,609)	(194,262)	(465,881)	(324,751)	(14,127,658)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,083,637	(2,339,377)	-	-	-	-	(255,740)
Цэвэр позиц	(804,991)	1,697,188	(4,020,275)	3,630	(320,580)	457,058	(2,987,970)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хүүгийн түвшний эрсдэл. Хүүгийн түвшний хэлбэлзлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг хүүгийн түвшний эрсдэл гэнэ. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдэлийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр буруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөн шинжилгээний аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5 хувиас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

Дараах хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн байдлыг харуулжээ. Энэ хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна:

	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт хүүтэй	Хүүгийн мэдрэмтгий байдалгүй	Нийт
<i>Сая төгрөгөөр</i>							
2018.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	5,673,424	2,044,547	433,393	4,591,546	12,742,910	921,863	13,664,773
Нийт санхүүгийн өр төлбөр	(9,232,125)	(454,383)	(4,883,667)	(894,174)	(15,464,349)	(1,245,082)	(16,709,431)
2018.12.31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг	(3,558,701)	1,590,164	(4,450,274)	3,697,372	(2,721,439)	(323,219)	(3,044,658)
2017.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	6,822,513	239,719	195,558	4,155,154	11,412,944	38,216	11,451,160
Нийт санхүүгийн өр төлбөр	(8,403,956)	(1,328,070)	(3,217,840)	(257,022)	(13,206,888)	(1,232,242)	(14,439,130)
2017.12.31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг	(1,581,443)	(1,088,351)	(3,022,282)	3,898,132	(1,793,944)	(1,194,026)	(2,987,970)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хөрөнгө болон өр төлбөрийн хүүг хувьсах хувь хэмжээгээр хуримтлуулдаг. ЗТЭ (Тодруулга 8), ЗТЭ-ийн хуваарилалт, банк болон Хятадын Ардын банкнаас авсан зээлүүд (Тодруулга 21). Хэрэв 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусад бүх хувьсагчийн хувьд тогтмол хүүгийн түвшин 200 суурь нэгжээр доогуур байвал тухайн жилийн алдагдлын хэмжээ (Хятадын ардын банкнаас авсан хувьсагч хүүтэй зээлийн хүүгийн өр төлбөр бага байсны үр дүнд) 13,471 сая төгрөг (2017 онд 8,882 сая төгрөг)-өөр бага байх байсан. Хэрэв хүүгийн түвшин бусад бүх хувьсагчийн хувьд тогтмол боловч 200 суурь нэгжээр илүү байвал хувьсагч хүүтэй зээлийн хүүгийн өр төлбөр их байсны үр дүнд тухайн жилийн алдагдлын хэмжээ 13,471 сая төгрөг (2017 онд 8,882 сая төгрөг)-өөр илүү байх байсан.

Банкны актив хөрөнгө болон өр төлбөрийн дийлэнх хэсэг нь тогтмол хүүтэй эсвэл хүүгүй бөгөөд Банк нь хувьсагч хүүтэй материаллаг актив хөрөнгө болон өр төлбөр байхгүй тул 2018 оны хүүгийн түвшний эрсдэлийн нөлөөлөл их биш гэж Банкны удирдлагууд үзсэн. Банк өөрийн санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинг хянаж байдаг. Доорх хүснэгтэд харгалзах тайлант өдрөөрх хүүгийн түвшинг удирдлагын тайланд үндэслэн нэгтгэсэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цааснуудын хувьд хүүгийн түвшин нь тайлант өдрийн байдлаар дуусгавар өдөр хүртэлх хугацааны өгөөжийн зах зээл дээрх түвшинг илэрхийлнэ.

Жилийн хүү	2018					2017				
	Төгрөг	Ам. доллар	Евро	Юань	Бусад	Төгрөг	Ам. доллар	Евро	Юань	Бусад
Хөрөнгө										
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	-	2.52%	-	3.09%	0.68%	-	1.48%	-	2.92%	0.19%
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	-	1.91%	-	3.57%	-	-	1.20%	-	-	-
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	10.25%	3.04%	-	-	-	10.00%	1.46%	-	-	-
Засгийн газрын үнэт цаас	1.00%	-	-	-	-	5.97%	-	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	4.59%	0.75%	1.25%	-	-	6.98%	3.98%	1.25%	-	-
Өр төлбөр										
Төв банкны үнэт цаас	11.46%	-	-	-	-	11.00%	-	-	-	-
Засгийн газрын хөрөнгө	-	2.17%	0.75%	-	1.00%	-	2.17%	0.75%	-	1.00%
Дотоодын банкуудын хөрөнгө	9.00%	-	-	-	-	9.00%	-	-	-	-
Гадаад өр төлбөр	-	-	-	5.51%	-	-	-	-	6.39%	-

Хүснэгт дэх “-” тэмдэг нь Банк харгалзах валютаар, харгалзах хөрөнгө, өр төлбөргүйг илтгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Газар зүйн эрсдэлийн төвлөрөл. 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харуулав:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	72,027	-	-	-	72,027
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	2,079,403	146,229	642,607	2,868,239
Дотоодын банкуудад олгосон зээл	442,293	-	-	-	442,293
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,421,789	2,141,713	-	113,687	4,677,189
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	5,201	6,533	-	-	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	322,054	2,141,558	-	-	2,463,612
Алт ба үнэт металл	-	2,035,750	-	-	2,035,750
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	199,657	-	-	-	199,657
Засгийн газрын үнэт цаас	64,331	-	-	-	64,331
Бусад санхүүгийн хөрөнгө	829,941	-	-	-	829,941
Total financial assets	4,357,293	8,404,957	146,229	756,294	13,664,773
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(968,618)	-	-	-	(968,618)
Төв банкны үнэт цаас	(5,005,515)	-	-	-	(5,005,515)
Засгийн газрын хөрөнгө	(1,130,107)	-	-	-	(1,130,107)
Банкуудын хөрөнгө	(4,215,585)	-	-	-	(4,215,585)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(368,710)	-	-	-	(368,710)
Гадаад өр төлбөр	-	(251)	(178,685)	(4,727,194)	(4,906,130)
Бусад санхүүгийн өр төлбөр	(114,766)	-	-	-	(114,766)
Нийт санхүүгийн өр төлбөр	(11,803,301)	(251)	(178,685)	(4,727,194)	(16,709,431)
2018.12.31-нээрх цэвэр позиц	(7,446,008)	8,404,706	(32,456)	(3,970,900)	(3,044,658)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 37)	(90,565)	-	-	(5,400,000)	(5,490,565)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харуулав:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	76,895	-	-	-	76,895
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	2,388,688	145,301	602,262	3,136,251
Дотоодын банкуудад олгосон зээл	860,358	-	-	-	860,358
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	2,143,112	811,416	-	-	2,954,528
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	234,536	2,849,451	-	-	3,083,987
Алт ба үнэт металл	-	429,440	-	-	429,440
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	55,732	-	-	-	55,732
Засгийн газрын үнэт цаас	163,027	-	-	-	163,027
Бусад санхүүгийн хөрөнгө	690,942	-	-	-	690,942
Нийт санхүүгийн хөрөнгө	4,224,602	6,478,995	145,301	602,262	11,451,160
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(906,396)	-	-	-	(906,396)
Төв банкны үнэт цаас	(3,444,401)	-	-	-	(3,444,401)
Засгийн газрын хөрөнгө	(1,880,664)	-	-	-	(1,880,664)
Банкуудын хөрөнгө	(3,116,298)	-	-	-	(3,116,298)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(311,472)	-	-	-	(311,472)
Гадаад өр төлбөр	-	(921)	(167,797)	(4,569,234)	(4,737,952)
Бусад санхүүгийн өр төлбөр	(41,947)	-	-	-	(41,947)
Нийт санхүүгийн өр төлбөр	(9,701,178)	(921)	(167,797)	(4,569,234)	(14,439,130)
2017.12.31-нээрх цэвэр позиц	(5,476,576)	6,478,074	(22,496)	(3,966,972)	(2,987,970)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 37)	(155,868)	-	-	(5,400,000)	(5,555,868)

Бусад эрсдэлийн төвлөрөл. Банкны удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээллийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавьдаг. 2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкинд ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл Санхүүгийн хэвийн болон хүнд нөхцөл байдалд өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл нь Банкинд учирдаг хамгийн гол эрсдэлүүдийн нэг юм. Импортоос ихээхэн хамааралтай, Засгийн газрын гадаад өрийг байнга төлж байх шаардлагатай, дотоодын зах зээл дээрх валютын эрэлт, нийлүүлэлт байнга хэлбэлзэж байдаг нөхцөл байдлын үед төлбөрийн чадвар нь гадаад валютын нөөцийн удирдлагын авч үзэх ёстой чухал асуудал юм. Төлбөрийн чадварыг удирдахын тулд Банк гадаад валютын нөөцийн багцыг хоёр дэд багцад хуваадаг. Үүнд:

- Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл төлбөрийн чадварын багц орно): Энэ багцыг зээлийн өр төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой болгох зорилгоор ашигладаг. Уг багц бэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас бүрдэнэ. Энэхүү багц нь мөн хугацаат хадгаламжид, өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий мөнгөний зах зээлийн хэрэгсэлд долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаасанд болон мөнгөжсөн алтанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын багц: Энэ багц нь дунд хугацааны, өндөр төлбөрийн чадвар бүхий Засгийн газрын бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийгддэг байна.

Хөрөнгө оруулалтын хороо гадаад валютын багцын хязгаарыг санал болгодог. Төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулахын тулд Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг дагаж мөрддөг:

- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө болгон харилцах данс болон валютаар илэрхийлэгдсэн бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө болгон 6 сар хүртэлх хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулах.

Гадаад арилжааны алдагдлын хязгаар 400,000 ам.доллар, арилжааны нэгжийн хязгаар 100,000 ам.доллар байх бөгөөд нэг удаагийн арилжааны хязгаар 50,000 ам.доллар байна.

Дараах хүснэгтэд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг гэрээнд заасан дуусах хугацаагаар нь харуулсан. Дуусгавар хугацааны тайланд тусгасан дүнгүүд нь санхүүгийн түрээсийн баталгаа (ирээдүйн санхүүгийн төлбөрийг хасахаас өмнөх), нийт зээлийн үүрэг, нийт санхүүгийн түрээсийн үүрэг зэргийг хамруулсан гэрээнд заасан, хямдруулаагүй мөнгөн гүйлгээ болно. Санхүүгийн байдлын тайланд дүнгүүд нь хямдруулсан мөнгөн гүйлгээн дээр үндэслэсэн байх тул хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна. Дуусах хугацааны шинжилгээний зорилгоор үүсмэл санхүүгийн хөрөнгийг холимог санхүүгийн хэрэгслүүдээс салгахгүй.

Аккредитивийг дэмжихэд шаардагдах төлбөрийн чадварын хэмжээ нь дуусах хугацааны шинжилгээнд харуулсан өр төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага юм. Учир нь Банк гуравдагч талыг эдгээр гэрээн дээр үндэслэн хөрөнгө татна гэж үздэггүй байна. Доорх дуусгавар хугацааны шинжилгээний хүснэгт дэх одоогийн нийт гэрээнд үндэслэсэн өр төлбөрийн хэмжээ нь ирээдүйд шаардлагатай мөнгөний хэмжээг илэрхийлэхгүй. Учир нь ихэнх энэ төрлийн гэрээт өр төлбөр нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өр төлбөрийн дүн тодорхой заагаагүй тохиолдолд тодруулсан дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлын үндсэн дээр тодорхойлно. Гадаад валютаар хийсэн төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшаар шилжүүлэн тооцно.

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	968,618	-	-	-	968,618
Төв банкны үнэт цаас	4,366,535	447,019	250,002	-	5,063,556
Засгийн газрын хөрөнгө	507,627	1,655	1,572	623,203	1,134,057
Дотоодын банкуудын хөрөнгө	4,215,722	-	-	-	4,215,722
Гадаад өр төлбөр	178,936	-	4,788,532	-	4,967,468
Бусад санхүүгийн өр төлбөр	114,766	-	-	-	114,766
<i>Нийт төлөгдсөн своп болон форвард:</i>					
- орох урсгал	(37,343)	(265,425)	(167,721)	(1,833,774)	(2,304,263)
- гарах урсгал	39,655	288,581	185,903	1,959,177	2,473,316
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
-ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдагүй санхүүжилт	5,400,000	-	-	-	5,400,000
-Бусад болзошгүй өр төлбөр	90,565	-	-	-	90,565
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	15,845,081	471,830	5,058,288	748,606	22,123,805

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

<i>Сая төгрөгөөр</i>	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	906,396	-	-	-	906,396
Төв банкны үнэт цаас	3,447,800	-	-	-	3,447,800
Засгийн газрын хөрөнгө	1,848,165	1,174	1,190	33,033	1,883,562
Дотоодын банкуудын хөрөнгө	3,116,327	-	-	-	3,116,327
Гадаад өр төлбөр	278,992	2,283,298	2,313,493	-	4,875,783
Бусад санхүүгийн өр төлбөр	41,947	-	-	-	41,947
<i>Нийт төлөгдсөн своп болон форвард:</i>					
- орох урсгал	-	(205,433)	(336,648)	(1,553,136)	(2,095,217)
- гарах урсгал	-	222,890	391,211	1,736,856	2,350,957
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
-ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдагүй санхүүжилт	5,400,000	-	-	-	5,400,000
-Бусад болзошгүй өр төлбөр	155,868	-	-	-	155,868
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд					
	15,195,495	2,301,929	2,369,246	216,753	20,083,423

Дотоодын банкуудын хадгаламж болон засгийн газрын байгууллагуудад өгөх өр төлбөрүүдийн ихэнх хэсэг нь Банкны үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр болон үндсэн хадгаламжийг илэрхийлж байна. Үүнтэй адилаар Банк хэдийгээр гэрээний дагуу төлбөр хийх хугацааг хойшлуулах эрхгүй боловч гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, мөн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг илэрхийлж байна.

Банк нь хөрвөх чадварыг удирдах өр төлбөрүүдийн гэрээгээрх хямдруулаагүй дуусгавар хугацаанд суурилдаг шинжилгээг ашигладаггүй. Үүний оронд Банк санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнийн тооцоолсон дуусгавар хугацааг болон үүнээс үүдэх тооцоолсон хөрвөх чадварын заагийг хянадаг.

Санхүүгийн өр төлбөрийн тооцоолсон дуусгавар хугацаа нь банкинд байршуулсан их хэмжээний хадгаламж (ихэвчлэн төрийн байгууллагууд болон дотоодын банкуудаас байршуулсан) болон гүйлгээн дэх бэлэн мөнгөнөөс шалтгаалаад гэрээний дуусгавар хугацаанаасаа өөр байж болно. Санхүүгийн өр төлбөрийг төлөх шаардлага гарахад борлуулахад бэлэн байдаг санхүүгийн хөрөнгө нь борлуулагдахаар хүлээгдэж буй өдөртөө үндэслэн дуусгавар хугацааны шинжилгээнд хамрагдана. Үнэ цэнийн бууралттай зээл нь ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалынхаа цаг хугацаанд тулгуурлах ба үнэ цэнийн бууралтын сангийн дүнгээр дансны үнийг цэвэршүүлсэн дүнгээр илэрхийлэгддэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэгслүүдийн дуусгавар хугацааны шинжилгээг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	72,027	-	-	-	72,027
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,477,144	1,391,095	-	-	2,868,239
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	569,034	535,555	102,176	3,470,424	4,677,189
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	11,734	-	-	-	11,734
Буцаан худалдан авах гэрээ	2,396,315	10,111	-	57,186	2,463,612
Алт ба үнэт металл	2,035,750	-	-	-	2,035,750
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	-	771	198,886	199,657
Засгийн газрын үнэт цаас	699	-	-	63,632	64,331
Дотоодын банкуудад олгосон зээл	53	86,207	180,924	175,109	442,293
Бусад санхүүгийн хөрөнгө	10	20,500	85,000	724,431	829,941
Нийт санхүүгийн хөрөнгө	6,562,766	2,043,468	368,871	4,689,668	13,664,773
Өр төлбөр					
